Энэхүү судалгаа нь орчуулгын судалгааны салбарт судлаачдын авч үзсэн онолтой уялдуулан холбогдох асуудлууд англи хэл дээрх улс төрийн ярианы, бичгийн бүтээлийг орчуулах арга техник, эргээд орчуулгад улс төрийн дискурсыг ойлгох тухай авч үзсэн. Улс төрийн бичвэрийг орчуулах талаар нарийн жор, тогтсон дэг гэж байхгүй болохыг онцлох нь зүйтэй бөгөөд орчуулгыг хийхдээ соёл, түүх, улс төрийн нөхцөл байдал, тэдгээрийн ач холбогдлыг ойлгож байгаа эсэх нь чухал. Олон төрлийн эх бичвэрийн хувьд “Орчуулга” гэх нэршлийн талаарх судалгаа ихэд хийгддэг ч нийгмийн олон судлаачдын үзэж буйгаар практик ач холбогдол, төрөл зэргээс хамаарч харилцан адилгүй ач холбогдолтой байх нь бий. Ерөнхий мэдлэгийн хүрээнд дискурст ашиглагдах холбоо хамаарал, улс төрийн дискурс, орчуулгын хоорондын харилцааг энэхүү өгүүллээр чухалчлан авч үзлээ. Шинжлэх ухааны судалгаанд орчуулга, хэлмэрчлэхүй, хөрвүүлгийн асуудал нь орчуулагчийн бүтээлч оюуны үйл ажиллагаа, тухайн эх бүтээлийн өөр хэл дээр буусан шууд тусгал болдог тул аливаа мэдээлэлд орчуулгын алдаа мадаг гаргахгүй байх нь амин чухал байдаг тул үүнийг дискурсын судалгаатай уяж өгсөн болно. Иймд орчуулга хийнэ гэдэг нь тэр дундаа улс төрийн текст бичвэр, илтгэл, ярилцлага, хэлэлцүүлэг зэргийг орчуулахдаа хоёр хэлийг сайн мэдээд зогсохгүй, тухайн үндэстэн, ард түмний соёл, сэтгэлгээний онцлогоор зогсолтгүй олон салбарын мэдлэг мэдээлэлтэй, эх агуулгаас хөрвүүлэхдээ хам сэдвийн онцлогоос хамааран орчуулах арга техникт суралцах, хэрхэн эх мэдээллийг анх тавьсан зохиогчийн зорилготой уяж бусад хэл рүү хөрвүүлэх вэ гэсэн асуудлыг хөнддөг тул энэ нь зөвхөн хэлзүйн асуудал төдийгүй, орчуулагчийн мэдлэг туршлага, тухайн зохиогчийн санаа, зоригийг бүрэн ойлгосон эсэхийг илтгэн харуулах чухал үйл явц юм.



Монгол эх сурвалж, материал

1. Батчулуун Д.(2016). Хэлшинжлэлийн удиртгал. Улаанбаатар.
2. Бадамдорж Д.(1997). Орчин цагийн монгол хэлний утга судлал. Улаанбаатар.
3. Б.Бирваа, (2009) Монгол хэл минь хэл биш сэг болох нь ээ хэмээх нийтлэл [3]-ээс түүж бичлээ. Үндэсний шуудан 2009.04.14 № 089
4. Баярсайхан Ё (1989) Монгол хэлний реалийн орчуулгын зарим асуудал (Орчуулах эрдэм №6).
5. Л. Бямбасүрэн (ХИС) Эдийн засгийн дискурс дэх метафор (Монгол,англи хэлний жишээгээр). 2012. 5 дугаар сар

6. Гүрбазар Р. (1996) Орчуулгын онол дадлагын үндэс. Улаанбаатар.
7. Дамдинсүрэн Ц., Лувсандэндэв А. (1983) Орос монгол толь. Улаанбаатар.
8. Дашдаваа Д. (1972). Үндэсний онцлог бүхий үг, хэлц үгийг орчуулах нь. Орчуулах эрдэм №1.
9. Хонгорзул. Т. (2012) Дискурсын үндсэн ойлголтууд
10. Д.Туул, Г.Туяа, Ц.Тунгалаг. (2012) Орчуулгын онол, дадлагын үндэс. Улаанбаатар.
11. Туяа Г. (2004) Хэл соёлын шүтэлцээг цагийн утгаар илэрхийлэх нь. Улаанбаатар, 2004.х.84
12. Туяа Г. (2004) Хэл соёлын шүтэлцээг цагийн утгаар илэрхийлэх нь. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.
13. Туул Д., Туяа Г., Тунгалаг Ц. (2001) Орчуулгын онолын дадлагын үндэс. Улаанбаатар.
14. Томтогтох Г.(2013) Монгол хэлний үндэсний онцлог үгийн үгийн сан-утгазүйн судалгаа.
15. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D) зэрэг горилсон бүтээл. (2012). Хэл шинжлэлийн удиртгал. Улаанбаатар.
- 16. Гадаад эх сурвалжаас**
17. Álvarez, Román and Vidal, M. Carmen-África (eds.). (1996.) Translation, Power, Subversion.. Clevedon: Multilingual Matters..
18. Baker, Mona. (2006) Translation and Conflict. A Narrative Account. London and New York: Routledge.
19. Bánhegyi, Mátyás.. (2009). The translator's ideology and the reproduction of superstructure.. Working Papers in Language Pedagogy 3: 28–56..
20. Bell, Allan. (1998). The Discourse Structure of News Stories. In Bell, Allan and Garrett, Peter (eds.), Approaches to Media Discourse, 64–104. Oxford: Blackwell.
21. Fairclough, N. (1995). Critical Discourse Analysis-The Critical Study of Language. London: Longman.
22. Bărbuleț, G. (1918). Discourse Analysis with Michel Foucault & Critical Discourse Analysis with Norman Fairclough. Universitatea, Alba Iulia.
23. Komissarov, Vilen N. (2004). On Linguistic Basis of Creativity in Translation. - La Traduzione.
24. Lyngbak Fogh Holst, June. (2010). Creativity in translation: a study of various source and target texts. PhD thesis. http://pure.au.dk/portal/files/11416/Creativity_in_Translation.pdf
25. Pym, Anthony. (1992). Translation and Text Transfer – An Essay on the Principles of Intercultural Communication. Frankfurt am Main: Peter Lang.
26. Savory, Th. H. (1968). The Art of Translation. - London: Jonathan Cape, Thirty Bedford Square.
27. Schäffner, Christina. (2004) Political Discourse Analysis from the point of view of Translation Studies., Journal of Language and Politics. 3(1): 117–150.
28. Soltani, S. A. A. (2004). Discourse Analysis as a Theory and Method
29. Tang, Jun. (2007) Encounters with Cross-cultural Conflicts in Translation. In Salama-Carr, Myriam (ed.), Translating and Interpreting Conflict, 135–147.. Amsterdam and New York: Rodopi.
30. Ubozhenko, I. V. (2012). The Theoretical Basis of a Linguo-Didactic Model of Developing Creativity in Translation: “Push-Word” Methodology, Prospects for the Neurolinguistic Approach. In: Abstracts of 4th UK Cognitive Linguistics Conference (London: King’s College).



ГАДААД ХЭЛ ЗААХ АРГАЗҮЙ



МОНГОЛ ХЭЛНЭЭС АНГЛИ ХЭЛНЭЭ ОРЧУУЛАХ “ОРЧИЛ” ХЭМЭЭХ НЭГЭН ЗАГВАРЫГ АШИГЛАХ НЬ

Т. Мягмарсүрэн⁶⁹

Abstract: *When starting translation classes at school, students majoring in English language encounter numerous problems. Those can be a/ putting their native and foreign language knowledge in real practice; b/ identifying their positive and negative factors influencing translation practice; c/ to finding out their own translation techniques etc. Students, learning translation theory, methods and techniques first time, have to be supported and mentored by their teachers who will provide good systematic knowledge on doing translation and instruct them in a good way. Based on my own teaching experiences and practice on Mongolian to English translation which is one of the major subjects for English majoring students, I developed a model called “Cycle” and started testing it at class.*

Түлхүүр үг: орчуулах онол арга зүй, системтэй мэдлэг, заах арга

Сэдвийн зорилго: Монгол хэлнээс англи хэлнээ орчуулж сурч буй оюутнуудад орчуулгын онол арга зүйн системтэй ойлголт, мэдлэг олгох, оюутныг хөгжүүлэх, бие даан суралцах чадварыг нэмэгдүүлэхэд оршино.

Оршил

Англи хэлний орчуулагч мэргэжлээр суралцаж буй оюутнууд сургалтын хөтөлбөрийн дагуу мэргэжлийн хичээлийн хүрээнд монгол хэлнээс англи хэл, англи хэлнээс монгол хэлнээ орчуулах дадлага хичээлийг судалдаг. Хичээлийн явцад оюутнууд эх болон гадаад хэлний үгийн нөөц, хэлзүйн мэдлэг, найруулах чадвар, тухайн орчуулж буй мэдээллийн талаарх ерөнхий ойлголт, мэдлэг гэх мэт олон бэрхшээлтэй тулгардаг тул багш нэг бүрчлэн тулж ажиллах зайлшгүй шаардлагатай болдог. Гэвч оюутан бүрийн сурах арга барил, мэдээлэл хүлээн авах харилцан адилгүй байдал, хичээл зүтгэл, хэлний суурь мэдлэг зэрэг янз бүрийн шалтгаануудын улмаас багш нар оюутан бүрд нийцсэн арга барилаар тааруулж ажиллаж байдаг ч ингэж суралцагчдаа зүглүүлж чиглүүлэх нь тийм ч амар биш. Хамгийн наад зах нь орчуулах дадлага хичээлийн онцлогийн улмаас нэг зүйлийг олон дахин давтан тайлбарлах нь зарим оюутанд, багшид ч бэрхшээл болох үе бий. Учир нь монголоос англи хэлнээ орчуулах хичээлийг заахад олон зүйлийг харгалзаж чамгүй цаг зав гаргаж багш тайлбарлаж, оюутан тайлбарлуулахад хүрдэг билээ. Хичээлийн агуулга хоцорсон нэг л оюутантай тулж ажиллахад бусад оюутанд зарцуулах цаг багасах жишээтэй. Энэ мэтчилэн олон асуудлыг шийдвэрлэхэд энэ хичээлийг зааж буй багшийн хувьд орчуулах арга зүйн тогтсон, цэгцтэй нэг арга, загварыг боловсруулж, суралцагчдад жигд мэдлэг, мэдээлэл өгөх шаардлагатай тулгарсан. Монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийхэд ашиглах

⁶⁹Доктор /Ph.D/, Олон Улсын Улаанбаатарын Их Сургууль, Англи хэлний тэнхим

тогтсон, системтэй загвар боловсруулснаар багшийн хувьд хичээлийн агуулгаа уламжлалт танхимын болон өнөөгийн цахим сургалтын арга зүйн аль ч хэлбэрээр оюутан бүрт тэгш, хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ нэг оюутанд зарцуулах цаг заваа илүү нэмэгдүүлэхээс авхуулаад өөр олон боломжийг бий болгож байгаа юм.

Нэг хэлнээс нөгөө хэлэнд орчуулга хийхэд хоёр хэлний авиа зүй, үг зүй, үгсийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүй гэх мэт хэл шинжлэлийн салбар шинжлэх ухаан болон тухайн хэлээр яригч хоёр ард түмний соёл, ёс заншил, уламжлал, үндэсний сэтгэлгээ гээд бусад олон зүйлсийн ялгаатай байдал, онцлогийг харгалзах хэрэг гарна. Түүн дундаас орчуулгын хичээлийг дөнгөж судалж эхэлж байгаа оюутан суралцагчдад эх хэл (source language), орчуулах хэл (target language)-ийнхаа өгүүлбэрийн бүтэц, үгийн бүтэц, хэлзүйн хувирал зэргийг юуны урьд анхаарч судлах нь зүйтэй байдаг. Учир нь эдгээр асуудал нь орчуулж сурч буй оюутан суралцагчдад тулгардаг гол бэрхшээл юм.

Орчуулгын хичээл заадаг багш нар өөрт тохиолддог бэрхшээлээ шийдвэрлэх арга замыг хайж, олж, хичээлээ зохион байгуулдаг. Тухайлбал судлаач багш Ц.Отгонсүрэнгийн хийсвэрлэх аргыг энд дурдаж болох юм. Өөр өөрийн гэсэн онцлог бүхий арга, загварыг бий болгон хичээлдээ ашиглаж байгаагийн нэгэн жишээ бол энэхүү монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийхэд ашиглах “Орчил” загварыг боловсруулсан оролдлого минь билээ. Энэхүү загварын дагуу орчуулгын онол, дадлага бүхий сурах бичгийг бэлтгэж, 2 дах улиралдаа хичээлдээ туршилтаар ашиглаж байгаа бөгөөд энэ нь орчуулж сургахад туслах энгийн бөгөөд хялбархан арга зам болж байна. Учир нь энэ загварыг орчуулж сурч эхэлж байгаа суралцагчдад зориулсан бөгөөд ийм суралцагчдад тулгардаг хамгийн эхний бэрхшээл нь хэлзүй байдаг тул энэ талын ойлголтыг дэлгэрэнгүй оруулсан. Гэхдээ тавдугаар үе шатанд орчуулгын аргуудыг, долоод орчуулсан мэдээллээ буцаан орчуулж утгыг магадлах, наймд орчуулсан мэдээллийн алдаа мэдгийг хянах, найруулах зэрэг орчуулга хийхэд зайлшгүй шаардлагатай бүх ажиллагааг дэлгэрүүлэн авч үздэг.


“Орчил” загвар, монголоос англиар орчуулах онол, арга зүй

“Орчил” загвар нь өнөөгийн холимог сургалтын арга зүй /blended learning/-гээр хичээлийн агуулыг хүргэх боломжийг бий болгож байгаа бөгөөд үүнийг танхимын болон цахим хичээлийн аль алинд хэрэглэж болно. Энэхүү загвараар

- оюутан бүрт монгол хэлнээс англи хэлнээ орчуулах арга зүйг эзэмшүүлэх,
- оюутанд орчуулах аргачлалын талаар эмх цэгцтэй суурь мэдлэг олгох,
- оюутан өөрийгөө хөгжүүлэх, бие даан суралцах,
- оюутан өөртөө үнэлэлт дүгнэлт өгөх чадвараа сайжруулах,
- судлаач, шинжээч болох бололцоотой.

“Орчил” загварыг Зураг 1.-т үзүүлье.

Зураг 1. Монгол хэлнээс англи хэлнээ орчуулах “ОРЧИЛ” загвар



Энэхүү загварыг орчил хэмээн нэрлэсэн нь орчуулж буй мэдээлэл эхэлсэн газартаа ижил эргэж буухаар үйлдэл хийнэ гэсэн санаа. Өөрөөр хэлбэл, эх мэдээллийн утга санаа, ойлголт, ухагдахууныг алдагдуулахгүйгээр орчуулсан хэлэндээ бүрэн буулгаж байх тухай юм. Бүр энгийнээр тайлбарлавал бидний орчуулах гэж буй монгол мэдээлэл гэсэн дүрс байлаа гэж бодъё. Тэгвэл англиар орчуулсны дараа энэ дүрс ийм хэвээрээ л байх учиртай. Энэ дүрснээс аль нэг тэмдэгт нь дутсан, илүүдсэн, хазайсан байх учиргүй. “Орчил” загвар нь 8 үе шатаас бүрдэнэ. Үүнд, нэгд- ангилах, хоёрт – тодорхойлох, гуравт – шилжүүлэх, дөрөвт – тохируулах, тавд – үг оноох, зургаад – хэлбэржүүлэх, долоод – хянах, наймд найруулах. Бүх найман үе шат өөр хоорондоо бүрэн уялдаатай. Энэхүү загварын тайлбарыг хүснэгт 1-д үзүүлье.

Хүснэгт 1. “ОРЧИЛ” загварын тайлбар

Үе шат	Хийх ажиллагаа	
I	Эх хэлний (монгол) өгүүлбэрийн гишүүдийг ангилах	} ЭХ ХЭЛ
II	Эх хэлний өгүүлбэрийн төрлийг ангилж, тодорхойлох	
III	Эх хэлний өгүүлбэрийг орчуулах хэлний (англи) өгүүлбэрийн бүтцэд шилжүүлэх	} ЭХ & ОРЧУУЛАХ ХЭЛ
IV	Эх, орчуулах хэлний өгүүлбэрүүдийн үйл үгийн цагийг тохируулах	
V	Үг оноох	} ОРЧУУЛАХ ХЭЛ
VI	Орчуулах хэлний (англи) өгүүлбэрийн бүтцэд шилжсэн гишүүдийг хэлзүйн харьцаагаар хэлбэржүүлэх	

VII	Орчуулсан өгүүлбэрийн утгыг эх хэлний өгүүлбэртэй нь тулгаж хянах	}	ОРЧУУЛАХ & ЭХ ХЭЛ
VIII	Орчуулсан (англи) өгүүлбэрийг найруулах		

Энэ нь монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийхэд зориулсан загвар тул эх хэл нь монгол хэл, орчуулах хэл нь англи хэл юм. Тус загварын нэг, хоёрдугаар үе шатанд эх хэлний өгүүлбэрийн гишүүд болон төрөл ангиллыг олж тогтоох ажлыг хийх бол, гурваас тавдугаар шатанд эх хэлнээс орчуулах хэлний өгүүлбэрийн бүтцэд байршуулах бэлтгэл ажил хийх, үйл үгийн цагийг тохируулах, өгүүлбэрт орсон үгсийг нийцэх орчуулгын аргын дагуу зөв оновчтой үгсээр оноох ажлуудыг гүйцэтгэнэ. Зургаадугаар үе шатанд англи хэлний бүтцэд шилжүүлэхэд бэлэн болсон өгүүлбэрийн гишүүдийг өгүүлбэр болгохын тулд хооронд нь холбож, нийлүүлж нэгтгэнэ. Энэ үе шатанд зөвхөн орчуулах хэлний хэлзүйтэй холбоотой ажил өрнөнө. Харин долоодугаар шатанд нэгэнт орчуулсан өгүүлбэрийнхээ утга санаа бүрэн гарсан эсэхийг шалгаж магадлах ажлыг хийнэ. Ингэж орчуулсан өгүүлбэрийнхээ утга санааг эх хэлнийхтэй нь тулгасны дараа алдаа гарвал дахин сайжруулж орчуулна. Эцэст нь наймдугаар үе шатанд орчуулсан өгүүлбэрээ дахин шалгаж магадлан. Энд орчуулсан өгүүлбэрт найруулгын алдаа бий эсэхийг хянах ба илүү ойлгомжтой, тодорхой, оновчтой болгох өөр арга зам бий эсэхийг шүүн тунгаана. Орчил загварын энэхүү товч тайлбарыг дараах Хүснэгт 2-т дэлгэрүүлбэ.

Хүснэгт 2. “ОРЧИЛ” загварын дэлгэрэнгүй тайлбар

Үе шат	Хийх ажиллагаа	Тайлбар
I	Эх хэлний (монгол) өгүүлбэрийн гишүүдийг ангилах	Гол гишүүд – өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, Дэд гишүүд - шууд ба шууд бус тусагдахуун, тодотгол, байц
II	Эх хэлний өгүүлбэрийн төрлийг ангилж, тодорхойлох	1) Энгийн, нийлмэл, холимог өгүүлбэрийн аль нь болохыг олж тогтоох 2) Нийлмэл болон холимог өгүүлбэр бол гол ба гишүүн өгүүлбэрүүдийн тоо, төрлийг тодорхойлох 3) Нийлмэл болон холимог өгүүлбэрийн утгыг зөв, оновчтой илэрхийлэх холбоосыг сонгох
III	Эх хэл дээрх өгүүлбэрийг гадаад хэлний (англи) өгүүлбэрийн бүтцэд шилжүүлэх	Англи хэлний өгүүлбэрийн үндсэн бүтцийн дагуу монгол өгүүлбэрийн гишүүдийг түүнд нийцүүлэн байрлуулах (SOV→SVO)
IV	Эх болон гадаад хэлний өгүүлбэрүүдийн үйл үгийн цагийг тохируулах	Монгол өгүүлбэрийн өгүүлэхүүн (verb/predicate) –ийн цагийг тодорхойлоод, англи хэлний тохирох цагийг олж тогтоох Монгол хэлний үйл үгийн цаг → англи хэлний

		үйл үгийн цаг (active, passive) → (simple, continuous, perfect → (past, present, future, future in the past)
V	Үг оноох	Орчуулж буй мэдээллийн утгыг оновчтой илэрхийлэхийн тулд өгүүлбэрийг бүрдүүлэгч үгсийг англиар зөв олж сонгох
VI	Гадаад хэлнээ орчуулсан өгүүлбэрийн бүтцэд шилжсэн гишүүдийг хэлзүйн харьцаагаар хэлбэржүүлэх	Англи хэлний өгүүлбэрийн байгууламж “SVO”-д шилжсэн өгүүлбэрийн гишүүдийг үгзүйн болон өгүүлбэрзүйн харьцаагаар хэлбэржүүлэх, Үүнд үг бүтэх ёс, хэлзүйн нөхцөл, дагавар, өгүүлбэрийн хэв, гишүүдийн байрлал гэх мэтийг зохицуулах
VII	Гадаад хэлэнд (англи) орчуулсан өгүүлбэрийн утгыг эх хэлний өгүүлбэртэй нь тулгаж хянах	Энэхүү монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийх “Орчил” загварын дагуу эхний зургаан үе шатыг гүйцэтгэсний дараа орчуулсан англи өгүүлбэрээ буцааж монголоор орчуулна. Англиас монгол хэлнээ эргэж орчуулсан монгол өгүүлбэрийг анхны эх монгол өгүүлбэртэй нь утгыг тулгана. Ингэж эх мэдээлэл (монгол өгүүлбэр)-ийн утга, санаа бүрэн гүйцэд, зөв, ойлгомжтой гарсан эсэхийг шалгаж магадлана.
VIII	Гадаад хэлээр орчуулсан (англи) өгүүлбэрийг найруулах	Эх (монгол) өгүүлбэрийн утгыг англиар илүү зөв, оновчтой, ойлгомжтой тодорхой гаргахын тулд 1) хэлний ба хэлний бус найруулгын алдаа гарсан эсэхийг нягтлах 2) орчуулсан англи өгүүлбэрийн тоо, төрөл, хэв, үг, өгүүлбэрийн холбоос болон гишүүд хоорондын харьцаа, үг үүсгэх болон хэлзүйн дагавар нөхцөлийг өөрчлөн хувиргах боломжийг эрэлхийлж, эх өгүүлбэрийн санааг илтгэх англи өгүүлбэрийн ямарваа нэг тогтсон бүтэц, үг хэллэг, өөр бусад онцлог байдаг эсэхийг сайтар харгалзах

Монгол хэл нь алтай язгуурын хэлний ангилалд, англи хэл нь энэтхэг-европ хэлний ангилалд тус тус багтдаг бөгөөд энэхүү төрөл бус хоёр хэлний өгүүлбэрийн бүтэц нь хоорондоо адилгүй. Англи хэлний өгүүлбэрийн бүтэц **өгүүлэгдэхүүн + өгүүлэхүүн + тусагдахуун** [SVO] байдгаараа монгол хэлнийхээс ялгардаг. Жишээлбэл:


- I draw the sun.
- Би зурдаг нар.

Гэхдээ “Орчил” загварыг сургалтад хэрэгжүүлэхдээ монгол, англи төрөл бус хоёр хэлийг Universal Grammar буюу Түгээмэл Хэл Зүй хэмээх хэл шинжлэлд нэрлэгддэг, хүн төрөлхтний ямар ч хэлний бүтэц ерөнхий зарчим дээр суурилдаг гэсэн шинжлэх ухаанч хандлагыг баримтлав (Д. Гүн-Үйлс, 2007). Тус загварын дагуу суралцагчдад зориулан орчуулж үзүүлсэн нэгэн жишээ өгүүлбэрийг “Монгол англи орчуулга II” сурах бичгээс эш татан үзүүлье. (Т. Мягмарсүрэн, 2019)

“Орчил” загвар, монгол хэлнээс англи хэлнээ орчуулах аргачлал

Жишээ өгүүлбэр: 1911 онд Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс байгуулагдсан боловч 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр хятадын харьяаны автомат засаг тогтсон байна.

ҮЕ ШАТ I: Эх хэлний (монгол) өгүүлбэрийн гишүүдийг ангилах



ҮЕ ШАТ II: Эх (монгол) өгүүлбэрийн төрлийг ангилж, тодорхойлох


Гол өгүүлбэр:

1. Цагийн байцын бүлэг: 1911 онд
2. Өгүүлэгдэхүүний бүлэг: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс
3. Өгүүлэхүүний бүлэг: байгуулагдсан

Гол ба гишүүн өгүүлбэрийн холбоос: боловч

Гишүүн өгүүлбэр:

1. Шууд тусагдахууны бүлэг: хятадын харьяаны автомат засаг
2. Шууд бус тусагдахууны бүлэг: 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр
3. Өгүүлэхүүний бүлэг: тогтсон байна.



ҮЕ ШАТ III: Эх өгүүлбэрийг орчуулах (англи) өгүүлбэрийн бүтцэд шилжүүлэх

SOV → SVO

(Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц → англи хэлний өгүүлбэрийн бүтэц)

Subject = өгүүлэгдэхүүн

Verb = өгүүлэхүүн

Object = тусагдахуун

Монгол өгүүлбэр

SOV: 1911 онд → Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр → хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна.

Англи хэлний өгүүлбэрийн бүтцэд оруулан байршуулах хувилбарууд

SVO 1: 1911 онд → Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч, 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр → тогтсон байна → хятадын харьяаны автомат засаг.

SVO 2: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд, 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр → тогтсон байна → хятадын харьяаны автомат засаг.

SVO 3: 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр → тогтсон байна → хятадын харьяаны автомат засаг, → Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд.

SVO 4: Хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна → 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр, → Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд.

SVO 5: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд , хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна → 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр.

SVO 6: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд , хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна → 3 улсын гэрээ гэгчээр → 1915 оны.

ҮЕ ШАТ IV: Эх, орчуулах өгүүлбэрийн өгүүлэхүүн гишүүний цаг тохируулах

Эх өгүүлбэрийн өгүүлэхүүн /гол өгүүлбэр/:

тогт + сон → өнгөрсөн цагийн –*сон* нөхцөл 

Орчуулах өгүүлбэрийн өгүүлэхүүн /гол өгүүлбэр/ :

establish + ed → энгийн өнгөрсөн цаг –*ed* /past simple tense – passive voice/

Эх өгүүлбэрийн өгүүлэхүүн /гишүүн өгүүлбэр/:

байгуулагдах + сан → өнгөрсөн цагийн –*сан* нөхцөл 

Орчуулах өгүүлбэрийн өгүүлэхүүн:

formalize + ed → энгийн өнгөрсөн цаг –*ed* /past simple tense – passive voice/

ҮЕ ШАТ V: Үг оноох

1911 онд Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс байгуулагдсан боловч 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр хятадын харьяаны автономит засаг тогтсон байна.

- 1) **Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс** → The Bogd Khanate of Mongolia / state of Mongolia Elevated by the Many
- 2) **3 улсын гэрээ гэгч** → so called Tripartite Agreement
- 3) **хятадын харьяаны автономит засаг** → Chinese autonomous government

ҮЕ ШАТ VI: Орчуулах өгүүлбэрийн бүтцэд шилжсэн гишүүдийг хэлзүйн харьцаагаар хэлбэржүүлэх

Үе шат гурав дээр гаргасан зургаан хувилбарын зургаа дах хувилбарыг авч ажиллая. Энэ хувилбар нь гол ба гишүүн өгүүлбэрээс тус тус бүтэж байгаа бөгөөд гол өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, цагийн байц гэсэн үндсэн 3 бүлэгтэй бол, гишүүн өгүүлбэр нь өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүн, шууд бус тусагдахуун, цагийн байц гэсэн 4 бүлгээс бүрдэж байна.

SVO 6: Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс → байгуулагдсан боловч → 1911 онд , → хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна → 3 улсын гэрээ гэгчээр → 1915 оны.



SVO: боловч* → Богд хаант Монгол улс Олноо өргөгдсөн → байгуулагдсан → - д 1911, → хятадын харьяаны автомат засаг → тогтсон байна → гэгчээр 3 улсын гэрээ → -ы 1915.

* **боловч → боловч:** Монгол хэлний “- боловч” хэмээх холбох үг нь хавсарсан нийлмэл өгүүлбэрт гишүүн өгүүлбэрийг гол өгүүлбэрт холбох үүрэг гүйцэтгэдэг “дутагдан холбох –вч” нөхцөлтэй ижилхэн утга болон үүрэгтэй.

Монгол хэлний “- боловч” хэмээх өгүүлбэрийг захируулан холбох үг болон англи хэлний сөрөл заасан байц гишүүн өгүүлбэрийн нийтлэг шинж

Монгол хэлний “дутагдан холбохын –вч” нөхцөл нь нэг үйлийг нөгөө үйлтэй утга эсрэгцүүлэн холбох үүрэгтэй байдаг тул “–вч” холбох нөхцөл болон үүнтэй ижил утга илэрхийлж байгаа “- боловч” хэмээх холбох үгс орсон гол ба гишүүн өгүүлбэрүүдийн нэгийг нь утга эерэг байхад нөгөөх нь сөрөг байна. Жишээлбэл,

- Эрдэнэ эхнэр, хүүхдээ **үгүйлэвч** буцаад явахыг бодсонгүй. /Ч.Л/

Энэ утгыг “- боловч” хэмээх холбох үгээс гадна “-үл хайхран”, “- гэсэн хэдий ч”, “- хэдий ч”, “хэдийгээр ...ч” хэмээх үгс үйл үгтэй хамт илэрхийлдэг. Мөн үйл үг нь сул “- ч”- тэй хамт илэрч болно.

Англи хэлний сөрөл заасан байц гишүүн өгүүлбэр

Монгол хэлний “дутагдан холбохын –вч” нөхцөлөөр холбогдсон гишүүн өгүүлбэрийг англи хэлэнд сөрөл заасан байц гишүүн өгүүлбэр гэж нэрлэдэг. Англи хэлний сөрөл заасан байц гишүүн өгүүлбэр нь бусад төрлийн өгүүлбэрүүдээсээ ялгарах холбох үгтэй. Эдгээрт “*in spite of the fact that*”, “*though*”, “*even though*”, “*although*”, “*even if*”, “*while*”, “*whereas*” г.м орно. Эдгээр холбоос нь гишүүн өгүүлбэрийнхээ өмнө байрлаж, гишүүн өгүүлбэрээ гол өгүүлбэртээ холбодог. Монгол хэлний хавсарсан нийлмэл өгүүлбэрт гишүүн өгүүлбэрээрээ эхэлж, гол өгүүлбэрээ төгсөх нь олонтаа тохиолддог бол англи хэлний гол ба гишүүн өгүүлбэрийн аль алинаар нь ч хавсарсан нийлмэл өгүүлбэрээ эхлүүлж, төгсгөж болдог онцлогтой. Жишээ нь:

- **Though** he is poor, he is always neatly dressed. (Тэр ядуу **ч гэсэн** үргэлж цэвэрхэн хувцастай явдаг.)
- I would like to go out **although** it is raining. (Бороо орж **байсан ч** хамаагүй, би гармаар байна.)
- I will go **even if** you forbid me to. (Чи намайг **хориглосон байлаа ч** би явна.)
- I enjoyed the film **even though** I had a headache. (**Хэдийгээр** толгой өвдөж **байсан ч** тэр киног үзэх сайхан байв.)
- **While** it is true that I have some lands and houses, I do not have liquid cash to invest in industry. (**Хэдий** надад хэд хэдэн газар, байшин гээд үл хөдлөх байгаа нь үнэн **боловч** үйлдвэрт хөрөнгө оруулахаар түргэн борлогдох актив алга.)

- **Whereas** John had more enemies than friends, his brother was extremely popular. (Жон найз нөхөдтэй гэхээсээ илүү олон дайсантай хүн явдаг **байхад** түүний ах нь/дүү нь олон түмнээр хүрээлүүлсэн алдар нэртэй хүн байх юм даа.)

SVO: Орчуулсан өгүүлбэр

Even though The Bogd Khanate of Mongolia, Elevated by the Many, was established in 1911, the Chinese autonomous government was formalized according to the so called Tripartite Agreement (China, Russia, and Mongolia) in 1915.

ҮЕ ШАТ VII: Орчуулсан (англи) өгүүлбэрийн утгыг эх өгүүлбэртэй нь тулгаж хянах

Монгол хэлээр	1911 онд Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс байгуулагдсан боловч 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр хятадын харьяаны автономит засаг тогтсон байна.	
	Even though The Bogd Khanate of Mongolia, Elevated by the Many, was established in 1911, the Chinese autonomous government was formalized according to the so called Tripartite Agreement in 1915.	Англи хэлээр
	1911 онд Олноо өргөгдсөн Богд хаант Монгол улс байгуулагдсан боловч 1915 оны 3 улсын гэрээ гэгчээр хятадын харьяаны автономит засаг тогтсон байна.	Монгол хэлээр

Орчуулсан өгүүлбэрээ буцаагаад монголоор орчуулахад эх өгүүлбэрийн утгатайгаа дүйцэж байна.

ҮЕ ШАТ VIII: Орчуулсан (англи) өгүүлбэрийг найруулах

Even though The Bogd Khanate of Mongolia, Elevated by the Many, was established in 1911, the chinese autonomous government was formalized according to the so called Tripartite Agreement in 1915.

Энэ өгүүлбэрийн гишүүдийг байршлын хувьд зургаан хувилбар гаргасан тул эдгээрийн аль ч хувилбараар бичих боломжтой. Түүнчлэн үг сонголтыг өөрчлөх бүрэн боломж бий.

Оюутан энэхүү “Орчил” загварын найман үе шатыг баримтлан монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийж эхэлснээр орчуулж сурах арга барилаа хялбар олж, цэгцтэй суурь мэдлэгтэй болж чадах ба орчуулгын аливаа алдаа мадаг гаргахгүйн төлөө хичээнгүйлэн ажиллах чадварт суралцах бол багш нь суралцагч бүрийн онцлог ялгаатай байдалд нийцсэн сургалтыг зохион байгуулж хамтран ажилласнаар оюутнаа хөгжүүлнэ.

Дүгнэлт, санал

Сургалт зохион байгуулах, хичээлийн агуулга хүргэх явцад тохиолддог янз бүрийн бэрхшээлтэй нөхцөл байдлыг шийдвэрлэхийн тулд оюутан бүрт хүртээлтэй, танхимын хичээлийн хуваарьт цагаар хэмжигдэхгүй, илүү чөлөөт байдлаар монголоос англиар орчуулах арга зүйн нэгдсэн системтэй мэдлэг олгоход “Орчил” загварыг ашиглах нь өнөөгийн холимог сургалтын арга зүйд нийцнэ.

“Орчил” загварыг зөвхөн монгол хэлнээс англи хэлнээ орчуулга хийхэд хязгаарлах төдий бус бөгөөд төрөл бус бусад аль ч хэлний орчуулгад авч ашиглах бүрэн боломжтой.

Оюутан тус загвараар орчуулж сурснаар бие даан суралцахад суралцаж, өөрийгөө хөгжүүлж, цаашид судлаач шинжээч болох бололцоотой.

Монгол хэлнээс англи хэлнээ орчуулах онол арга зүйг тусгасан “Орчил” загварыг бүрэн хэмжээнд тайлбарласан, түүний дагуу үндсэн зургаан сэдвийн хүрээнд арван таван дэд сэдвээр орчуулах дадлага хийх дасгал ажлуудыг багтаасан сурах бичгийг оюутан суралцагчдад зориулан гаргасан. Орчил загвараа хоёр улирлын хугацаанд хичээлдээ туршаад явж байгаагаас гадна илүү сайжруулахаар хэл шинжлэлийн эрдэмтэн судлаачдаас зөвлөгөө авч ажиллаж байгаа тул цаашид энэ загвараа улам боловсронгуй болгоно.

Ном зүй

1. Гүн-Үйлс, Д. (2007). *Англи монгол зэрэгцүүлсэн хэл зүй*. Улаанбаатар.
2. Мягмарсүрэн, Т. (2019). *Монгол англи орчуулгын дадлага II*. Улаанбаатар. Амжа принтинг.
3. Толя, М. (2013). *Монгол улсын түүхийн лекцүүд. Монголын түүхийн үечлэл*.
4. Төмөртоогоо, Д. Санжаа, Ж нар. (2004) Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Монгол судлалын сургууль, Монгол хэл шинжлэлийн тэнхим. *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар.

DEVELOPING NOTE-TAKING SKILLS IN CONSECUTIVE INTERPRETING WHICH SHOULD BE INTRODUCED IN THE INTERPRETING CURRICULUM (IN THE UNDERGRADUATE STUDENTS)

Sh.Serchmaa⁷⁰

Товч утга: Гадаад хэл зааж байгаа их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр нь тухайн гадаад хэлний эзэмшвэл зохих мэдлэгийг эзэмшихийн зэрэгцээ тодорхой ур чадвар, хандлагыг эзэмшүүлэх нийгмийн хэрэгцээ шаардлага тулгарч байна. Гадаад хэл зааж байгаа их, дээд сургуулиудын хичээлийн хөтөлбөрт бичгийн болоод аман орчуулгын хичээл нь мэргэжлийн судлах хичээлд багтдаг. Эндээс аман орчуулгыг авч үзвэл, нэг хэлээр илэрхийлсэн санааг өөр хэлээр дамжуулахдаа дагаж хэлмэрчлэх, зэрэгцэж хэлмэрчлэх гэсэн хоёр аргыг хэрэглэдэг. Дагаж хэлмэрчлэх аргыг тодруулан авч үзвэл орчуулагч тухайн яриа (speech)-г сонсонгоо тэмдэглэл хөтлөөд тэмдэглэлээ ашиглан хэлмэрчилдэг. Дагаж хэлмэрчлэх явцад тэмдэглэл хөтлөх арга нь тухайн ярианы (speech) гол хөтөч болдог. Тухайн сэдэвт гарч байгаа үг хэллэг, илэрхийлэл, гол санааг нь микро түвшинд, илтгэлийн бүтэц, хүрээг нь макро түвшинд нь авч үздэг. Хэлмэрчлэхүй хичээлийн хөтөлбөрт дагаж хэлмэрчлэх орчуулгын аргачлалыг тусгах нь тэмдэглэл хөтлөх, тэмдэгт болон товчилсон үг, хураангуйллыг стандартын дагуу зөв бичиж сурах дадлагыг хөтөлбөрөөр нь дамжуулан оюутанд олгосноор аман орчуулга хийх дөртэй болох юм. Цаашиаад бид хэлмэрчлэхүй хичээлийн хөтөлбөрийг боловсронгуй болгоход анхаараад зогсохгүй хичээлийн хэлбэр, заах арга зүйд анхаарах шаардлага зайлиггүй байна.

Key words: *consecutive interpretation (CI) - дагаж хэлмэрчлэхүй, simultaneous interpretation (SI) -зэрэгцэж хэлмэрчлэхүй, speech- яриа/илтгэл, note-taking techniques- тэмдэглэл хөтлөх аргачлал, symbol- тэмдэгт, short-term memory (STM)- түр зуурын ой санамж, long-term memory (LTM)-урт хугацааны ой санамж*

Theoretical background

The history of interpreting is not well documented, although it is generally agreed that as an activity it is older than written translation. Firstly, the communication skills, which it requires are clearly different, as interpreters need to be expert oral communicators. Secondly, while translators often have relatively unlimited opportunity to make alterations and improvements before submitting a final version, interpreters are required to create a finished product in ‘real time’ without the possibility of going back and making revisions; in other words interpreting, unlike written translation, is both non-correctable and non-verifiable. Thirdly, interpreters must ensure that any background knowledge, which they are likely to need has been acquired in advance;

⁷⁰ Ph.D, English Language Department, International University of Ulaanbaatar

seeking colleague's advice or consulting reference works is not generally possible during the actual process of interpreting. Fourthly, interpreters are performers who are constantly making split-second decisions and taking communicative risks; consequently, they typically experience higher stress level while on the job than most translators. Various types of interpreting can be distinguished either by the context in which it occurs (conference interpreting, court interpreting, community interpreting, liaison interpreting) or in the way in which it is carried out (consecutive interpreting, liaison interpreting, simultaneous interpreting).

Consecutive interpreting involves listening to a speech delivered in one language in front of an international audience, taking notes and then giving the same speech in another language, making sure it is as close to the original as possible in terms of content, delivery and style. The activity is taught and practiced through memory exercises, listening comprehension, summarizing, abstracting and note-taking. There is some very useful literature on note-taking for consecutive interpreting aimed both at trainee interpreters and at interpreter trainers. The most frequently cited works are Jean Francois Rozan, (1956) *Note-taking in Consecutive Interpreting*; Roderick Jones, (2002): *Conference interpreting explained* Andrew Gillies, (2017): *Note-taking for consecutive interpreting*. Even though note-taking constitutes an integral part of the interpreting process, it may detract interpreters from active listening. This means that the note-taking task involves filtering and ruthless selection, as well as translation, so that the speech can be then delivered in another language. Because of the bilingual nature of the task, shorthand would not be effective in helping to reproduce the original speech verbatim and thus eschew the process of filtering, as shorthand is based on standardized symbols of sounds, not meaning. More importantly, the role of interpreters' notes should be to "relieve memory" (Jones, 2002: 42) and to outsource tasks that cannot be performed by memory alone. In other words, notes should be an aide-memoir, not a schematic representation of the entirety of the speech. Because of the mutual dependence of memory and notes and the highly contingent nature of memory, notes are highly personalized to the extent that "no two interpreters will ever produce an identical set of notes" (Andrew Gillies, 2017) for the same speech. At the same time, the majority of speeches tend to be formulaic to the extent that they "present the interpreter with a limited range of the same problems, for which effective solutions have already been worked out and are applied by many, many interpreters" (ibid.). This means that despite the contingent and subjective nature of notes, there exist basic principles of note-taking in consecutive interpreting that *can* be taught. Despite this, there is no one-size-fits-all note-taking system, which poses a particular challenge for learning and teaching. The basic principles mentioned above are supposed to become "internalized" (Andrew Gillies, 2017) and ultimately individualized to follow a personal style as well as the requirements of any given speech, speaker or setting. This is easier said than done. The current learning experience involves teaching students some basic note-taking symbols and abbreviations of terms that occur in most speeches, as well as strategies in noting down numbers, links, tense and how to separate ideas. Learners practice interpreting speeches based on no notes, minimal notes, only symbols,

only numbers etc. They are also encouraged to share their notes to see examples of different note-taking styles and even to try to reproduce the original speech based on other people's notes. However, they do not get an insight into *how* different styles of notes are produced – how quickly the interpreter takes notes, how much of a time lag there is in producing these notes, how selection of information takes place, which language is chosen for note-taking etc. Class time is too limited for carrying out these activities and for helping learners develop the creativity required to assimilate the techniques taught and make them their own. Maybe uploading pre-recorded videos of real-time note-taking on a virtual learning environment such as Blackboard would be useful for learner practice. The videos would not be prescriptive, but they are meant to trigger reflection and generate ideas. It would save class time and create the space necessary for students to be creative, experiment and develop a personal note-taking style. It would also offer an insight into the professional world by demonstrating different types of real-time note-taking. The opportunity for reflection is important, as students can go back and deconstruct the process while exploring and developing their own efficient system. In this way, they are encouraged to be “active makers and shapers of their own learning” (JISC, 2009: 51).

Note-taking in Consecutive Interpreting

Memory plays an important role in interpreting. There are two types of memory for human beings. The first one is short-term memory (STM) which keeps the information for a short period of time (up to 30 seconds) and no neural mechanisms for later recall is created in it. The second is long-term memory (LTM) which creates neural pathways to save information which can be recalled weeks, months or years later. LTM is a learning process and is an important element in interpreting, since Review of Applied Linguistics Research information stored in LTM may last for minutes to weeks, months or even an entire life. Having powerful memory is very important in interpreting, and students of interpreting should be taught to empower their memory. But which of these two kinds of memory should be trained? The answer is STM. Since in interpreting memory lasts for a short time and when the job is finished the interpreter moves on to another conference with different subjects, speaker and audiences. Therefore, he doesn't need to keep the information of a specific conference to his mind. Each interpreter needs two kinds of qualifications to do his best in the challenging work of interpreting: a good short-term memory to retain what he or she has just heard and a good long-term memory to put the information into context. Interpreting is based on short term memory. The notes can support memory to restore more information. CI of speeches longer than two or three minutes, note-taking is necessary. It has been proved that note-taking is useful in CI due to several reasons. First, notes facilitate the reception and analysis of the SL speech by improving concentration and preventing distraction. Second, notes decrease the burden imposed on memory, as interpreters can resort to their notes for remembering names, dates, numbers, etc. Third, notes can be used to highlight missing details and anything that requires latter attention. In consecutive interpreting, the speeches are divided into several segments. The interpreter listening to what is being said and taking notes while the speaker finishes the segment. When the

speaker stops speaking, the interpreter then renders the portion of the message or the entire message, depending on how it was delivered, into the target language. If the speaker talks in a sentence or two, it is easier for the interpreter to translate. However, when the speaker talks longer, the interpreter has to take notes in order to deliver the message accurately. A speaker can talk for five minutes before pausing. A consecutive interpreter has to have an excellent memory aside from being fluent in the source and target languages. Moreover, the interpreter needs excellent note-taking skills. They use a special note system, wherein they use symbols to represent words that denote emphasis, negation, entailment, consistency and more. More often, the consecutive interpreter is required to recreate, rather than memorize, the meaning of the speech. It takes times even years of experience and practice for interpreters to develop their own efficient, tried and tested system of note-taking for consecutive interpreting. In order to be a good consecutive interpreter the students must be able to listen very actively, analyze what the speaker is saying, make useful notes which will jog your memory of the speech as you give it back, and then be able to make the speech as if it were your own in your active language. There are three main actions are:

1. *Listen actively (understand)*
2. *Analyze (take structured notes)*
3. *Reproduce (communicate)*

Let us consider about the followings:

1. *Listen actively (understand)*

A number of different skills are involved – beyond the understanding of the passive/foreign language. A consecutive interpreter first has to learn how to 'listen actively'. This might sound straightforward but interpreters listen in a very different way to other people (just as a psychoanalyst also has a special way of listening to people talk) – because the purpose of the listening is different. Interpreters are not listening to react or join in the conversation, they are listening to be able to remember and reproduce accurately and faithfully in another language what was said (and psychoanalysts are listening for clues as to the mental state of their patient). In order to learn this special skill interpreters are first taught how to be able to reproduce a speech without taking notes.

2. *Analyze (take structured notes)*

Note-taking is part of the second phase of 'analysis' – this necessitates the ability to prioritize information and distinguish between primary and secondary information, to be able to clearly note down who has said what, when something happened, (who, what, when, where, how) the speaker's opinion and so on.

3. *Reproduce (communicate)*

The third and final phase of 'reproducing' what you have heard requires again a number of different skills – the ability to access short-term memory, understand your notes, communicate in an engaging way to name but a few. Stress management and voice care are an important part of this too. All of these different skills need to be learnt.

You are not an interpreter just because you happen to speak more than one language; it is much more complex than that.

There are several reasons why having a considered and consistent system for taking notes in consecutive interpreting is useful. In economics micro means looking at the individual, the small scale, whereas macro means examining the workings of the whole national or international economy. Macro means looking at the bigger picture. Whereas words, expressions and ideas are part of the micro-level, the structure, framework and way the speech is built up from the macro-level. Notes taken in consecutive interpreting are a representation of the skeleton structure of the speech. The original speech is a group of ideas in a certain order; it is not an arbitrary muddle of the unrelated ideas. In the speaker's mind at least, the ideas that make up a speech are related to one another, be it logically, chronologically or by their relative importance. These relationship and the structures used to express them are limited in number and occur repeatedly in all sorts of speeches, so once have learnt to recognize them, you will need a quick and consistent way of noting them. In this way, notes become the visual representation of your analysis of the source speech. The notes must be at least as clear as the analysis preceding them; otherwise the analysis is wasted, and usually the notes will be clearer in structure than the original speech, so that the interpreter can easily transmit the same message to the audience. You will be listening at two levels; to the words of the speech in order to understand them but also to the overall speech, to how the bits fit together. This is what we mean by a macro- approach. Consecutive interpreting involves a number of different tasks that have to be completed at the same time with finite and competing intellectual capacities- multitasking. These tasks as follows:

Phase1: While the speaker is speaking

Listening and analysis, note- taking, short –term memory operations, coordination of these tasks

CI= L (listening) + M (Short-term Memory) + N (Note-taking)

Phase2: While the interpreter is speaking

Note- reading, remembering and production

CI= R (Remember) + R (Read the notes) + P (Produce the speech in the target language)

In Phase 1, the most common problem for student interpreters is that it is difficult to do all these things at the same time. We have finite intellectual capacity. If you are thinking too much about how to note something, you will listen less well. In fact not hearing something is much more common among student than not understanding something. You do not hear because you are concentrating too much on deciphering the original or on taking notes. Note also that these four tasks are inextricably linked to one another. Listening makes analysis possible, but good analysis in turn means quicker, clearer notes. And vice versa: a sound note-taking system helps you to analyze the source speech. Finally good analysis and note taking will promote

effective short term memory operations. If your notes are unclear or illegible, your production will suffer because you will put too much effort into reading them. Clear notes, on the other hand, offer something stage directions. Telling the interpreter when to pause, when to add emphasis and when not to. Note-taking system is not a system in the way shorthand is a system. There is no single right way to note a source speech. The note-taking system has its roots in the Indo-European languages of Europe. It reads from left to right and is built around word order of these languages. There are historical and practical reasons for it: conference interpreting was born in Europe and much of its literature was written there.

There is a question what to note? Interpreters should be aware of the fact that in the process of note taking, they should note ideas rather than isolated words. Words of language are just containers for concepts and ideas. Interpreters cannot write down every single word they hear in a speech, since the speed of writing is always slower than that of speaking. Consequently, the interpreter should have the ability to detect and keep the main idea but delete any irrelevant element. The second thing that interpreters should keep in mind while note taking is paying attention to the links between ideas. Ideas are connected to each other by means of links and connectors. Jones (2002) divided these links into three groups. a) The logical consequences expressed by: consequently, as a result, accordingly, or therefore. b) The logical cause showed by words like: because, due to, as or since. c) Opposition showed by: but, yet, however or nevertheless. While note-taking, the interpreter should simply write down links, as he can use them to join the written ideas on his notes later in his turn for rendering the message. Links can really prevent confusion for interpreters. Paying attention to non-contextualized information in a speech is another important thing in note-taking. They are elements that cannot be recalled by analyzing a text and logical thinking. Proper names, terminologies, lists of things and numbers are examples of non-contextualized elements. There is a difference between these elements and main ideas of a speech. The interpreter can easily remember main ideas as they form a kind of mental image in his mind. Whereas, non-contextualized information are easily disappear, if they are not written down by interpreters. The final thing that should receive attention in note-taking is tenses of verbs. Jones (2002) explained that "when noting verbs, interpreters should thus take care to the tense correctly, and if appropriate the mode, in particular conditional". This is due to the effect of mode and tense of verbs on meaning.

The second question is how to note? It is obvious that notes are aimed at helping the interpreter to recall much more information while rendering the speech. Therefore, they should be taken in an organized way to reach their aim. Otherwise, notes not only are not helpful for interpreters but also they waste his time and distract his attention from concentrating on the speech. Thus, notes should be economical and short to save interpreter's time on writing. That's why using abbreviations and symbols is one of the curtail features of note-taking. Abbreviations help interpreters take notes quickly. They should be "unequivocal and unambiguous". Abbreviations should be used automatically and this is possible only when interpreters develop their own system of

abbreviations beforehand. Although, abbreviations may be meaningless for others, they must be meaningful for interpreters. Abbreviations can be classified into three groups:

- a) Common abbreviations: which are most derived from Latin. Such as:

C.F.	compare
i.e.	that is
e. g	for example
NB	note well
No	number
etc. (et cetera)	and so on

- b) Discipline-specific abbreviations: as the term reveals are technical abbreviations used in specific fields of study. Every interpreter depending on his interest in different subjects, should be familiar with the common abbreviations of that discipline. For example,
in chemistry: **Au** is an abbreviation used for gold, **GM** is an abbreviation used for magnesium.
- c) Personal abbreviations: these kinds of abbreviations are created by interpreters themselves and will vary from one person to another. For example, an interpreter may use the following abbreviations:

pres → president

countr → country

poli → policy

According to Rozan (2005) interpreters can follow a principle in creating abbreviations.

- a) Write what they hear just by recording the sounds of that word. For instance, interpreters should write the abbreviated form hi for the word high

- b) Drop medial vowels. For example, the word **legal** can be abbreviated as **lgl**,

- c) Write initial and final vowels. Thus, **office** can be written as **ofs**.

Interpreters to avoid ambiguity in writing abbreviations. Therefore, if they have an abbreviation such as prod in their notes it could be read as: production, producer, product, or productivity. Whereas, if written this way the ambiguity is removed: pr^{on}, pr^{er}, pr^{ct}, pr^{vity}. Moreover, the tense of verbs should also be stated clearly, thus, for future tense ^{ll} and for past tense ^d should be used. To avoid writing long expressions in notes and saving time, it is recommended to use a shorter word with the same meaning.

Их гүүшийн орчуулгыг ойлгомжтой болгон засварласан нь ч мөн нэг иймэрхүү зүйл болжээ. Тухайлбал, хамгийн эхний мөрийг аваад үзье. “Хөрст алтан дэлхийн Хөвөө хязгаар нутагт” гэснийг “... хязгаар нэгэн нутагт” болгосон нь болхи гэхэд дэндүү болхи аж. Чухамдаа “хөвөө хязгаар” гэсэн тодотгол бол монгол үлгэрт гардаг “газрын мухарт”, “эндээс маш хол нутагт” гэсэн утга бүхий уран дүрслэл билээ. Манай хэвлэгч үүнийг дээрх маягаар сольсон нь дээр өгүүлсэнчлэн бичээчийн хуруу “нугын цагаан эрвээхэй нисэн буухын адил аа”-г “түүний хуруу хурдан хөдөлдөг” болгон зассантай агаар нэгэн бөлгөө.

Уран зохиол бол үгийн урлаг, тийм ч учраас үг бол уран сайхны дүр бүтээх, аливаа зүйлийг уран сайхнаар яруу тансаг илэрхийлэх үндсэн хэрэглүүр юм. Ямар нэгэн утга үүрэг оноож, зориудаар хэрэглэсэн тэр хэрэглүүрийг “засварлан сайжруулах” боломжгүй бөгөөд хэрвээ аливаа нэгэн этгээд тэгж зүрхэлбээс “толгойдоо булуу хурааж буй” хэрэг болно. Бидний хэлэлцэн буй энэхүү “бүтээл”-д “... Гучин жил тэнэж, дөчин жил суужээ” (орос эхэд “Ровно тридцать лет и три года” гэж буй) гэсэн, “маш олон жил” гэсэн утга бүхий яруу дүрслэлийг “Гучин гурван жил ... аж төрөн суужээ” гэсэн нь тухайн утгыг ойлгомжтой болгосон хэрэг огтхон ч биш, харин ч орос хэлний тухайн хэлцийн утгыг гадарладаггүй гэдгээ нийтэд тунхаглан зарласан хэрэг болжээ. Нэг хэлнээс нөгөөд уран зохиол орчуулж байгаа хүн тухайн тэр зохиолд юуны тухай өгүүлж байгаа агуулгыг төдийгүй, энэ агуулгаа

чухам яаж, уран сайхны ямар арга хэрэглүүрээр дамжуулан гаргасныг эх хэлээрээ дүрслэн буулгах учиртай тухай манай нэрт эрдэмтэн, орчуулга судлаач, доктор, профессор А.Шархүү гуай нэгэн өгүүлэлдээ [7: 57] онцлон тэмдэглэсэн байдаг. Гэтэл манай хэвлэгч зохиолын агуулгын талаар, тэр тусмаа түүнийг илэрхийлж буй хэлний уран яруу хэрэглүүрийн тухайд ч ямар ч ойлголтгүй нэгэн бололтой. Тэр ч атугай яруу найраг, шүлэг хэрхэн бүтдэг тухай мэдэхийг ч нэг их хүсдэггүй нь илт. Эс тийм бөгөөс “Өвгөн нь загас барьж, Далайн хөвөө сахина” гэсэн товч бөгөөд тодорхой мөрүүдийг мөн л “сайжруулж”, “Өвгөн нь загас барьж, Өдөржин далайн хөвөө сахина” хэмээн юунд нуршихсан билээ.

Энэ мэт “ойлгомжтой болгон сайжруулсан” “засвар” маш олон байна. Энэ юү болж байна вэ? Уран зохиолд, улмаар өсвөр хойч үеийнхээ оюуны боловсролд яаж хандаад байна вэ? Сайн зохиол бичиж, яруу сайхан орчуулга хийж мөнгө олж болох ч, нийт олноор нэгэнт хүлээн зөвшөөрсөн дэлхийн сонгодог зохиолын шилдэг орчуулгуудыг “ойлгомжтой болгон засварлах” замаар ийнхүү эрэмдэглэж, түүгээрээ хүүхэд багачуудын тархийг угааж, түрийвчээ зузаалах нь зөв үзэгдэл, зүйтэй хандлага мөн үү?

Иймэрхүү сөрөг үзэл хандлагыг таслан зогсоох үүрэг хариуцлага бүхий орчуулгын шүүмж судлал хаахна явна вэ? Монгол улсад орчин үеийн орчуулгын онол, орчуулгын шүүмж судлал 1930-аад оноос эхлэлтэй бөгөөд нэрт дуун хөрвүүлэгч Б.Ринчин, Ц.Дамдинсүрэн нар үндсийг нь тавьсан хэмээн эрдэмтэн судлаачид үздэг. Энэхүү шинэхэн салбар ухааныг Х.Пэрлээ, Ү.Нямдорж, М.Цэдэндорж, Ж.Бадраа, Чой.Лувсанжав, Д.Чойжил, Р.Гүрбазар, Д.Дашдаваа, Ц.Хасбаатар, Г.Аким нарын зэрэг манай нэрт орчуулагч, эрдэмтэн судлаачид залган авч, хөгжүүлэн дэвжээж, залуу хойч үедээ залгамжлуулан өвлүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан [1: 4-5] нь маргаангүй үнэн билээ. Гэтэл сүүлийн жилүүдэд дээрх эрдэмтэн судлаачдынх шиг жинтэй, дорвитой шүүмж туурвих нь эрс ховордож, тал зассан, хий хоосон магтан дэвэргэсэн зүйл нэлээд гарах болов [8: 144-153]. Иймд орчуулгын чанарыг сайжруулъя, ард иргэддээ, нэн ялангуяа хүүхэд залуустаа орчуулгын чанар чансаатай бүтээл барих зорилго эрхэм хэмээн үзэж л байгаа бол энэ чиглэлийн шүүмж судлалд дээр дооргүй анхаарах цаг болжээ. Энэ салбарын мэргэжилтнүүдийг уран бүтээлийн зохих эвлэл, холбоодоос санаачлан захиалах замаар МУИС, МУБИС-ийн сэтгүүл зүйн салбараар тодорхой төлөвлөгөөтэйгөөр бэлтгэж эхлэх шаардлагатай байна. Эс тэгвээс “Сувдаг шунахай сэтгэл эцэстээ юунд хүргэдгийг” нотлон харуулсан энэ мэт номонцор номын дэлгүүрүүдийн лангууг дүүргээд зогсохгүй, өсвөр хойч үеийнхний маань оюун тархийг бохирдуулсаар байх нь ээ.

Ном зүй

1. Адьяа О. Орчуулга: онол, туршлага, сургамж. УБ., 2008, 4-5-р тал.
2. Барамсай Ж. Хэцүү урилга. УБ., 2009. 39-р тал.
3. Дамдинсүрэн Ц. “А.С.Пушкины “Олег сэцний дуулал” орчуулсан ба тайлбарласан нь” эрдэм шинжилгээний өгүүлэл, УБ., 1938.

4. Магсар Ц. Место Пушкина в истоке монгольской поэзии нового времени // [https://nccur.lib.nccu.edu.tw/bitstream/140.119/97061/1/19\(p49-71\).pdf](https://nccur.lib.nccu.edu.tw/bitstream/140.119/97061/1/19(p49-71).pdf)
5. Мөнх-Эрдэнэ Б. Эгнэгт дурсагдах их эрдэмтэн// [https://medium.com/@Mogii_haha/%D1%8D%D0%B3%D0%](https://medium.com/@Mogii_haha/%D1%8D%D0%B3%D0% Мэндэлснийх нь 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжигээний өгүүлэл.) Мэндэлснийх нь 110 жилийн ойд зориулсан эрдэм шинжигээний өгүүлэл.
6. Шаракшинова Н.О. О переводах Пушкина на монгольский язык//Вестник Ленинградского университета, 1949, №6, стр.78.
7. Шархүү А. Орос хэлнээс яруу найраг орчуулж байгаа тухай асуудалд//Туурвил зүй, орчуулга судлалын зарим асуудал. УБ., 2011, 57-р тал.
8. Эрдэнэмаам С. Ойлгох нь орчуулахын амин сүнс//Орчуулга зүй, 2013, №1, 144-153-р тал.

СОЛОНГОС ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН НЭГЭН ЗОХИОЛЫН ТУХАЙД

Г. Эрдэнэчимэг⁷⁴

요약: 지난 20 여년 동안 몽골에서 한국 문학작품 번역이 매우 활발하게 이루어졌지만, 번역에 대한 비평은 거의 찾아볼 수 없습니다. 하지만 번역에 대한 심도 있는 비평이 이루어져야 번역의 수준이 향상될 수 있습니다.

저는 이번에 한국의 문학번역원 지원으로 출간된 ‘한국학의 즐거움’의 몽골어 번역본을 읽어 보았습니다. 번역본은 전반적으로 몽골어 번역이 매끄럽지 못해서 원저자의 의도를 제대로 살리지 못한 부분이 상당히 여러 군데 보였습니다. 번역이 매끄럽지 못하다는 것은 정확한 어휘 대역이 이루어지지 않았고, 번역문 몽골어의 문체가 일반 몽골인 독자들에게 생경하거나 부자연스럽다는 것입니다. 각 분야에서 왕성하게 활동 중인 필자 22 명의 원고를 몽골어로 좀 더 정확하게 번역했다면 몽골독자들이 ‘한국적인 것’을 좀 더 깊이 이해하는 계기가 되었을 것이라는 아쉬움이 남습니다.

Түлхүүр үг: Солонгос судлал, орчуулагч, орон судлаач, соёл судлал, үг оноолт, хам сэдэв

БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн Яамны харьяа Солонгос Судлалыг Дэмжих Албанаас Солонгос судлал (Korean Studies) гэдэг ухагдахууныг мэргэжлийн түвшинд тодорхойлох шаардлагатай гэж үзээд 2009 оны өвөл нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлжээ. Хэлэлцүүлгийн дүнд 2011 оны 8-р сард Их сургуулийн профессор эрдэмтэн, гүн ухаантан, яруу найрагч, утга зохиолын шүүмжлэгч зэрэг Өмнөд Солонгосын 22 соён гэгээрүүлэгчийн бичсэн өгүүллийг эмхэтгэсэн “Солонгосыг судлахын цэнгэл (한국학의 즐거움)” хэмээх бүтээл уншигчдын гарт очсон юм. Уг бүтээлийг БНСУ-ын их дээд сургуульд ахисан түвшинд суралцаж, мэргэжлээрээ чамгүй олон жил ажилласан, их дээд сургуулийн багш голцуу монгол судлаачид БНСУ-ын Утга Зохиолын Орчуулгын Хүрээлэнгийн ивээн тэтгэлгээр орчуулж, 2017 онд “Солонгос түмнийг тольдохуй” нэрээр хэвлэн монгол уншигчдын гарт хүргэв.

Аливаа бүтээлийг орчуулахад соёл судлалын үүднээс хандах, үг хэлний өнгөн бүтэц төдийгүй, түүний чанадад орших соёлын утга агуулгыг бүрнээ нээж илтгэхийг чухалчилж буй (Чимэдцэе.М, 2014:101-106) өдгөө үед ийм бүтээл гарсанд миний бие олзуурхсан ч уншиж үзээд урам хугарлаа. Тэгээд орчуулгын чанарын талаар хэдэн үг нэмэрлэх нь зүйтэй гэж бодов. Бичиг зохиолд уншууртай байх гэж нэг чухал чанар бий. Үг үсгийн алдаагүй, утга төгөлдөр, найруулга

⁷⁴Доктор /Ph.D./, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази Судлалын тэнхим

сайтай бүтээлийг унших нь автомашинаар зүйрлэвэл толь шиг замаар салхи сэнгэнүүлэн давхих мэт гацаж торохгүй хурдан байдаг. Уг номыг уншихад эхний хуудаснаасаа энхэл догол замаар элэг бөөрөө доргион сэгсчүүлэх мэт санагдлаа.

Мэдээж уг номын хорин хоёр өгүүллийн орчуулга бүгд уншуургүй биш. Эдгээр солонгос зохиолчдын бүтээл үнэ цэнээ алдахгүй бөгөөд ямар нэг зохиол бүтээлийг хэдэн ч хүн, хэдэн ч удаа орчуулж болох тул монгол уншигчдад илүү сайн хүргэхээр авьяас чадвараа сорих боломж бидэнд байна.

Энэ удаад бид уг номын хоёрдугаар өгүүлэл болох философич Кан Шинь жү-гийн “Солонгос хайр сэтгэл – Жаяа хэмээх нэгэн эмэгтэйн хайр”-ыг авч үзье. Зохиолч өгүүлэлдээ ХХ зууны эхэн үеийн Чосөн-ий алдарт яруу найрагч, орчуулагч Пэг сөг (1912-1996), дууч эм Ким Ёнхан хоёрын хайр сэтгэл, ялангуяа Ким Ёнханы дотоод ертөнцийг судалснаар солонгос хүний хайр сэтгэлийн тусгай (singularity) болоод нийтлэг шинж (universality) юу болохыг тодруулахыг зорьсон (강신주, 2011:36) ажээ.

Орчуулагч хүний гол үүрэг бол эх зохиолын агуулгыг нэмж хасахгүйгээр, утгыг нь төгс бус юм гэхэд төгс рүү дөхүүлсэн хэмжээнд уншигчдад хүргэх явдал юм. Орчуулах ажилдаа үнэнч, бүтээлч санаачилгатай хандан хичээл зүтгэл гаргаснаас нь хэр зэрэг ёс зүйтэй орчуулагч болохыг үнэлж ч болно.

Манай орчуулагч, гүүш нар эртнээс үгчилж орчуулахын болхи бүдүүлгийг шоолж, утгачилж орчуулахын эрхэм чухлыг (Оюунзаяа.Н, 2014:73-76) онцлон дурдаж ирсэн тул онолын нарийн ширийнийг нуршилгүй, засаж залруулуштай зүйлийг товч дурдъя.

Юуны өмнө үг ташаа оноосны улмаас утга учир нь ойлгогдохгүй зүйл цөөнгүй байна. Ташаа үгийг давтах тусам орчуулгын чанар муудах нь тодорхой. 33-р нүүрний эхний мөрөнд “хэнхэг сэтгэлзүйн өвчтөн”, 41-р нүүрт “... эрэгтэйчүүдийн дийлэнх нь хэнхэг өвчнөөр шаналж байдаг..., ... хэнхэг өвчтөнд хамгийн чухал нь өөрийн дур хүсэл ..., “Наташагүй явж чадахгүй гэдэг итгэл нь түүний хэнхэг сэтгэлзүйн баталгаа нурж байгааг харуулж байна” гэжээ. Үүнийг уншсан ямар ч монгол хүн ойлгохгүй. Орчуулагчийн хэнхэг сэтгэлзүйн өвчин гэж оноосон 강박증 гэдэг үгийг гар доорх толь бичиг, интернет сайт зэргээс нягталж үзэхэд нэг бодол, нэг үйлдлээ олон давтдаг, ийнхүү давтдагаа хэвийн бус гэж ойлгож байгаа ч больж чаддаггүй сэтгэлзүйн эмгэгийг хэлдэг юм байна. Жишээ нь, гэрээсээ гарч явтал хаалгаа цоожлоогүй мэт санаж, дахин дахин буцсаар үүднээсээ холдож чадахгүй байх, эсвэл өвчин халдах мэт санан гараа угааж арчсаар угаалтуураас холдож чадахгүй болох зэргээр хүн хүнд янз бүрээр илэрдэг байна. Өмнөд Солонгост урьд нь тун ховор байсан ийм эмгэг сүүлийн үед олширч байгаа ажээ. Мэдрэлийн эмч нар анх уг эмгэгийг сэтгэл түгших эмгэг хэмээн оношилж байснаа сүүлийн үед тусад нь авч үздэг болсон юм байна. Монголчууд бид энэ эмгэгийн талаар сайн мэдэхгүй тул сэтгэл түгших эмгэг гэж оноход болохгүй зүйлгүй мэт.

34-р нүүрт “Тиймээс бид өөрийн худал хуурмагийг илрүүлэх нь хэдий төвөг ярвигтай ч заавал бусадтай харилцаж байдаг. Өөрийн үнэн царайг илрүүлэн тайлж, нээж, тэвэрч өгөхийг найдангаа шүү дээ” гэж утгыг гажуудуулсан байна. Эхийг нягтлахад, бид өөрөө өөрийнхөө хуурамч төрхийг илрүүлэх бус харин бидний хуурамч төрхийг бусад хүн дор нь олоод харчихдаг тухай өгүүлсэн байх юм. Бас өөрийн үнэн төрхийг илрүүлж өгөхийг найдах тухай өгүүлсэнгүй. Харин жинхэнэ дүр төрхийг маань бусад хүн мэдсэн ч мэдээгүй юм шиг хандаасай гэж хүсч найддаг тухай өгүүлжээ.

Гарчиг гэдэг бол хам бичвэрийн утга санааг хэдэн үгээр томьёолж илэрхийлсэн, уншигчийн нүдэнд эн тэргүүнд тусдаг чухал зүйл. Орчуулагч эх бичвэрээ сайтар уншиж ойлгосны дараа гарчгийг хэрхэн оноохоо бодож тунгаах хэрэгтэй. Харин энд гарчгийг орчуулахдаа хайхрамжгүй хандсан тал байна. (35-р нүүр) “Жусоны дууч эмсийн бүлгэмийн дууч эм Ким Ёнхан”-ыг “Жусоны дуулаачийн бүлгэмийн дууч Ким Ёнхан” гэхээр утга нь бүдэг бүрхэг болжээ. Тэгсэн атлаа текст дотроо дууч эм гэж оноосноос үзэхэд орчуулсан зүйлээ эргэж харж, нягталж шалгаагүй юм уу гэлтэй. Тэгээд ч Ким Ёнхан дууч эм учраас л энэ хоёр хүний хайр сэтгэл эмгэнэлтэй байсныг зохиолч тайлбарлаад байгаа юм.

Хэлц үгийг ташаа орчуулсан байна. Мөн нүүрэнд “Илжиро нь .. тухайн үеийн Жусонд алтны уурхайн халуун салхийг дэгдээж байлаа” гэснийг ойлгоход хэцүү. Үгчилж орчуулбал халуун салхинд дайруулах 熱風에 휩쓸리다, утгачилбал ямар нэг зүйлд автах гэдэг хэлц үгийг “халуун салхийг дэгдээх” гэж ташаа оноожээ. Эх бичвэрийг нягтлахад “Ылжиро гудамж ... тухайн үеийн Жусон улс алтны ‘солоиролд’ автсаныг тод харуулах газар болоод байлаа” гэсэн утгатай байна. Соёлын агуулгатай орчуулга хийхэд орчуулагч тухайн цаг үеийн нөхцөл байдлыг олж мэдэх, тайлбар зүүлт хийх шаардлага заавал гардаг. Харин энэ орчуулгыг үзэхэд орчуулагч 1930-аад оны Солонгосын нөхцөл байдлыг мэдэхийн тулд эрэл хайгуул эс хийжээ гэж бодогдлоо. Дээр нь нэг ч зүүлт, тайлбар хийсэнгүй. Энд дурдаж буй “Ылжиро”-г Сөүл хотын төвд орших худалдааны гудамж гэдгийг тайлбарлахад илүүдэхгүй. Мөн Кёнсон(35-р нүүр)-ийг колоничлолын үеийн Сөүл хотын нэр гэдгийг жирийн уншигч тэр бүрий мэдэхгүй.

Мөн 38-р нүүрт “сурагч, эсвэл оюутны асран хамгаалагч” гэдэг үгийг “анги тэнхим” гэж ташаа оноосноос “... анги тэнхим шиг байр хөлсөлж амьдардаг байсан Пэг Сог...” гэсэн нь уншигчийг төөрөгдүүлэхээр болжээ. Энэ үеийн хорин дөрвөн настай залуу Пэг Сог, анги танхим шиг айхавтар том байр хөлсөлж амьдрах эдийн засгийн чадваргүй байлаа. Тийм ч учраас дууч эмийн хөлсний байраар эргэлддэг байсан байж таарна. Байр хөлсөлж бус харин хамаатныхаа ахынд толгой хавчуулж суудаг байсан тул орчуулагч хам сэдвээ сайтар ойлгох нь хэр чухал болохыг энэ ташаарлаас харж болно.

Газар усны нэрийг буруу орчуулсан, ерөнхий мэдлэг дутсанаас алдсан зүйл ч байна. Үүнд 37-р нүүрэнд “... Хятадын Дунжины үед” гэснийг монгол уншигч Хятадын эртний улс болох Зүүн Жинь улсын үед гэж ойлгохгүй. Мөн 40, 41, 43-р нүүрэнд Манжуурыг Манж гэж ташаа оноожээ. Орчуулагч хүн түүх, газарзүйн

тодорхой мэдлэгтэй байх шаардлагатайг сануулах юун. Өгүүлэлд 1920, 30-аад оны үйл явдал гарч байгаа бөгөөд Манж Чин улс энэ үед хэдийн мөхсөн байлаа. Колоничлолын эхэн үед солонгосчууд Манжуур руу шилжин суурьших нь ихэссэн бөгөөд залуу Пэг сог хайртай бүсгүйгээ дагуулаад Манжуур явахыг мөрөөддөг байжээ. Төстэй дуудлагаас нь болдог юм уу, манай оюутан залуус Манж Манжуур хоёрыг хольж хутгах нь их.

Үүнээс гадна сулхан найруулсан, утга гажуудуулсан зүйл байна. Тухайлбал, 33-р нүүрэнд, “*Ингээж бид өөрийн талаарх жинхэнэ үнэн ойлголтонд хүрдэг нь хууль юм*”, 37-р нүүрэнд “*Пэг Сог өөрөө Ким Ёнханд өгөх эмгэнэлт хүлээлтийг урьдчилан таамаглаж байсан болов уу?*”, 38-р нүүрэнд “*... ямар ч өөр сэвгүй хаш чулуу мэт бичиг номонд гэгээрсэн нэгэн...*”, “*Пэг Сог ... аавынхаа хүчинд автан Кёнсонд албадуулан гэрлэжээ*”, 39-р нүүрэнд “*эцэг эх мэт дээдлэн үздэг энэ орчлон хорвоо түүнд хичнээн аймшигтай байсныг харж болно*” гэх мэтээр тааруу найруулжээ.

Ялангуяа “...티 없이 옥 같은 군자로서...” гэснийг “... ямар ч өөр сэвгүй хаш чулуу мэт бичиг номонд гэгээрсэн нэгэн...” гэж оноосон нь тааруухан оноолт болжээ. 군자 (君子) гэдэг үгийг манай гүүш нар эртнээс эрдэмт сайд гэж орчуулж ирсэн уламжлалтай. Күнзийн сурталд төгс төгөлдөр ёс суртахуунтай хүнийг гэгээн, түүний удаад орох хүнийг эрдэмт сайд гэж нэрлэдэг ажээ⁷⁵. Күнз “Гэгээн хүнтэй учирч эс чадах аваас эрдэмт сайдтай учрах сан (論語, 述而篇)” хэмээн мөрөөдөж байжээ. Тэгэхээр зүгээр нэг бичиг номд гэгээрсэн хүн бус, харин ёс суртахууны хувьд төгс биш юм гэхэд сайтар боловсорсон хүнийг хэлж байна. Орчуулгын уламжлалаа гээхгүй, дагаж мөрдөхийн чухлыг давтан сануулъя.

Мөн 40-р нүүрт, “Наташа бид хоёр ба цагаан илжиг” гэдэг шүлэг дур булаам чанарыг илэрхийлж байгаа гэжээ. Солонгос эхэд буй 관능적 гэдэг үгийг “дур булаам чанарыг илэрхийлэх” гэж оноосон байх юм. Харин толь бичгээс нягтлахад “бэлгийн дур хүслийг өдөөх” гэсэн утгатай байна. Тэгэхээр дур булаам чанарыг илэрхийлсэн бус харин эротик шүлэг болж таарлаа. Тэгээд ч солонгос эхэд илжгээр “тачаангүй бүсгүй”-г бэлгэдсэн гэж тодорхой тайлбарласан байна.

Энэ өгүүлэлд 욕망;慾望 гэдэг үг нэлээд олон давтагдана. Үүнийг хам бичвэрээс нь хамааран “дур хүсэл”-ээс гадна “хүсэл эрмэлзэл”, “хүсэл шунал”, “хүсэл мөрөөдөл”, “хүслэн” гэж оноож болмоор. Гэтэл орчуулагч арваас есөд нь дур хүсэл гэж оноожээ. 41-р нүүрт, “*Тиймээс эрэгтэйчүүд өөр хэн нэгэн түүнд дур хүслээ илэрхийлэхэд яахаа ч мэдэхээ болих тийм мэдрэмжийг мэдрэх нь олонтаа*” гэсэн нь модон найруулгатай болсон байна. Ер нь монгол хүн мэдрэмж гэдэг үгийг яриандаа нэг их хэрэглэдэггүй. Харин сүүлийн үед англи хэлнээс орчуулсан тааруухан орчуулгын нөлөөгөөр залуус хэт “мэдрэг” болж, “цонхоор харах мэдрэмж”, “хоол идэх мэдрэмж” гэж ярих нь халаг боллоо. “Танд ямар санагдаж байна вэ?” гэснээс “Танд ямар мэдрэмж төрж байна вэ?” гэж асуувал их л соёл боловсролтой хүн мэт харагдана гэж боддог бололтой.

⁷⁵ <https://terms.naver.com/entry.nhn?docId=510170&cid=42126&categoryId=42126>

Цааш 43-р нүүрний “‘өнөөдрөөс эхлэн чи миний үүрдийн эхнэр’ гэж хэлсэн өөрийн амлалтаа биелүүлэх гэсэн Пэг Согын амлалтаа зөрчсөн гэмээ ухамсарласан ухаарлыг үлдээхийг Жаяа хүссэнгүй. Мэдээж түүнд хайртай эсвэл түүний дур хүслийн объект болмоор байвал шүү дээ... тэр нь өөрийн хайрт Пэг Согыг бага ч атугай тайван амгалан байлгах арга, тэгснээрээ мөн түүнийг хүсэл сонирхлын объектоор үлдээж чадах арга гэж ч бодсон учраас тэр”, мөн 45-р нүүрний “Тухайн үедээ өөрийнх нь дур хүслийн объект болохыг л хүсэж байсан тэр бүсгүйг шийдэмгийгээр тэрхүү дур хүслийнхээ эзэн нь болгох хэрэгтэй” гэсэн хэсгийг хэдэнтээ уншаад ухаж эс дийлэв. Дээр нь алдарт яруу найрагч, дууч бүсгүй хоёрын хайр сэтгэлийг дур хүсэл төдийгөөр ойлгуулаад байвал юунд ч уярч, сэтгэл догдлох билээ? Бичгийн өндөр боловсролтой, яруу найргийг ойлгодог тэр бүсгүй Пэг Сөг-ийн өдрийн бодол, шөнийн зүүд болсон хүн байсан болов уу.

Эцэст нь дүгнэхэд :



Орчуулгын ажлын үе шатыг орчуулга хийх гэж буй хүн сайтар мэдэх шаардлагатай. Чимхлүүр, нягт нямбай ажиллагаа шаарддаг энэ ажлын тодорхой үе шатыг гүйцэтгэлгүй, бэх нь хатаагүй шахам анхны нооргоо хэвлэлийн газар руу барьж гүйдэг (Гүрбазар.Р, 1996:7-9) байж болохгүй. Орчуулагчийн солонгос бичгийн хэлний мэдлэг, монгол хэлээрээ найруулан бичих чадвар, үгийн баялаг сулхан байна. Үг ташаа оноосон зүйл цөөнгүй тул нэг бүрчлэн тоочсонгүй.

Оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглахдаа ямар галигийн журам ашигласан нь тодорхойгүй. Солонгос хэлний оноосон нэрийг монгол хэлээр галиглах журам байдаг ч улсын хэмжээнд нэг мөр мөрдөхөөр батлаагүй байгаа тул түр орхив.



Орчуулагч хүнд орон судлаач байх хэрэг их гарна. Орчуулах гэж буй зүйлийнхээ талаар мэдлэг хомс, утга учрыг нь олоогүй бол орчуулах талаар бодох ч хэрэггүй. Орчуулагч хүн бүгдийг мэдэж чадахгүй ч зөв орчуулахын тулд эрэл хайгуул, судалгаа хийх хэрэг байнга гарна. Толь бичгээс өөр “багаж зэвсэг”-гүй ахмад үеийн орчуулагч нартай харьцуулахад интернэтийн эриний залууст эрэл хайгуул хийх нь хялбар ажил болсныг сануулах юун.

Орчуулгыг ариутган шүүх үүргээ редактор гүйцэтгэсэнгүй. Номын редактор хийх хариуцлагатай үүргийг хүлээж авсан бол нэрээ тавиад орхих бус, мэдлэг, ерөнхий боловсролоо зузаатгасны үндсэн дээр, (Ринчен.Б, (Аким.Г) 1991) ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэж, цэвэр сайхан монгол хэлээ эвдэхгүйн төлөө хичээж чармайх хэрэгтэй.

Сүүлийн хорь гаруй жилд солонгос хэлтэй орчуулагч, судлаач олширч, Солонгосын уран зохиолын 400 гаруй бүтээлийг монгол хэлээр орчуулсан ч орчуулгын шүүмж бараг гарсангүй. Цаашид чанар чансааг нь сайжруулах нэн шаардлагатай байгаа тул солонгос-монгол орчуулгын үйлсэд санаа аваасай хэмээн хэдэн үг нэмэрлэв.



НУТГИЙН АЯЛГУУ СУДЛАЛ



НУТГИЙН АЯЛГУУ СУДЛАЛЫН ТОЙМ

М.Очирцэнд⁷⁶

Товч утга: Монгол хэлний нутгийн аялгуу судлал бол монгол хэл-бичгийн шинжлэх ухааны томоохон салбар ухаан болно. Одоо Монгол улсад Халх, Ойрад, Буриад, Үзэмчин гэсэн дөрвөн гол аман аялгуутан оришин сууж байна. Монголчууд бидний хэл яриаг гадаадад эрчимтэй судлах ажил 1898 оноос эхэлжээ. Монгол хэлний нутгийн аялгуу судлалын 110 гаруй жилийн түүхийг эргэн үзэхэд анхандаа гадаадын монголч эрдэмтэд монгол хэл аялгуутны угсаатны бүрэлдэхүүн, оришин суух нутаг орон, зан үйлийн талаас илүү анхаарсан байдаг.

Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс өнгөрсөн 90-ээд жилд Монгол хэл, нутгийн аялгуу, аман зохиол судлах 100 орчим эрдэм шинжилгээний хээрийн шинжилгээний ангийн хийсэн албан томилолтын тайлан, гар бичмэл, соронзон туузанд шингээн үлдээсэн баялаг эх хэрэглэгдэхүүн нь Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгт хадгалагдаж байна. Одоогоор монгол хэлний нутгийн аялгууны тухай хүрэлцээтэй ганц сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний олон зуун өгүүлэл, баялаг эх хэрэглэгдэхүүнтэй байгаа явдал нь Монгол улс дахь монгол хэл шинжлэлийн нутгийн аялгуу судлалын нэгэн гол амжилт мөн билээ.

Түлхүүр үг: Нутгийн аялгуу, сан хөмрөг, эрдэмтэд

Нутгийн аялгуу судлалын тойм

Монгол хэлний нутгийн аялгууг финийн монголч эрдэмтэн Г.И.Рамстедтээс хойш хориод жилийн дараа халхын аялгууг түүхэн харьцуулах аргаар судалсан академич Б.Я.Владимирцовын сонгодог зохиол гарснаас хойш удааширч байсныг тухайн үеийн ШУХ-гийн Хэл зохиол судлах газар буюу эдүгээгийн ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ахмад эрдэмтдийн санаачилга, хамтын ажиллагааны хүчин чармайлтаар 1952 оноос эрчимтэй эхлэн хөдөө орон нутагт аман зохиол, нутгийн аялгуу сурвалжлан судлах хээрийн шинжилгээний ангийг жилд 1-3 удаа зохион байгуулж ажилласны зэрэгцээ цуглуулан эх хэрэглэгдэхүүний сан хөмрөгийг шинээр үүсгэж, хадгалах, судалгаанд бэлтгэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн байдаг.

Төв Азийн өргөн уудам нутагт тархан суугаа монгол угсаатнуудын хэл аялгууны ялгаатай болон адил төстэй талыг харгалзан ангилах асуудал эрдэмтдийн анхаарлыг татсаар ирсэн байдаг. Энэ талаар хамгийн анхны ангиллыг хийсэн хүн бол оросын эрдэмтэн А.Д.Руднев юм.

А.Д.Руднев 1908 онд тухайн үедээ мэдэгдэж байсан монгол хэл аялгуунуудыг газар зүйн байрлалаар нь Дорнод, Өрнөд, Умард⁷⁷ гэж 3 хуваасан

⁷⁶ ШУА, Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

- *Дорнод салбарт: Ордос, Цахар, Түмэд, Сөнөд, Хорчин, Харчин, Баарин, Хишигтэн, Горлос, Халх аялгуу*
- *Өрнөд салбар: Халимаг, Баяд, Хошууд, аялгуу*
- *Умард Салбарт: Буриад аялгууг тус тус багтаасан байдаг.*

Түүний дараа **Б.Я.Владимирцов 1929 онд Ленинград хотноо хэвлүүлсэн “Монгол бичгийн хэл ба хүрээний халхын аялгууны харшуулсан хэл зүй” номынхоо удиртгалд монгол хэл аялгуунуудыг Баруун салаа, Дорнод салаа⁷⁸ гэж хуваажээ.**

- *Баруун салаанд Асхаран болон Ховдын Дөрвөд, Торгууд, Ховдын Дүрвэд, Баяд, Захчин, Мянгад, Урианхай, Дамби, Өөлдийн хэлэлцэх Ойрад аялгуу*
- *Дорнод салаанд Буриад, Барга, Дагуур, Харчин, Горлос, Найман, Цахар, Ордос зэрэг өвөрлөг аялгууг багтаажээ.*

1953 онд профессор Г.Д.Санжеев Москва хотноо хэвлүүлсэн “Монгол хэлнүүдийн харшуулсан хэл зүй” номынхоо удиртгалд монгол хэл аялгуунуудыг Монгол хэл, Ойрад хэл, Буриад монгол хэл, Дагуур хэл, Монгол хэл, Могол хэл гэсэн 6 төрөл⁷⁹ болгон ангилсан:

- *Тэрбээр Монгол хэлэнд: Халх, Цахар, Ордос, Хорчин, Харчин, Ар Монгол, Өвөр Монгол аялгуунуудыг багтаажээ.*

Түүний дараахан 1955 онд профессор Н.Поппе “Монгол хэлний харшуулсан шинжлэлийн удиртгал” номондоо монгол хэл аялгуунуудыг Өрнөд, Дорнод гэсэн хоёр салаа⁸⁰ болгон ангилаад:

- *Дорнод салаанд Дагуур, Монгол (Монгол Дунсян, Шар, Ёгур), Дорнод монгол (Халх, Ордос, Харчин, Цахар), Буриад (Эхирит, Түнхин, Бохан, Алар, Баргузин, Хори, Ага, Барга буриад, Цонгоол)*
- *Өрнөд салаанд Могол, Ойрад, Халимаг хэлийг тус тус багтаажээ.*

1950-иад оны сүүлийн жилүүдэд Бээжингийн их сургуульд багшилж байсан профессор Ш.Лувсанвандан 1959 оны нэгдүгээр сард Б.Ринчен профессорын илгээсэн нэгэн захидалд: “Таны биеийг монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хуралд илтгэх монгол эрдэмтний бүрэлдэхүүнд оруулсныг мэдэгдье. Таны нэг илтгэлийг “Монгол хэл аялгууны учир” гэж төлөвлөсөн. Үүнд монгол хэлийг халимаг хэл, буриад хэл гэх зэргээр хуваадгийг хэлний шинжлэлийн үндэс баримт хаашаа болохыг гаргамуй. Халимаг хэл гэж Ижил, Донын их, бага дөрвөд, торгууд аялгууг нэрлэдэг бол манай Увс, Ховдын дөрвөд, торгууд, урианхайг бас тусгай хэлтэн гэж үзэх, эсвэл орос үг олон олноор халимаг, буриад нь тусгай хэл гэх болов уу, автономит улс болохдоо аялгуу нь хэл болдог юм уу? гэж бодмоор.

⁷⁷Ш.Лувсанвандан “Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудалд IV”.Уб 2002, 37-р тал

⁷⁸Ш.Лувсанвандан “Монгол хэлний авиа зүйн онол практикийн асуудалд IV”.Уб 2002, 38-р тал

⁷⁹Ш.Лувсанвандан “Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудалд IV”.Уб 2002, 39-р тал

⁸⁰Ш.Лувсанвандан “Монгол хэлний авиазүйн онол практикийн асуудалд IV”.Уб 2002, 40-р тал

Тус хуралд ирэх эрдэмтэн бүхэн монголын судлалд шинэ нээлт болох илтгэл хийх тул дэлхийн эрдэмтдийн сонирхол татах бөгөөд тэдний мэддэггүй зүйлээс илтгэл хийх тул Танд илтгэлийн сэдэв, хэмжээний хувьд сонгон тогтоох бүрэн бололцоо олгоё” гэжээ. Ш.Лувсанвандан багштан, Б.Ринчен гуайн энэ саналыг хүлээн авч монгол хэл аялгуу, монгол хэлний түүх, судлагч эрдэмтдийн шинжилгээ судалгаандаа дэвшүүлсэн саналаас дэлгэрэнгүй шинэ ангилал хийсэн байна. Монгол хэл аялгуунуудыг илүү бодитойгоор ангилсан хүн бол академич Ш.Лувсанвандан⁸¹ юм.

Тэрээр нийт монгол аялгуунуудыг 4 үндсэн аялгуу⁸² болгон хуваажээ. Үүнд:

- *Төв халх аялгуу*
 - a. *Халхын аман аялгуу*
 - b. *Цахарын аман аялгуу*
 - c. *Ордосын аман аялгуу*
- *Дорнод аялгуу*
 - a. *Хорчины аман аялгуу*
 - b. *Харчины аман аялгуу*
- *Өрнөд аялгуу*
 - a. *Шинжааны Ойрадын аман аялгуу*
 - b. *Ижил мөрөний Ойрадын аман аялгуу*
- *Умард аман аялгуу*
 - a. *Байгалын өмнөд буриадын аман аялгуу*
 - b. *Байгалын хойд биеийн аман аялгуу*

1960-д оны дундуур германы эрдэмтэн G.Doerfer орчин үеийн монгол хэл аялгуунуудыг Өрнөд монгол хэл, Дорнод монгол хэл, Алслагдсан монгол хэл гэж гурав хуваасан байдаг.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс монгол хэлний нутгийн аялгууг судлах ажлыг жар далаад онд халх аман аялгууг нарийвчлан судлах эрдэм шинжилгээний ангийг удаа дараалан зохион байгуулж явуулсны үр дүнд Монгол улс дахь халхын аман аялгууг бүхэлд нь хамарсан судалгаа хийгдэж, түүний үр дүнд Э.Вандуй, А.Лувсандэндэв, Ж.Төмөрцэрэн, Ж.Цолоо нарын судалгааны өгүүллүүд нийтлэгджээ. Түүнчлэн халх аялгуунд багтах Дархад, Дарьганга, үзэмчин аялгууны талаар эрдэмтэн Г.Д.Санжеев, А.Лувсандэндэв, D.Kara нарын бүтээлтэй зэрэгцэн халх аялгуун дээр суурилсан орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн тайлбар толь гарсан байдаг. Тус хүрээлэн нь 1955 оноос эхлэн авиа, дуу бичлэгийн тоног төхөөрөмжөөр хангагдаж 1966 онд туршилт авиа зүйн лабораторийг байгуулснаар тухайн үеийн өндөр мэдрэмжит тоног төхөөрөмж кимограф, осциллограф, рентген аппаратаар монгол хэл, түүний олон салбар аман аялгуунуудын онцлог шинжийг судлах болсноос гадна, соронзон туузан бичлэг хийж, тагнайн хэв дардас авах зураглал үйлдэх болсон нь хэл шинжлэлийн шинжлэх ухаанд илүү дэвшилтэт ололт

⁸¹Д.Төмөртоогоо “Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс”.Уб.,2017, 46-р тал

⁸²Ш.Лувсанвандан. Монгол хэл аялгууны учир “Монгол судлал I-р боть”,Уб 1959, 41-р тал

амжилтыг дагуулснаар “Дөрвөд аман аялгуу” (1966), “Захчин аялгуу” (1966), “Монгол хэлний авианы өгүүлэгдэх ёс” (1967), “Халхын аман аялгуу” (1967) зэрэг сэдэвт бүтээлүүд хэвлэгдсэн байна. Уг Туршилт авиан зүйн лаборатори⁸³ нь ШУА-ийн Гадаад хамтын ажиллагаа хийгээд Хэл зохиолын хүрээлэнгийн ахмад эрдэмтдийн хичээл зүтгэлээр Унгарын ШУА-тай хамтран ажиллах хэлэлцээрийн үр дүнд гарсан төлөвлөгөөний нэгээхэн хэсэг юм.

Хэл зохиолын хүрээлэнгийн Туршилт авиан зүйн лабораторийн анхны эрхлэгчээр 1966 онд Ж.Цолоо томилогдон үр бүтээлтэй ажилласан байдаг. Монгол хэлний нутгийн аялгуу судлалын “Монгол хэлний нутгийн аялгуу судлалын тойм”-ыг Д.Цэнд 1959 онд анх удаа хэвлүүлсэн байна. Энэ үед гарсан нутгийн аялгуу судлалд холбогдолтой өөр нэг томоохон бүтээлч ажил бол академич Б.Ринчений удирдлагаар туурвисан “БНМАУ-ын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”⁸⁴ юм. Б.Ринчен, Х.Лувсанбалдан, Ц.Шагдарсүрэн Монгол Ард Улсын Угсаатны судлал хэлний шинжлэлийн атласын⁸⁵ тухайд Академич Б.Ринчений томоохон суурь судалгааны нэг бол “Монгол Ард Улсын угсаатны судлал хэл шинжлэлийн 2 боть атлас” юм. Тэрбээр “Монгол ард улсын хамниган аялгуу” хэмээх бүтээл туурвижээ. *Тэргүүн ботид Монголын улс гүрэн, шавь, засаг захиргааны нэрс, угсаатны бүрэлдэхүүн, овгийн нэрс, сүм хийд, газар зүйн холбогдолтой нэрс, монгол хүний нэрс, монголын аж байдлын холбогдолтой үгс зэрэг монгол хэлний үгийн сангийн бүрэлдэхүүний идэвхтэй ба идэвхгүй хэрэглээний уугуул монгол үг, нутгийн аялгууны үг, түүхэн үгийн хувилбар дуудлагыг хамарсан түүхэн хэл шинжлэлийн судлагдахуунууд багтсан байдаг. Дэд боть нь Хэлний шинжлэл гэсэн ерөнхий гарчигтай бөгөөд монгол хэлний халх, ойрад, буриад, үзэмчин зэрэг аялгууны эгшиг авианы хувьсал, хөгжил, гийгүүлэгч авианы хувьсал, хөгжил байрлалыг тодорхойлсон байна.*

Б.Ринчен “Монгол ард улсын хамниган аялгуу” бүтээлдээ “Алтай овог хэлний нэгэн салбар хамниган-манж хэлтэн”⁸⁶ хэмээн тэмдэглэжээ. Монгол нутагт суурьшсан Ерөөгийн хамниган, Мөнгөнморьтын хамниган, Цэнхэрмандал, Мөрөн зэрэг нутгийн хамниганы хэл аялгууг нягтлан судалж, орчин тойрныхоо монголчуудтай бараг ялгаагүй хэл аялгуутай болсныг олон баримтаар нотолсон юм. Гэвч монгол хамниганы өндөр настан хэсэг хүмүүсийн аман аялгуунаа монгол хэлний түүхэнд сонин үзэгдэл болох баримт бий. Мөн маш цөөхөн нэгэн хэсэг хамниган уугуул хэлээрээ өөр зуураа хэлэлцдэг байна. Б.Ринчен академич монгол нутгийн нутгийн хамниган өтгөсийн хэлийг сурвалжлан Хамниган эвенки хэлний үгсийн зүйлийг 1. Тооны үг, 2. Хүн, хүн бусын зүйл, 3. Хүний ишийн зүйл, 4. Биеийн зүйл, 5. Биеийн эрхтэн, 6. Хувцас хунарын зүйл, 7. Гэр орон, сав хэрэгсэл, 8.тэнгэр, цаг, зүгийн зүйл, 9. Газрын зүйл, 10. Адгуус амьтны зүйл, 11.

⁸³Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухаан, Дээд Боловсролын Хүрээлэн, Унгарын Шинжлэх Ухааны Академи хоёрын хооронд 1959 оны 10-р сарын 14-д Улаанбаатар хотод байгуулсан хамтран ажиллах хэлэлцээр дагуу 1960 оны 11 сарын 03-ны өдөр Будапешт хотод гарын үсэг зурав.

⁸⁴“Хэл шинжлэлийн асуудлууд”, УБ.2006, 111-р тал

⁸⁵Б.Ринчен “Монгол Ард Улсын Угсаатны судлал хэлний шинжлэлийн атлас”, 1979

⁸⁶ Б.Ринчен “Монгол улсын ард хамниган аялгуу”, 1969 3-4-р тал

Адгуу амьтны зүс бялдын зүйл, 12. Ургамлын зүйл, 13. Төмөрлөгийн зүйл гэж уламжлалт аргаар үгсийн бүрэлдэхүүнийг зүйл хувааж судалсан байна. Мөн хамниган аялгууны судалгаанд 1957 онд эрдэмтэн Л.Мишиг Хэнтий аймгийн нутгаар амьдарч суурьшсан хамниганы хэл аялгууг судлахаар Хэнтийн Дадал, Биндэр нэгдэл хамниганчууд бөөн нутагладаг газраар явж 40-90 насны ахмад хөгшид нийлсэн 32 хүнтэй уулзаж сурвалжилж “Монгол ард улсын хамниган аялгууг сурвалжилсан нь” хэмээх илтгэлийг Олон улсын монголч эрдэмтдийн анхдугаар хуралд хэлэлцүүлсэн нь эрдэмтдийн анхаарлыг ихэд татсан байдаг.

Академич А.Лувсандэндэв Монгол хэлний нутгийн аялгуу судлалын ажлаар Хэл зохиол судлах газрын Хэл бичгийн кабинет, Хэл зохиолын хүрээлэнгээс монгол хэлний нутгийн аялгуу, аман зохиол судлах шинжилгээний анги, албан томилолт зэрэгт 1955 оноос эхлэн явж, Дорнод халхын дариганга аман аялгууг судалж, 1970-аад оноос Монгол улсын баруун хойд нутгаар оршин суудаг дархадын аман аялгуу, аман зохиол, цаатан тува урианхай хэл аялгууг Л.Болд, С.Дашцэвэл нартай хамтран амжилттай судалж 1978-1980 онд төв халхын Сэлэнгэ, Цагаантолгойн халхчууд, Төв, Дундговь аймгийн Мандал-Овоо сумын нутгаар Ж.Цолоо, Л.Болд, Я.Баатар нарын хамтаар явж үргэлжлүүлэн шинжилсэн дээр хэд хэдэн шинжилгээний ангийг удирдсан байдаг⁸⁷.

1956 онд Э.Вандуйн удирдсан эрдэм шинжилгээний анги тэр үеийн Говь-Алтай аймгийн Түмэн, Тайшир, Алдархаан, Чандмань, Эрдэнэхайрхан, Завханмандал, Идэр, Тэлмэн сумдын нутгаар явж халх аялгууны авиа зүй, хэл зүй, үгсийн сан, аман зохиолыг анкетын аргыг түүхэн харьцуулах аргатай хослуулан судалсан⁸⁸ байна.

Шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд Ш.Барайшир, Ц.Өлзийхутаг нар оролцжээ. ЭША-ийн хэрэглэгдэхүүнээ боловсруулж 1957 онд Э.Вандуй зарим нутгийн аялгууны үгсийн сангийн бүрэлдэхүүний тухай, Ш.Барайшир “Зарим нутгийн аман аялгууны авиа зүйн тухай” гэдэг хоёр товхимлыг тус тус бичжээ. Э.Вандуй энэхүү өгүүлэлдээ тухайн нутгийн халх аялгууны ерөнхий төлөв, авиабарын тогтолцоог тоймлон судалжээ. Э.Вандуйн сурвалжлан тэмдэглэж, орос, кирилл галиг, латин галигаар бичиж үлдээсэн халх, ойрад, буриад, барга зэрэг аман аялгуу, салбар аман аялгуу, аман зохиолын тайлан өв санг одоо Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгт хадгалагдаж байна.

Монгол хэлний Халх, Буриад, Үзэмчин, Барга аялгуу судлахаар аялсан Монгол улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Хэл шинжлэлийн секторын Туршилт авиа зүйн лабораториос зохион байгуулан илгээсэн хэд хэдэн шинжилгээний ангид Г.Гантогтох амжилттай оролцож, хэдэн чамбай бүтээл туурвижээ. Г.Гантогтох БНМАУ дахь “Монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг” хэмээх гурван боть зохиолын III боть Буриад аялгууны Буриад-халх-орос толь бичгийг 1988 онд туурвиж дуусгасан байдаг. Зохиогч толийнхоо оршилд “ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс удаа дараалан томилон явуулж

⁸⁷ Ж.Цолоо “Монгол улсын шинжлэх ухаан 11”.2009, 62-63-р тал

Ж.Цолоо “Монгол улсын шинжлэх ухаан 11”.2009, -р тал

⁸⁸ Ж.Цолоо “Монгол улсын шинжлэх ухаан 11”.2009, 82-р тал

цуглуулсан нутгийн аялгуу, аман зохиолыг судлах шинжилгээний ангийн хэрэглэгдэхүүнийг түшиглэн монголын утга зохиолын хэлнээс авиа зүй, үгийн сангийн онцлог 6000 толгой үгийг сонгон авч уг толийг зохиолоо гэсэн байна.

Халх, өмнөд монголын аман аялгуу судалсан эрдэмтэд

Академич Д.Төмөртоогоо 1966 онд Дархад аялгуу судлах эрдэм шинжилгээний томилолтоор Хөвсгөл аймгийн Баянзүрх, Улаан-Уул, Ринченлхүмбэ сумдаар явж, дархад аман аялгууны талаар цуглуулсан хэрэглэгдэхүүнээ боловсруулан шинжилж, дархад аман аялгууны авианы нэгэн гол шинж болох урт эгшгийн онцлогийг түүхэн үүднээс авч үзэх зорилт тавилаа хэмээн судалгааныхаа зорилго, арга зүйг тодорхойлсон⁸⁹ байдаг.

Профессор Ж.Төмөрцэрэн Өвөрхангай аймгийн халх аялгууг төв халх, өрнөд халх аялгуутай харьцуулж судлаад Өвөрхангайн халхчуудын хэл яриа төв халх аялгуунд их ойр байдаг боловч авиа зүй, хэл зүй, ялангуяа үгийн сангийн хувьд өрнөд халхын аялгуунаас ялгарах онцлогтой гэжээ.

Эрдэмтэн Ш.Барайшир урьд өмнө судлаагүй байсан төв, баруун нутгийн халх салбар аман аялгууны үгийн санг харьцуулах, анкетын аргыг хослон судалж, монгол бичгийн хэлэнд ховорхон тохиолддог хоёр зуу гаруй үгийг олж гэрийн эд хогшлын нэр, сав суулгын нэр, малын зүсмийн нэр хэмээн хуваан ангилж, газар нутгийн аялгууны үгсийн бүрэлдэхүүний судалгаа гаргасан юм. Энэ нь “Зарим нутгийн халх аялгууны үгсийн бүрэлдэхүүн тухай” гэдэг бүтээлд нь туссан байна.

Эрдэмтэн М.Шинэхүү нь Монгол хэлний нутгийн аялгуу, аман зохиолын сан хөмрөгийг бүрдүүлэхэд биечлэн оролцсон эрдэмтдийн нэг юм. 1958 оны зун Ховд, Увс аймагт нутгийн аялгуу, аман зохиол, зан суртахуун, соёлын өв, ховор чухал ном судар цуглуулах шинжилгээний ангид оролцон явж, захчин аман аялгууны үгийн сан, аман зохиол тэмдэглэж, үг түүвэрлэн, орчин цагийн утга зохиолын хэлнээс ялгаатай 500 гаруй үгийг судалжээ.

Профессор С.Мөөмөө 1955 онд Дариганга аялгуу судлах шинжилгээний ангид оролцож Дариганга, халх ардын олон үлгэр домог тэмдэглэн бичсэн нь одоо ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Дуун ухааны сан хөмрөгийн архивт хадгалагдаж байна.

Доктор Б.Амаржаргал нь 1983 онд Дундговь, Дорноговь, 1984 онд Увс, Завхан аймгийн нутгаар явж өрнөд халхын аялгууг судалж 2007 онд “Халх аялгууны үгийн сан, утгын судалгаа” гэдэг ганц сэдэвт бүтээлээ хэвлүүлсэн байна.

Халх, Ойрад аялгуу судалсан монгол эрдэмтэд

Эрдэмтэн Х.Лувсанбалдан бол Монгол хэлний нутгийн аялгуу, аман зохиол судлах шинжилгээний анги, албан томилолтоор халх, ойрад, буриадын нутагт олонтоо очиж, Монгол хэлний угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас зохиолцсон бөгөөд Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн номын сан хөмрөгийг академич Б.Ринчен, академич Д.Цэрэнсодном, доктор Ж. Цолоо нартай гар

⁸⁹ Ж.Цолоо “Монгол улсын шинжлэх ухаан 11”.2009, -р тал

нийлэн бүрдүүлсэн байдаг. Тэрбээр “Торгууд аман аялгууны онцлог” гэдэг зохиолоо бичихээр Монгол улсын торгуудын нутагт албан томилолтоор хоёр удаа очиж, хамтарсан шинжилгээний ангид удаа дараа оролцжээ.

Доктор Д.Бадамдорж нь Өөлд салбар аман аялгууг судалж хэд хэдэн бүтээл туурвижээ. Монгол хэл аялгууны ойрадын нэгэн аман аялгуу болох өөлд салбар аман аялгууны авиа зүй, хэл зүй, үгийн сан, утга зүйн талаар 1993 онд “Өөлд аман аялгууны ойллого” нэг сэдэвт зохиол гаргасан байдаг. Энэхүү зохиолыг бичихийн тулд 1982-1993 оны хооронд Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын өөлдүүдийн аман яриа, ардын аман зохиол, үүх түүхийг сурвалжлан судлах шинжилгээний анги томилолтод биечлэн оролцжээ.

Эрдэмтэн Ж.Санжаа багш Монгол утга зохиолын хэлний үндсэн суурь аялгуу болох халх аялгууны авиа, авиалбар зүйг судлан онол, хэрэглээний суурь судалгааг удаа дараа зохиож хэвлүүлснээс гадна өмнө бидний өгүүлсэн өөлд аялгуутны салаа тасархай болсон Архангайн халхажсан өөлд аялгууг судалсан билээ.

Эрдэмтэн О.Самбуудорж нь “Монгол хэлний Ойрад аялгууны фонемын тогтолцоо” хэмээх ганц сэдэв зохиолоо 2002 онд гаргасан бөгөөд уг зохиолдоо Ойрад аялгууны фонемын тогтолцоог нэгтгэн судалж, Ойрад-Монголчуудын түүхэн тойм, сурвалж бичгийн дурсгал, аман домог зэргийг харьцуулан Монгол улсын хилийн цаанах ойрад монголчууд, Монголд оршин суудаг дөрвөд, торгууд, өөлд, захчин, урианхай, баяд, хотон нарын гарал, түүхийг бичгийн сурвалжуудаас эшлэн⁹⁰ өгүүлжээ. 1996 онд “Торгууд аман аялгууны тэмдэглэл” хэмээх бүтээлээ хэвлүүлсэн. Ойрад аялгууг судалсан түүх, ойрадын аман аялгууг ангилан судалсан гадаад, дотоодын 13 монголч эрдэмтний саналыг шүүн хэлэлцэж ойрадын аман аялгуу юм уу? Төрөл хэлнүүд үү? гэсэн нэгдмэл биш саналыг тодруулсан⁹¹ байна.

Пхофессор Ж.Цолоо “БНМАУ-ын нутгийн аялгуу” (1987) хэмээх эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээлдээ орчин үеийн монгол хэлний хэл зүй, авиа зүй, үгийн сангийн судлалын монголч эрдэмтдийн судалгааг цаашид улам гүнзгийрүүлж, Монгол улсын монгол хэлний нутгийн аялгууны шинэ ангиллыг журамлан тогтоосон нь хэрэглээний чухал ач холбогдолтой болсныг онцлон дурдалтай. “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг” (1988)-ийг халх аялгуу, ойрад аялгуу, буриад аялгуу гэсэн гурван ботиор туурвиж хэвлүүлэх анхны санал санаачлагыг профессор Ж.Цолоо дэвшүүлэн гаргаснаар барахгүй энэхүү орос хэлний хадмал орчуулга бүхий гурван боть толь бичгийг туурвиж нийтлүүлэх судалгааны “чимхлүүр” нүсэр ажлыг биечлэн эхлүүлж, бодит ажил хэрэг болгожээ. Эл суурь судалгааны бүтээлийн I хэсэг болох халх аялгууны нэгдүгээр ботийн хянан тохиолдуулагчаар академич Д.Төмөртоогоо, доктор Г.Лувсан, II хэсэг болох ойрад аялгууны хоёрдугаар ботийн хянан тохиолдуулагчаар доктор Х.Лувсанбалдан, III хэсэг болох буриад аялгууны гуравдугаар ботийн хянан тохиолдуулагчаар судлаач Н.Шарав-Иш ажилласан нь уг гурван боть толь бичгийн чанар чансаанд сайнаар нөлөөлсөн нь дамжиггүй.

⁹⁰ Ж.Цолоо “Монгол улсын шинжлэх ухаан 11”. 2009, 172-р тал

⁹¹ О.Самбуудорж “Монгол хэлний ойрд аялгууны фонемийн тогтолцоо”. Уб., 2002, 23-р тал

Академич Л.Болд Монгол улс дахь нутгийн аялгуу судлалын тоймыг “Хэл шинжлэлийн асуудлууд”, (Уб., 2006), Д.Төмөртоого Орчин цагийн монгол хэл аялгууны тоймыг “Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс” (Уб., 2017), Ж.Цолоо, Ж.Ганбаатар, С.Энхжаргал Монгол хэлний нутгийн судлалын асуудлыг “Монгол улсын шинжлэх ухаан 11”(Уб. 2009) зэрэг бүтээлдээ бичжээ.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн үе үеийн эрдэмтдийн сурвалжилсан хээрийн шинжилгээний ангийн тайлан бүтээлийг нэгтгэн дүгнэх, тэдний хийсэн бүтээснийг цааш улам баяжуулан судлах, хувьсал өөрчлөлтийг цаг алдалгүй нээн илрүүлэх цаг нэгэнт иржээ.

Нутгийн аялгуу нь тухайн ард түмний түүх соёлыг тээн хадгалж байдаг өвөрмөц онцлогтой бөгөөд тухайн хэлэлцэгчдийн нийгэм соёлын өөрчлөлтийн тусгал, улиран өнгөрсөн он жилүүдийн түүхэн ул мөрийг агуулж гэрчлэх хэрэглэгдэхүүн болж үлддэг. Өнөө цагт нутгийн аялгуу судлалын талаар ихээхэн ач холбогдол өгөхөө больчихсон бөгөөд түүхэн хэл зүйн нутгийн аялгууны салбарт шинэлэг уур амьсгалыг оруулах цаг нэгэнтээ ирсэн гэдгийг өмнөх болон одоо цагийн эрдэм судлаач, багш нар минь хэлж байгаа нь үнэний ортой юм. Нутгийн аман аялгууг нийгмийн хэрэглээний түвшинд хэрэглээ хийгээд нийгэм хэл шинжлэлийн талаас нь авч үзэж болохоор байна.

Нутаг нутгийн аман аялгуугаар хэлэлцэгчдийн өвөрмөц аялгуу нь нийгэм цаг үеэ даган хувьсан өөрчлөгддөг жам ёсны асуудал тул өнөө цагт дахин өнгөрсөнтэй нь харгуулан зэрэгцүүлж авч үзвэл нэн сонирхолтой байна гэдэгт бүрнээ итгэлтэй байна.

Ном зүй

1. Ш.Лувсанвандан. Монгол хэл аялгууны учир “Монгол судлал I-р боть”, Уб., 1959
2. Д.Цэнд “Монгол хэлний нутгийн аялгуу судлалын тойм”, Уб., 1959
3. Э.Вандуй “Дөрвөд аман аялгуу”. Уб., 1965
4. Б.Ринчен “Монгол ард улсын хамниган аялгуу”. Уб., 1969
5. Ш.Барайшир “Халхын аялгуу”. Уб., 1970
6. Б.Ринчен “Монгол Ард Улсын Угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”, Уб., 1979
7. С.Мөөмөө, Ю.Мөнх-Амгалан “Орчин үеийн монгол хэл аялгуу”. Уб., 1984
8. Ж.Цолоо “БНМАУ дахь монгол хэлний нутгийн аялгууны толь бичиг II”, Ойрд аялгуу., Уб., 1988
9. Ш.Лувсанвандан “Монгол хэлний авиан зүйн онол практикийн асуудлууд”. Уб., 2002
10. О.Самбуудорж “Монгол хэлний ойрд аялгууны фонемийн тогтолцоо”. Уб., 2002
11. Л.Болд “Монгол хэл шинжлэлийн асуудалд”. Уб., 2006
12. “Монгол улсын Шинжлэх ухаан, 11, Монгол нутгийн аялгуу судлал” 2009
13. Г.Гантогтох “Буриад аялгууны толь”. Уб., 2010
14. Ж.Цолоо “Орчин цагийн монгол хэлний нутгийн аялгуу”, Уб., 2011
15. Д.Төмөртоогоо “Монгол хэлний түүхэн авиа зүйн үндэс”. Уб., 2017

БАРГА БУРИАД АЯЛГУУНЫ ОНЦЛОГ

Д.Содон⁹²

Хятад улс дахь монгол хэлний нутгийн аялгууг барга буриад аялгуу, өвөр монгол аялгуу, ойрад аялгуу хэмээн гурав хуваадаг бөгөөд барга буриад аялгууг бас зүүн хойд аялгуу ч гэж нэрлэдэг. Барга буриад аялгуу гэдэг нь голдуу Хөлөнбуйр хотын Шинэ барга зүүн хошуу, Шинэ барга баруун хошуу, хуучин барга хошуу болон Эвэнк үндэстний өөртөө засах хошуу, Хайлаар зэрэг газрын барга буриадуудын хэл яриаг хэлж байна. Барга буриад аялгууг үндсэндээ шинэ барга, хуучин барга ба буриад гэх гурван аман аялгуунд хувааж үздэг. Шинэ барга аман аялгуугаар Шинэ барга зүүн, Шинэ барга баруун хошууны барга монголчууд ярилцана. Хуучин барга аман аялгуугаар хуучин барга хошууны барга монголчууд ярилцана. Буриад аман аялгуугаар Эвэнк хошууны Шинэхэн зүүн сум, Шинэхэн баруун сум, Мөнгөнчулуу сум, Баянтал сумын буриадууд ярилцана.

Баргачууд XI, XII-р зууны үед Байгал нуурын зүүн этгээд Баргужин төхмөөр нутаглаж байжээ. XVII-XVIII зууны үед Оросын эзэнт гүрэн газар нутгаа тэлэхэд түрэгдэн Баргужин төхөм нутгаа орхин Халхын Цэцэн хан аймагт ирэв. XVIII зуунд Манжийн Найралт төв хаанд өргөн мэдүүлснээр Хөлөнбуйрт нүүдэллэн ирж, чингээд 1732 онд ирснийг нь Хуучин барга гэж, 1734 онд ирсэн нь Шинэ барга хэмээн нэрийддэг болов.

Буриад дотроо сонгоол буриад, агын буриад, хорь буриад гэж хуваагдана. Шинэхэн буриад нь хорь буриадаас гаралтай бөгөөд XX зууны эхээр Өвөр Монголын Хөлөнбуйрт нүүн очжээ. 2000 оны бүртгэлийг үндэслэвэл Барга буриад аялгуутан БНХАУ-д нийт 110 мянга бий.

Барга буриад аялгууны онцлог

Нэг. Авианы онцлог

1. Эгшиг авиа

А. Богино эгшиг

Барга буриад аялгуу нь а э и о у ү гэсэн зургаан богино эгшиг авиалбартай. Барга буриад аялгууны богино эгшгийн талаарх онцлогтой зүйл гэвэл:

Тус аялгуунд биеэ даасан урагшилсан богино эгшиг авиалбар байдаггүй. Жишээ нь:

аймаг aimag

хатираа хатра:

найр pair

⁹² МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн Ухааны салбар

Тус аялгуунд *õ* эгшиг байхгүй. Бичгийн хэлний *õ* эгшгийг бүр *ü* гээр авиалдаг.

Жишээ нь:

Өвөр *üwær*

Өв *üw*

Өндөр *ündær*

Бичгийн хэлний зарим үгийн эхэн ба дунд орсон “э” эгшиг хуучин барга аман аялгуунд *i*-гээр авиалагдах үзэгдэл буй. Жишээ нь:

Эзэн *idzæn*

Бэлэн *bilæn*

Хэл *xil*

Үнэн *uniŋ*

Б. Урт эгшиг

Барга буриад аман аялгуу нь *a: ɛ: i: o: u: ɔ: ʉ: e:* 8 урт эгшигтэй, *e:* нь зөвхөн үгийн эцэст илэрнэ. Жишээ нь:

та нар *ta:nar*

Чи *ʃi:*

Хээр *xə:r*

Ховоо *xowo:*

Уул *u:l*

Үзжээ *udzdʒe:*

Барга буриад аялгууны хос эгшиг нь урагшилсан хос эгшиг болоогүй. Жишээ нь:

Аймаг *aimag*

Найр *nair*

Нойр *noir*

Могой *mogoi*

Тус аялгуунд бас *-uai-* гэдэг гурамсан эгшиг байдаг. Энэ нь голдуу хуучин барга аман аялгуунд тохиолддог. Жишээ нь:

Уйлах *uailax*

Уйтгар *uaitxar*

Гуйранч *guairanʃ*

2. Гийгүүлэгч авиа

Барга буриад аялгуунд нийт *n, b, p, x, h, g, ʃ, ɕ, m, l, s, t, d, ɬ, ɟ, ɳ, j, r, ʎ, ʈ* гэсэн 20 гийгүүлэгч авиалбар бий. Барга буриад аялгууны гийгүүлэгч авианы онцлог гэвэл:

А. Бичгийн хэлний нилээд тооны үгийн “*c(s)*” гийгүүлэгчийг *x(h)* гийгүүлэгчээр авиалдаг. Жишээ нь:

Сар	har
Сайн	haiŋ
Санаа	hanaa
Сээр	heer
Нас	naɦa:
Сүүл	hù:l

Б. Бичгийн хэлний “ц” ба “ч”-ийг [s] [ʃ] [tʃ]-ээр авиалах тохиолдол байна.

Жишээ нь:

Цас	saxa~sahaŋ
Цаг	sag
Эмч	эмʃ
Ирчих	jərtʃəg
Царай	ʃarai

В. Бичгийн хэлний зарим үгэн дэх “с” авиаг t, d-гээр дууддаг. Жишээ нь:

Хөмсөг	xumtəg
Гишгэ	gitəg
Улс	uld
Бос	bod

Г. Хуучин барга аман аялгуунд “ц”-ийг -s- гээр авиалдаг. Жишээ нь:

Цоохор	so:xor
Гагц	gans
Нагац	nags
Цэцэг	səsəg

Д. Төв халх аялгуунд байдаг -з- гийгүүлэгчийг хуучин барга ба шинэ барга аялгуунд -ɖz- -ɖz- гээр авиалж буриад аман аялгуунд -z- -z- гээр авиалдаг. Жишээ нь:

Газар	gaɖzar ɢazar
Хэзээ	хэɖzə: хəzə:
Баз	baɖz baz

Е. Үгийн эцсийн -г- гийгүүлэгчийг ɢ буюу g гээр тод ялган авиалдаг.

Жишээ нь:

Бага	baɢ
Баг	baɢ
Барга	baɢaɢ
Бараг	baɢaɢ

3.Эгшгийн зохицол

Барга буриад аялгууны эгшгийн зохицол нэлээд чанга, жигд байдаг.

- (1) Үгийн эхэнд нь а а: u u: байвал, арын үед нь а а: u: i i: ai e: ui үе: гэх зэрэг эгшиг ордог.
- (2) Үгийн эхэнд нь о о: oi байвал, арын үед нь о о: oi ui а: e: i: u: үе: гэх зэрэг эгшиг ордог.
- (3) Үгийн эхэнд нь э э: e: i i: ù: ùi байвал, арын үед нь э э: e: i i: ù: ùi гэх зэрэг эгшиг ордог.

4. Авианы хувирал

А. Авиа ижилсэх

Тус аялгуунд “᠓” нь “d” авиатай ижилсээд “n” болох зэрэг авиа ижилсэх тохиолдол бий. Жишээ нь:

Оронд $oro᠓+d \rightarrow orond$

Б. Авиа гээгдэх

Зарим үгэнд -с- -саар- -сан- зэрэг дагаврын [s] авиа нь гээгдэх тохиолдол бий.

Жишээ нь:

Арьс агу:

Хус ху:

Оосор о:г

Явсан jowo: ᠓

Бодсоор bodo:г

В. Бичгийн хэлний зарим үгний -b- гийгүүлэгч гээгдэх тохиолдол бий.

Жишээ нь:

Өвчүү uᠫᠤ:

Өвч uᠫ

Г. Авиа солигдох

Цөөвтөр үгэнд бичгийн хэлний “л” авиа нь -г- болж дуудагддаг.

Жишээ нь:

Сууж байтал suudʒ baitar

Чамайг явтал ʃami: jowtor

Д. “Ч” гийгүүлэгчийг [ʃ] -гээр авиалах тохиолдол бий.

Жишээ нь:

Чи ʃi:

Чармай ʃarmai

Чадаагүй ʃada:güe:

Хоёр. Үгийн сангийн гол онцлог

1. Эртний үгс

Барга буриад аялгуунд эртний үгс олон тохиолддог. Жишээ нь:

- bədə:rex гэдэг үг нь эрэх гэсэн утгатай бөгөөд “Монголын нууц товчоон”-д тэмдэглэгдэж үлджээ.

- tuga:ɣ гэдэг үг нь саяхан гэсэн утгатай бөгөөд “Монголын нууц товчоон”-д тэмдэглэгдэж үлджээ.

2. Өвөрмөц үг

агаалж awa:xaɪ

ухна təx

ялаа borgu:

3. Утга ондоо үг

батгана ʃumu:

нүүдэл zɔːdəl

толь ɡərəl

ядах əsəx

4. Зээлсэн үг

Барга буриад аялгуунд хятад, орос, манж зэрэг хэлнээс зээлсэн үгс олон бий. Жишээ нь:

Төмс tʉːdʉːs (хятад)

Сүнх sʉŋk (орос)

Сонин ɡadʒaːd (орос)

Ном зүй

М.Баатар, Б.Сод “Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл”

ОРЧУУЛГА БА АЛШАА ЭЗНЭЭ АМАН АЯЛГУУНЫ ОНЦЛОГ

Б.Яруу⁹³

1. Удиртгал

Дэлхийн орчуулгын өдрийг тохиолдуулж би орчуулгатай холбоотой хэдэн юм хэлмээр байна. Би бол багаасаа монгол сургуульд суусан, Өвөр Монголын монгол хүүхэд билээ. Гэтэл орчин тойрон, уулзаж учирч байгаа хүмүүс маань олонх нь хятад хүн болохоор заримдаа ямар нэг зүйлийг хятадаар унших нь надад илүү ойлгомжтой мэт бодогддог. Тэгээд Монголд ирсний дараа хичээлийн даалгаварт Галидасын “Үүлэн зардас” бүтээлийг унших шаардлагатай болов. Эхлээд би хятадаар уншсан. Дараа нь Бямбын Ринчен гуайн монгол орчуулгыг нь уншихад үнэхээр миний сэтгэлд хүрсэн гэдгийг юу нуух билээ. Сайн орчуулга гэдэг нь нэг нэг үсгээр махчилж орчуулах биш, харин тухайн үндэстний хэлэнд ойрхон, ойлгомжтой орчуулж чаддаг болохоор уншигчийн сэтгэлд хүрдэг юм байна гэдгийг мэдлээ.

Алшаа аман аялгуу бол Өвөр Монгол аялгууны баруун захын аман аялгуу болно. Алшаачууд бол алс баруунтай Шинжаан, Хөхнуураас урьд хожид нүүдэллэж ирсэн ойрад монголчууд гэдэг. Тийм болохоор Алшаа аман аялгуу ойрад аялгуутай нэлээд төстэй болж, харин Өвөр Монголын бусад аман аялгуунаас ялгарах онцлог нэлээд арвин байдаг.

2. Алшаа аймгийн тухай товч танилцуулга

Алшаа аймаг бол БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны хамгийн баруун захын аймаг бөгөөд 267.574 км² талбайтай. Хойд хэсгээрээ Монгол Улсын Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай аймагтай хиллэдэг. Өвөр Монголд хамгийн том засаг захиргааны нэгж боловч хамгийн цөөн хүн амтай аймаг юм. 2018 оны бүртгэлд үндэслэвэл, Алшаа аймаг нийт 250,000 хүн амтай. Үүнд Хятад, Монгол, Манж, Төвөд, Хотон, Монгор буюу Цагаан монгол зэрэг үндэстэн багтана. Халх, торгууд, буриад, барга зэрэг ястнууд оршин суудаг. Үүний дунд зөвхөн 22.74% нь Монгол үндэстэн билээ.

Алшаа аймаг нь Алшаа зүүн хошуу, Алшаа баруун хошуу, Эзнээ хошуу хэмээх гурван хошуутай. Алшаа зүүн, баруун хошуунд хошууд ястан, Эзнээ хошуунд торгууд ястан гол цөм нь болдог.

⁹³ МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбар

3. Алшаа гэдэг үгийн гарлын тухай

Алшаа гэдэг үгийн гарлын тухай хэд хэдэн зүйлийн тайлбар байдаг билээ. Алшааг хятад хэлний Хө Лань Шань (贺兰山) гэдэг уулын нэрээс гаралтай гэж олонх эрдэмтэд үздэг. Хө Лань Шань-г монголчууд Алшаа уул буюу Хулан уул гэдэг.

4. Алшаачуудын гарал үүсэл, түүхийн тухай

Холбогдол бүхий материалд үндэслэвэл, Алшаа аймагт суурьшин амьдарч байгаа монголчуудын зонхилох хэсэг нь 300 гаруй жилийн өмнө Гэгэн гүүш хаан Төрбайхын хойч үе болох Эрх жононгийн Алшаад дайчлан дагуулж ирсэн хэсэг бүлэг хошууд ба өөлд ястны хойч үе болно. Арваннайм дугаар зууны эхээр Манж Чингийн төрийг дагасан хэсэг бүлэг торгуудчууд Цэвээнравдангаас зугтаан зайлахын төлөө бас Эзнээ голын дунд ба доод урсгал дагуу суурьшин амьдрах болжээ. Одоогийн Эзнээ хошууны торгуудчууд бол тэдний хойч үе болно.

Бас зарим хүмүүс Алшаачууд бол 300 гаруй жилийн өмнө алс баруунтай Шиньжян, Хөхнуураас урьд хожид нүүдэллэж ирсэн ойрад монголчууд гэдэг.

5. Алшаа аман аялгуу буюу Алшаа эзнээ аман аялгуу

Алшаа аман аялгуугаар ярилцагчид одоогийн Алшаа зүүн, баруун, эзнээ хошуугаар нутаглан сууж байна. Аялгууны газарзүйн байршлаар Алшаа аман аялгууг бас Алшаа эзнээ аман аялгуу гэж нэрлэдэг. Алшаа эзнээ аман аялгуу бол монол хэлний нутгийн аялгууны доторх нэлээд өвөрмөц онцлогтой аман аялгууны нэг болох юм. Өвөр Монгол аялгууны онцлог шинж, ойрад аялгууны онцлог шинжийг зэрэг хадгалсан болохоор зарим эрдэмтэн Алшаа эзнээ аман аялгууг бас Өвөр монол аялгуу ба ойрад аялгууны завсрын шинжтэй аман аялгуу гэж үзсэн байдаг.

6. Алшаа эзнээ аман аялгууны авиазүй, үгийн сангийн онцлог

Авиазүйн гол онцлог

Эгшиг авианы талаар:

(1) Алшаа эзнээ аман аялгуу а, е, i, э, v, ө, у, æ гэх найман богино эгшиг авиалбартай. е эгшигийн талаар Алшаа эзнээ аман аялгуу өвөрмөц онцлогтой. Дуудлага нь ойрад аялгууны е -тэй адилавартай байж, голдуу үгийн эхэн ба дунд тохиолдоно. ек--эх екке:---эрхий гэх мэт.

(2) æ эгшиг бол бичгийн хэлний хоёр, гуравдугаар үеийн i эгшигийн нөлөөгөөр үгийн эхний үеийн а эгшиг урагшилсны үр дүнд бий болжээ. Дуудлага нь ойрад аялгууны æ -тай адил, үгийн эхний үед тохиолддог. Жишээ : хæг -харь tæmir - тамир гэх мэт.

Гийгүүлэгч авианы талаар:

Алшаа эзнээ аман аялгууны гийгүүлэгчийн авиалагдах байдал нь бичгийн хэл буюу бусад аялгуу, аман аялгууны гийгүүлэгчтэй үндсэндээ таарч байдаг.

Харин g, k, ts, dz дөрвөн гийгүүлэгчийн талаар онцлогтой зүйл байдаг .

⊖ Алшаа эзнээ аман аялгуунд монгол хэлний эхэнд ордог х гийгүүлэгчийг k-р авиалдаг үзэгдэл тодорхой оршдог. Голдуу эм үг буюу хөндий үгэнд тохиолддог. Заримдаа бас эр үгийн i эгшгийн өмнөх х гийгүүлэгчтэй тохиролцоно.

kel--хэл takа: -- тахиа ʃik--чих гэх мэт.

⊖ Монгол бичгийн хэлний ʃ гийгүүлэгч нь Алшаа эзнээ аман аялгуунд ʃ, ts болон салбарлажээ. Өвөр Монголын баримжаа авианд цөм ʃ-р авиалдаг бол, Алшаа эзнээ аман аялгуун дахь ʃ гийгүүлэгчийн авиалагдах байдал нь ойрад аялгуу, халх аман аялгуутай ижил байна. tsas -- цас ʃulu: --- чулуу гэх мэт.

⊗ Монгол бичгийн хэлний dz гийгүүлэгч нь Алшаа эзнээ аман аялгуунд мөн хоёр салбарлаж dz болон dz болжээ. Энэ нь ойрад аялгууны z гийгүүлэгчтэй их төлөв адил байж, Өвөр Монголын авга, сөнөд болон халх аялгуутай ч адилхан байна. Жишээ нь: dzol:--жолоо, dzol---зол гэх мэт.

④ Үүнээс гадна, Алшаа эзнээ аман аялгуунд “ G,γ ” хоёр гийгүүлэгчийг тодорхой ялган авиалдаг бөгөөд тус хоёр гийгүүлэгч нь үгийн эцэст утга ялгах үйлдэлтэй байдаг. Энэ нь кирил бичиг дэх хэлний “ г ” ба хоолойн “ г ” гэдэгтэй төстэй байна. Жишээлбэл:

Gar-гар arγal- аргал

baG - баг baγ- бага гэх мэт.

Үгийн сангийн онцлог

1. Алшаа эзнээ аман аялгуу нь бусад аман аялгуутай харьцуулбал өвөрмөц үгс харьцангуй олон байдаг.

Алшаачууд

⊖ толь гэдэг үгийг нүүрийн гэр гэж

⊖ хөөрхөн гэдэг үгийг барамхан гэж

⊗ алиа гэдэг утгатай үгийг елдэн гэдэг.

④ Үүний дунд бас ондоо утгат үг байдаг. Өвөр Монгол даяар нүдэн шил гэхэд, Монгол Улсад нүдний шил гэхэд, Алшаад саравч гэдэг.

2. Эртний зохиол, сурвалж бичигт илэрдэг зарим үгс Алшаа нутгийн монголчуудын дунд одоо болтол уламжлагдан хэрэглэгдсээр ирсэн жишээ олон байна. Жишээлбэл:

⊖ үрүүн — “ Монголын увш хун тайжийн тууж” гэх номд энэ үг өглөө гэсэн утгаар илэрсэн бол Алшаад мөн адил утгаар хэрэглэгдсээр эдүгээ хүрсэн билээ.

⊖ дэлтэр — дэлтрийг “ жангар ”номд эмээлийн хамгийн доор нь тохдог эсгийг зааж байсан бол Алшаачууд мөн эмээл тохмын доорх эсгийг дэлтэр гэж нэрлээд он уджээ.

3.Ер нь бурхны шашин Алшаа нутагт дэлгэрээд 300 гаруй жилийн түүхтэй болжээ. Яг ийм учраас Алшаа аман аялгуунд бас төвөд хэлнээс зээлсэн үг, төвөд гаралтай үг олон байдаг. Жишээлбэл:

Зэд тавих: түгээл өгөх

диграа: орос зүү

гүнцэг: лам нарын үдийн хоолны хүндэтгэл,

Цав: лам хуврагийн зоог зэрэг үгийг нь Алшаачууд өдөр тутмын амьдралдаа “та минь гүнцгээ барих юм уу?”, “Цаваа барих цаг болжээ” гэж шилжсэн утгаар нь хэрэглэдэг билээ.

4.Алшаа монголчууд нь оршин сууж байгаа орчин тойронд хятад үндэстний нөлөөнд автсанаас Алшаа аман аялгуунд бас хятад хэлнээс зээлсэн үг олон болсон байдаг. Үүнийг хотод амьдардаг монголчуудын ярианаас илүү мэдэж болно. Жишээ нь:

Пэнз (盆子) панз (盘子) ан бан (案板) хэмээн өдөр тутмын амьдралын аар саар зүйлүүдээ шууд хятадаар ярьдаг онцлогтой.



7. Дүгнэлт

Орон нутгийн онцлог шинжийг бүрэн хадгалсан ийм сайхан нутгийн аялгуугаа хамгаалж, өвлөж, хөгжүүлэх нь монгол хүн нэг бүрийн дархан үүрэг билээ. Энд Алшаа нутгийн малчин зохиолч Бармадын Улаанхүүг дурдах ёстой. Энэ хүн бол нутгийн аялгуугаараа зохиол бүтээлээ туурвидаг онцлогтой. Нэг талаар энэ нь мөн нутгийн аялгуугаа хамгаалж хөгжүүлж байгаа явдал гэж би боддог. Мэдээллийн зууны өрсөлдөөний дунд Монгол хэл, нутгийн аялгуугаа хэвээр хадгалан байлгая гэвэл орчуулгын ажилтай холбож, улам олон хүмүүст Монгол хэл, нутгийн аялгуугаа ойлгуулах нь чухал болов уу гэж би боддог юм.



Ном зүй

1.“Монгол хэлний нутгийн аялгууны шинжлэл”---М.Баатар. Б.Сод

2.“Алшаа аман аялгууны судлал”---Н.Гэрэлт



ДУРТГАЛ



МОНГОЛ ХЭЛ, АЯЛГУУНЫ ТУХАЙ ААВЫН МИНЬ ИЛТГЭЛ

Л.Маналжав⁹⁴

(2019 оны 9 сарын 26-ны өдөр МУИС-д болсон Орчуулгазүйн Профессорын багийн их семинарыг хөтлөхдөө хэлсэн үгээс)

Өнөөдөр энэ билигт сайн өдөр их сайхан арга хэмжээ болж байна. НҮБ-аас 2019 оныг “Уугуул үндэстний хэл соёлыг хамгаалах жил” болгож зарласан. Нэгдүгээрт бол үүнд зориулсан, хоёрдугаарт бол дэлхийн орчуулгын өдөр энэ 9 сарын 30-нд юм байна. Энэ хоёр үйл явдалтай холбогдуулж МУИС-ийн ШУС-ийн Гадаад хэлний орчуулгын профессорын хамтлагаас санаачилж, өнөөдрийн энэ их семинарыг зохиож байна. Сэдэв бол “Нутгийн аялгуу судлал ба орчуулгазүй”.

Энд би хурал хөтөлж байгаа завшааныг ашиглаж бас нэг зүйлийг нэмж хэлье гэж бодож байна. Юу гэхээр одоогоос 60 жилийн өмнө 1959 онд Монголч эрдэмтдийн анхдугаар хурал болж байсан. Үүнийг ахмад үеийн судлаачид, багш, эрдэмтэд сайн мэдэх байх, залуучууд номоос олж үзээгүй бол нэг их сайн мэдэхгүй байж магадгүй. Тэр хурал бол үнэн хэрэгтээ хэл, монгол хэл бичгийн эрдэмтдийн хурал байсан. Тэр битгий хэл хурлын дараа эрдэмтдээс бичсэн тэмдэглэл, дурсамж дотор харахад, жишээлбэл Г.Д.Санжааев гуайн бичсэн дурдатгал, Ю.Н.Рерих гуайн бичсэн дурдатгал дотор юу гэж бичсэн гэхээр тэр үед нийт 33, зарим нь 33 гэдэг зарим нь 34 илтгэл тавигдсан байна гэсэн байдаг. Гадаад дотоодын эрдэмтдийн гол илтгэлийг энд хэлж байгаа юм. Үүнээс 20 нь хэлшинжлэлийнх байсан. Ерөөсөө хэл шинжлэлийнх түлхүү байжээ. Тэгээд тэр монгол хэлээ тойрсон 20 илтгэл байж. Заримыг нь дурдахад, Ю.Н.Рерих гуайн төвөд хэлэнд орсон монгол үг ч гэдэг юм уу, Ц.Дамдинсүрэн гуайн монгол хэлэнд орсон төвөд үгийн тухай. Миний аавын тавьсан илтгэл бол “Монгол хэл аялгууны тухай”, яг монгол нутгийн аялгууны тухай илтгэл байлаа. Тэгээд Г.Д.Санжааев гуай сүүлд бичсэн тэмдэглэл дотроо энэ хурал бол ерөнхийдөө хэл шинжлэлийн хурал байсан тэр дотроо монгол хэлний нутгийн аялгуунд зориулагдсан хурал болсон гэж хэлсэн байдаг юм. Яагаад гэхдээ зэрэг, тэр дотор баарин аялгууны тухай Чингэлтэй гуайн нутгийн аялгууны асуудлаар мөн илтгэл тавьсан, Ц.Б.Цэдэндамбаев гуай бас илтгэл тавьсан. Ерөөсөө цөмөөрөө бараг л тийм сэдэвтэй илтгэл тавьсан юм байна лээ. Дандаа монгол хэлтэйгээ холбоотой, тэгээд тэр дундаа нутгийн аялгуутай холбоотой илтгэлүүд байж.

Энд нэг зүйлийг мартаагүй дээрээ, хэдийгээр өөрөө илтгэл тавиагүй ч гэсэн та бүхэндээ дуулгаж санал бодлоо солилцье гэж бодлоо. Сая манай эрдэмтэн судлаачид их юм хийжээ, ялангуяа тэр Хэл зохиолын хүрээлэнд хадгалагдаж байгаа нутгийн аялгууны материал бол үнэхээр их үнэ цэнтэй зүйл. Миний багш Б.Ринчен багшийн хийж байсан юмыг би аспирант байх үедээ хажуунаас нь харж

⁹⁴ Доктор, профессор, “Боловсрол сургалтын хүрээлэн” ТББ, УЗ-ийн тэргүүн

байснаа санаж байна. Гэхдээ өөр сэдэвтэй байсан учраас даанч харамсалтай нь тэрийг их онцолж сонирхож байсангүй. Монгол хэлний угсаатны зүй, хэл шинжлэлийн атлас бол үнэхээр хосгүй бүтээл гарч байлаа. Тэрийг бол Б.Ринчен багш удирдаад ерөөсөө эрдэмтдийн, судлаачдын баг тэрийг хийсэн. Тэр дотор бол Б.Ринчен багшийн шавь Ц.Шагдарсүрэн доктор, Х.Лувсанбалдан гуай гэх мэт олон улсууд оролцсон. Тэгээд нутгийн аялгуу, аман зохиол, этнографийн маш үнэтэй цэнтэй материал бол тэр хоёр саяын М.Очирцэндийн (*ШУА-ын Хэл Зохиолын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, их семинарын гол илтгэгч*) дурдсан бүтээл дотор бол байгаа. Тэнд М.Очирцэнд бас нэг зүйлийг хэллээ монгол хэлний нутгийн аялгууг ангилахад академич Ш.Лувсанвандан хамгийн оновчтой санал дэвшүүлсэн гээд товчхон дурдаад өнгөрлөө. Энэ талаар би та нарт сонирхуулж нэг юм ярья. Юу гэхээр зэрэг 1959 оны монголч эрдэмтдийн хурал дээр монгол хэлний нутгийн аялгууны тухай илтгэл тавьсан академич Ш.Лувсанвандан бол миний эцэг. Тэр хуралд манай эрдэмтэд маш их чамбай бэлдсэндээ ер нь. Сэдвийг бол тэр битгий хэл Б.Ринчен багш бараг санал болгосон. Та одоо нэг ийм юм хийгээч гээд. Тэгээд энийг аав бол их нухацтай бэлдэж байсныг би оюутан байсан ч гэсэн санаж байна. Аавын ангилсан тэр ангиллыг та нарт зүгээр товчхоноор танилцуулж хэлье. Тэр нь юу вэ гэхээр ерөөсөө монгол нутгийн аялгууг дөрвөн хэсэгт хуваасан, нэг нь төв монгол аялгуу. Төв аялгуунд юу орж байсан бэ гэхээр, халх аялгуу мэдээжийн хэрэг, ордос, цахар гол төлөөллүүд нь энэ. Тэрнээс гадна өрнөд аялгуу. Өрнөд аялгуундаа бол манай нутаг дээрх ойрад аялгуунаас гадна шинжааны торгууд, шинжааны ойрад, ижил мөрний халимагуудын аялгууг оруулсан байсан. Баруунд нь тийм ээ. Дорнод аялгуу нь бол харчин, хорчин гол төлөөллийг багтаасан. Умардад бол Байгалийн өмнөд, хойд биеийн буриадуудыг гол төлөөллөө болгоод оруулсан. Мөн энэ дөрвөн том ангиллын завсрын аман аялгууны тухай ч тодорхой хэлсэн байдаг. Профессор Ш.Лувсанвандан илтгэлдээ юу гэсэн бэ гэхээр ерөөсөө монгол хэл бол нэгдмэл гэсэн тийм санал дэвшүүлсэн байдаг. Аав бүр илтгэлдээ “Их гүрэн задарснаас хойш, монгол туургатны дунд харилцаа байсан, нэгдмэл дундын бичгийн хэлтэй, чөлөөтэй харьцдагт нь тулгуурлаж, монгол хэл бол нутгийн аялгуунуудтай, тэдгээр нь төв аялгуу, өрнөд монголын аялгуу, дорнод монголын аялгуу, умард монголын аялгуу гэж ангилсан” гэж дурдсан. Ингэж хуваасан ч монгол хэл бол ерөөсөө нэгдмэл нэг хэл юм гэж үзсэн. Ганцхан зүг чигээр хувааж болох нь хэдэн учиртай. Сая М.Очирцэнд бол яг зөв ярьж байна л даа. А.Д.Руднев, Н.Поппе, Г.Д.Санжеев гээд олон эрдэмтэн монгол хэл аялгууны ангиллыг хийсэн байсан, А.Д.Руднев, Б.Я.Владимирцов хоёр бол монгол хэл аялгууг ерөнхийдөө зүг чигээр нь л бас ингээд хуваачихсан бөгөөд нэг л хэл гэж үзсэн нь хамгийн гол нь юм. Ер нь монголч эрдэмтдийн хурал их амжилттай болсон. Дараа нь гадаадын хэвлэлд хурлын талаар мэдээлэл гарсан байдаг. Зөвхөн Зөвлөлт Холбоот Улс гэхэд л “Вопросы языкознания” гэдэг маш нэр хүндтэй сэтгүүлд Г.Д.Санжеев гуай “Монголд анх удаа ийм хэл шинжлэлийн хурал боллоо, монгол хэл шинжлэл хөгжиж байна гэж бичсэн. Юрий Рерих гуай “Проблемы востоковедения” дотроо бичсэн байна лээ. За энэ хоёр эрдэмтэн хурлын тухай их сайхан бичсэнийг бид нар олж үзэж байсан. За Г.Д.Санжаев гуай бол аавтай санал нийлэхгүй байсан.

Тэр нь бол ерөөсөө онолын асуудал. Юу гэхээр зэрэг, тэр үед бид нар ч гэсэн хэл шинжлэлийн хичээлд бол яг л тэгж үзэж байсан шүү дээ, энэ нутгийн аялгуу гэдэг бол ер нь овог аймагтай шууд холбоотой, одоо ер нь засаг захиргаатай холбоотой юм шиг тийм ээ, одоо тийм овог аймаг бол тийм аялгуутай гээд тогтчихсон, ингээд засаг захиргаатай нь холбочихсон байсан. Аавын ангилал бол юу гэхээр зэрэг, Монголд ерөөсөө хэл аялгуу хоорондоо хэр зэрэг ойлгогдож байна гэдгээр нь авсан. Хэлийг нь нэгдсэн хэл, нэг хэл гэдгээс л үндэслэж хуваасан юм байна лээ. Г.Д.Санжаев гуай бол аавыг шүүмжлэх маягтай тэр дотроо бичсэн. Академич Ш.Лувсанвандан нэг ийм илтгэл тавьсан гээд, тэгсэн мөртлөө их дэлгэрэнгүй танилцуулаад байгаа юм. Ингэж 4 хуваасан, тэгээд энэ нь бол аргументаци дутагдаж байна гэж хэлсэн байдаг. Дутагдсан гэсэн утгаар л хэлсэн л дээ. Энийг бол аргументациар баталгаажуулах хэрэгтэй. Гэтэл аавын илтгэл дотор аав бол Чингэлтэй гуайн судалгаан дээр үндэслэж ерөөсөө ямар ямар юман дээр аялгуунууд хоорондоо үгийн хэдэн хувь яг таарч байна вэ, хэдэн хувь зөрүүтэй байна вэ, хэдэн хувь нь одоо бүр өөр утгатай үг байна вэ ч гэдэг юм уу тийм маягаар хийсэн байдаг. Чингэлтэй гуайн судалгаан дээр үндэслэсэн юм байна лээ. Яг илтгэлийг нь унших юм бол тийм юм гарч гарч байгаа юм. Гэтэл Г.Д.Санжаев гуай бол жаахан одоо улс төрийн ч гэдэг юм уу жаахан тийм өнгө маягтайгаар академич Ш.Лувсанвандангийн илтгэлийг тэгээд улсууд нэг их хэлэлцэлгүй өнгөрчихлөө гэж бичсэн. Аан үнэн хэрэгтээ бол Ц.Б.Цэдэндамбаев гуай ч хэлсэн, Г.Д.Санжаев гуай өөрөө шүүмжилсэн ч гэсэн бас л одоо анхаарч, шүүмжлэх маягаар анхаарсан. Гэтэл Ю.Н. Рерих гуай бол юу гэж бичсэн бэ гэхээр, академич Ш.Лувсанвандан монгол хэлийг нэг хэл гэж тооцоод шинээр ангилал гаргаж ирсэн. Энийг бол цаашаа судалж үзэх нь зүйтэй юм байна гэж илүү дипломат маягаар бичсэн байна лээ. Тэгэхээр энэ бол эрдэмтдийн хоорондын байдаг л нэг мэтгэлцээн л дээ, Г.Д.Санжаев гуай бол тэгж шүүмжилж хэлэх нь ч зүйтэй байсан байж магадгүй. Юу гэхээр зэрэг, халимаг хэлийг тэр битгий хэл одоо бие даасан хэл биш юм, монгол хэлний нэг нутгийн аялгууг хэлнэ, буриадыг тэглээ гээд бүр яг ингээд шүүмжлээд биччихсэн байсан. Тэгэхээр энэ нутгийн аялгууны асуудал бол үнэндээ бас нийгмийн хэл шинжлэлийн нэг хэсэг, ерөөсөө бас юу гэдэг юм, одоо нийгмийн ухаантай холбоотой. Нийгэм түүх хөгжихийн хэрээр энэ бол өөрчлөгдөж байдаг юм байна. Аав бол монгол үндэстний тэр улс төрийн юманд нэг их ордоггүй байсан байгаа юм. Тэгсэн мөртлөө монголчууд үргэлж хоорондоо холбоотой байсан, шашин шүтлэгийн зорилгоор мөргөлд явж байсан, тэрнээс гадна жин тээж байсан, тэрнээс гадна түүхтэйгээ бас холбосон юм байж байгаа. 1920-оод оны үед бол буриадууд хойноос, Өвөрмонголоос Ар Монголд орж ирж байсан. 1930-аад оны үед бол Монголоос дүрвэж зөндөө улсууд урагшаа гарч байсан. 1945 онд бол Өмнөд Монголоос бас Монголд хүн орж ирж байсан. Тэгээд ер нь монголчууд бол үргэлж хоорондоо холбоотой байсан. Энэ бол одоо нүүдлийн соёл иргэншилтэй маань холбоотой. Тэгээд хамгийн сүүлд бичсэн нь бол Монгол-Орос, Орос-Монголын харилцаа сайн байна, аан бас Монгол-Хятад, Хятад-Монголын харилцаа сайн байна. Энэ нөхцөлд бол монгол үндэстний соёл энэ тэр бол цаашаа бие биендээ нөлөөлөх ёстой гэсэн тийм дүгнэлт гаргасан байна лээ. Их сонин ерөөсөө одоогийн бидний яриад байгаа юмтай адилхан юм хэлсэн

нь бас энэ манай том эрдэмтэд бол юмыг түрүүлж хардаг байсан байна гэж бодогдмоор. Хойч үеийн залуу судлаачид аавын энэ ангилал, бусад судалгааг үзсэн байх нь тааралддаг, тухайлбал, 2005 онд М.Хашимото, О.Самбуудорж нар Осакагийн Гадаад хэлний Их сургуульд хийсэн “Тод монгол үсгийн бичгийн хэлний тойм” зохиолдоо мөн аавын дэвшүүлсэн монгол хэл аялгууны тухай мөн тэмдэглэж оруулсан байдаг. За энийг би нэмж хэлье гэж бодлоо.

ТААРУУ ОРЧУУЛАГЧ БОЛОХ БИ БЭЭР ОРЧУУЛГЫН ТУХАЙ ЭРГЭЦҮҮЛЭН БОДОХ НЬ

Гэрэгэ / Gregory Pringle⁹⁵

Би 50 орчим жил орчуулгын ажил хийж байна. Орчуулгын сайн мууг яаж ялгах вэ, орчуулгын шинж чанар, холбоо хамаарлын талаар олж мэдэж, ажиглаж хуримтлуулсан бага сага туршлагадаа тулгуурлан энэ сэдвийг бичиж байна.

Гадаад хэл сурахад тус болох санаа

Бусад үеийнхэнтэйгээ адилхан, би дунд сургуульд гадаад хэл сурах үедээ орчуулгатай танилцсан юм. Тэр үед гадаад хэл заах нэг арга бол орчуулгыг загварчилж хийлгэдэг байлаа. Энэ талын дасгал бол үг нэг бүрийн утгыг нь ойлгож, мэдэж байгаа хэлзүйн бүтцийг ашиглан уялдаа, холбоотой өгүүлбэрийн утгыг мэдэж авахад тусалдаг байсан бөгөөд энэ нь яваандаа үгчилсэн орчуулга хийхэд хүргэдэг байв.

Энэ сурах аргад дутагдал байсан хэдий ч, ямартаа ч гэсэн гадаад хэлийг үндэс сууриар нь ойлгоход тустай арга байсан юм. Энэ нь гадаад хэлний хэлзүйн бүтцийг ерөнхийлөн ойлгох болон бага зэрэг болхи ч гэсэн гадаад хэлээр өгүүлбэр зохиох загвар болдог байсан. Тиймээс ахлах сургуульдаа би герман хэлний өгүүлбэрийн бүтцийн дарааллаар нь англи үгийг байрлуулан тогтоодог байсан билээ. Их сургуульд орсны дараа би япон хэлийг хэрхэн холбогддогийг ойлгохоор өгүүлбэрийг нь задлахад нэлээд цаг зарцуулдаг байлаа. Сурсан аргаараа япон хэлний бүтцээр англи хэлийг махчлан орчуулсан нь их хачин англи өгүүлбэр болдогсон. Харамсалтай нь би сурсан энэ зуршлаасаа одоо хэр нь ангижрахгүй байгаа болохоор, орчуулгын түвшингээ сайжруулахад үргэлж саад болсоор л байх юм.


Хаттори Широо



Хүмүүнлэгийн ухааны бакалаврын дипломын ажлынхаа хүрээнд би хэл шинжлэлийн хоёр өгүүлэл орчуулсан нь жинхэнэ орчуулга хийх, анх удаагийн ултай оролдлого болсон юм. Нэг нь структуралист (бүтэцзүйн хэл шинжлэлч) болох Хаттори Широо (Hattori Shirō)-гийн дайны дараа бичсэн зүйл байсан. Нэр томъёог нь оновчтой орчуулахаас бусад нь тийм ч хэцүү байгаагүй. Нөгөө нь уламжлалт хэлзүйч болох Хашимото Шинкичи (Hashimoto

⁹⁵ Австрали улсын иргэн, орчуулагч, судлаач

Shinkichi)-гийн 1930-аад оны үед бичсэн өгүүлэл байсан. Хашимото бол япон хэлзүйн дүрмийг зохиож энэ нь сургууль болон олон нийтэд хэрэглэгддэг болсноороо алдартай хүн. Би урьд нь тийм түг тагхийсэн, тодорхой мэдээжийн зүйлийг нэг бүрчлэн тайлбарлаж бичсэн өгүүлэлтэй таарч байгаагүй юм. Би



үүнийг орчуулах гээд өгүүлбэрээр нь задлан ялгаж, бүр махчлан орчуулдаг арга барилдаа орохоос өөр аргагүй болж билээ. Хэдийгээр өгүүлбэрзүйгээр нь задалж чадсан ч, англиар нь ойлгомжтой, оновчтой найруулгатай гэж санагдахаар тийм өгүүлбэр болгон орчуулж буулгах нь хамгийн хэцүү байсан. Одоо ч гэсэн тэр орчуулгыг харах болгондоо ичиж санаа зовдог.

Хашимото Шинкичи

Анхны ажил

Би Японд их сургуулиа төгссөний дараа Токио дахь Австралийн элчин сайдын яаманд орчуулагчаар орж анх удаа жинхэнэ орчуулагчийн ажил хийх болов. Тэр ямар ажил вэ гэвэл, үдээс өмнө Японы сонины өгүүллүүдийг англи хэл рүү орчуулж, үдээс хойш элдэв янзын материал орчуулдаг байсан. Орчуулсан сонины өгүүллүүдийг элчин сайдын яамны холбогдох тасгийн түшмэлүүд эх орныхоо яаманд лавлах материал болгон хэрэглэдэг байсан гэдэг юм.

Тэр үед, Австралийн элчин сайдын яамны сонины орчуулга Америкийн элчин сайдын яамныхаас нь хамаагүй сайн гэдгээр манайхан бахархдаг байсан. Америкийн элчин сайдын яамныхны орчуулсан орчуулга нь эхийг нь үгс, бүтцээр нь үгчлэн орлуулсан нь орчуулга гэж нэрлэхэд бэрх байсан юм. Харин энэ орчуулах арга бодит үндэслэлтэй байсан. Энэ юу вэ гэвэл, япон хэл мэддэг Америкийн түшмэл тэр орчуулгыг уншвал япон хэлний эх дээр юу хэлж байгааг нэлээн зөв зүйтэй ойлгож чаддаг байсан. Америкийн элчин сайдын яаманд эхийн утгыг нь бүдгэрүүлэх гоё англи хэл бус, махчилсан орчуулга хэрэгтэй байжээ.

Манай орчуулга Америкийн элчин сайдын яамныхаас илүү уншуургатай байсан ч гэсэн, заримдаа эх дээр байхгүй зүйлийг нэмж бичдэг байсан нь хачирхалтай. Жишээ нь, тухайн үеийн Австралийн ерөнхий сайд эдүгээ талийгаач болсон Боб Хоук байсан. Японы сонинд ер нь 豪ホ一ク首相 Gō Hōku shushō 'Австралийн Хоук ерөнхий сайд' гэж бичдэг байсан ч манай нэг орчуулагч маш хүндлэн эхэд байхгүй 'the Prime Minister of Australia the Hon. Robert James Lee Hawke' болох 'Австралийн ерөнхий сайд эрхэм Роберт Жээмс Лий Хоук' гэж орчуулж байсан.

Орчуулагчийн хувьд, би япон хэлний өгүүллийн агуулгыг аль болох харуулангаа зөв найруулгатай англи хэлээр илэрхийлэх зорилготой байсан. Миний хувьд тогтсон хэлбэртэй Японы сонины өгүүллийн найруулга уншихад дадлагажсан учраас, өмнө нь хийсэн орчуулгуудаасаа илүү өсөн дэвшиж байсан гэж бодож байна.

Орчуулга хийхдээ би хоёр зүйл дээр анхаарлаа хандуулж байлаа.

Нэгд нь, техникийн үг хэллэг, байгууллагын нэр гэх мэт нэр томъёог зөв оноон тогтмол хэрэглэх зорилготой байсан. Хамт ажиллагсдын аажмаар бүрдүүлсэн үгсийн тайлбар болон тэр үеийн хоёр хэлний нэр томъёо, үг хэллэгийн толь бичгүүд надад байнгын шаардлагатай хэрэгсэл минь болж байлаа.

Байгууллагын нэрийн энгийн жишээ гэвэл, тухайн үед 通商産業省 tsūshō sangyō-shō (товчилсон нэр 通産省 tsūsan-shō) гэдэг яам байсан. Тэр яаманд Ministry of International Trade and Industry ('олон улсын худалдаа, аж үйлдвэрийн яам', товчилсон нэр 'MITI') хэмээх тогтсон англи нэр байсан юм. Орчуулагч дураараа Department of Trade and Industry ('худалдаа аж үйлдвэрийн хэлтэс') шиг өөр үгээр орчуулбал, уншиж буй хүмүүс өөр байгууллагыг зааж байгаа гэж бодно.



経済産業省
Ministry of Economy, Trade and Industry

METI

(2001 онд MITI-г 経済産業省 keizai sangyō-shō, нэрийг нь товчлон 経産省 keisan-shō, гэж өөрчлөн нэрлэсэн билээ. Англиар Ministry of Economy, Trade and Industry — 'эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яам' ('METI') гэдэг.)



Техникийн үгсийн жишээ гэвэл, цахилгааны үүсгүүрт ашигладаг нүүрсийг монголоор 'эрчим хүчний нүүрс' гэдэг. Энэ төрлийн нүүрсийг японоор 一般炭 ippan-tan, бичсэнчлэн хэлбэл 'жирийн нүүрс' гэдэг. Англиар 'steaming coal' ('уур гаргах нүүрс') эсвэл 'thermal coal' ('дулааны нүүрс') гэж орчуулах хэрэгтэй.

Нүүрсээр ажилладаг цахилгаан станц (Wikimedia)

Тохирсон мэргэжлийн үгийг хэрэглэх нь чухал гэдгийг эрүүл ухаанаар ойлгох чадваргүй хүмүүс бас байгаад байдаг. Олон жилийн дараа нүүрсний төрлийг огт мэдэхгүй нэг компанийн орчуулагчийг япон, хятад түншлэгчдэд орчуулга хийж байгааг би сонссон билээ. Японоор 'эрчим хүчний нүүрс'-ийг 一般炭 ippan-tan ('жирийн нүүрс') гээд, хятадаар 动力煤 dònglì-méi ('хөдөлгөгч хүчний нүүрс') эсвэл 电煤 diàn-méi ('цахилгааны нүүрс') гэдэг. Харин тэр орчуулагч яг ижил утгатай гэдгийг анзаараагүй, хоёр талын үгийг махчлан орчуулж байсан. Тийм учраас, хэлэлцээ нь:

- *Япон тал:* Богино хугацааны эрчим хүчний нүүрсний зах зээлийг яаж харах вэ?
- *Хятад тал:* Бид нар эрчим хүчний нүүрсний үнэ нь бууна гэж бодож байна.

гэж ярих байсныг

- *Япон тал:* Богино хугацааны жирийн нүүрсний зах зээлийг яаж харах вэ?
- *Хятад тал:* Бид нар хөдөлгөгч хүчний нүүрсний үнэ нь бууна гэж бодож байна.



гэж ярьснаас болж талууд андуу ойлголцож магадгүй байсан. Аз болоход хоёр тал нүүрсний худалдааг нэвтэрхий мэддэг байсан болохоор эндүүрэл гараагүй.

Кобегийн ган төмрийн компанийн ган хайлах зуух (Steel 360)

Дашрамд хэлэхэд, коксжих нүүрсийг (заримдаа 'хүүрс' гэдэг хуучин монгол үгийг ч хэрэглэдэг) англиар 'coking coal' ('коксжих нүүрс') эсвэл 'metallurgical coal' ('металлургийн нүүрс'), японоор 原料炭 genryō-tan ('түүхий эдийн нүүрс'), хятадаар 炼焦煤 / 焦煤 liánjiāo-méi / jiāo-méi ('коксжих нүүрс / коксын нүүрс') эсвэл 冶金煤 yějīn-méi ('металлургийн нүүрс') гэдэг.

Хоёрт нь, эхийн бүтэц, үгийг хэтэрхий мөрдсөнөөс болсон эв дүйгүй өгүүлбэрийг жигдхэн уянгалаг өгүүлбэр болгох зорилготой байсан. Хашимото Шинкичигийн өгүүллийг орчуулсан үедээ ухаарсан шиг, япон хэлний өгүүлбэрийг англи хэл рүү орчуулахад байнга амаргүй байдаг. Махчлан орчуулсан болхи бүтцийг сайжруулж, өгүүлбэрийн хэлбэрийг англи хэлний хэлбэрт оруулж өөрчлөх шаардлагатай.

Жишээлбэл, тухайн үеийн томоохон асуудлын тухай Японы сонинд байнга гол санааг нь өмнө нь суурь мэдээлэл болгон тодотгол гишүүн өгүүлбэрийн хэлбэрээр оруулдаг. Жишээ нь, дараах тодотгол гишүүн өгүүлбэрээр эхэлсэн өгүүлэл их түгээмэл байсан:

- АНУ, Японы харилцаанд маш том маргаантай сэдэв болсон үхрийн мах, жүржийн асуудалтай холбогдуулан, Японы хөдөө аж ахуйн сайд өнөөдөр [...] гэж хэллээ.

Англи руу үгчлэн орчуулбал жаахан болхи өгүүлбэр болсон боловч би дандаа эхийн өгүүлбэрзүйн бүтцийг баримталж орчуулдаг байсан. Гэвч манай нэг орчуулагч үүнийг ингэж орчуулсан нь:

- Үхрийн мах, жүржийн асуудал АНУ, Японы харилцаанд маш том маргаантай сэдэв болжээ. Японы хөдөө аж ахуйн сайд өнөөдөр [...] гэж хэллээ.

Тийнхүү орчуулж тодотгол гишүүн өгүүлбэрийн болхи найруулгаас зайлсхийж чадсан. Харин энэ орчуулга сонины нэгдүгээр өгүүлбэрт бүх өгүүллийн гол санааг илэрхийлэх шаардлагатай гэдэг англи хэлний сэтгүүл зүйн гол дүрмийг зөрчсөн. Энэ өгүүллийн сэдэв 'үхрийн мах, жүржийн асуудал маш том асуудал болсон' бус, Японы хөдөө аж ахуйн сайд энэ асуудлын тухай саналаа илэрхийлсэн гэдэг нь чухал байсан.

Эдүгээ японы сонины бичих арга англи хэлний бичих аргыг авч хэрэглэснээр иймэрхүү маягийн бичих аргыг бага хэрэглэх болсон болохоор ийм орчуулгын асуудал бас ч багассан билээ.

Түүнчлэн 'хэт даврагч', 'алан хядлага', 'даяарчлал', 'дэлхийн дулаарал', 'цаг уурын өөрчлөлт' гэх мэт шинээр дэлгэрсэн илэрхийллүүдэд тодорхой, товчхон, ойлгомжтой дүйх үг олох нь бас чухал ажил байлаа. Энэ тал дээр өнөөгийн нэр томьёо, үг хэллэгийн толь бичиг ч маш их хэрэг болов.

1980-аад онд Японы засгийн газар эрчим хүчний хэрэглээг багасгахын тулд, эрчим хүч их хэрэглэдэг үйлдвэрлэлийн тоог цөөрүүлэх болон хаах бодлогыг батлан хэрэгжүүлсэн юм. Энэ үйл явцыг японоор 合理化 gōri-ka ('оновчтой болгох') гэж хэлдэг. Тухайн уед Англи, Америкт ч улсын үйлдвэрийн газар үр ашиггүй байсан учраас, нийт эдийн засгийнхаа үр ашгийг дээшлүүлэхийн тулд хувьчлах ёстой хэмээх үзэл хүчтэй өрнөж байлаа. Зах зээлийн үр ашиггүй талыг сайжруулахын төлөө, хүнд суртлыг халж, татварын хувь хэмжээг бууруулж, төрийн байгууллагуудын хувьд, илүүдсэн тасаг, ажлын байрыг цомхотхож, мөн компаний хувьд илүүдсэн үйлдвэр, ажлын байрыг ч үгүй хийх хэрэгтэй байсан. Энэ үйл явцыг ч японоор 合理化 gōri-ka гэж хэлдэг. Харин Англи хэл рүү 合理化 gōri-ka-г яаж орчуулах вэ гэдэг асуудал гарч ирсэн юм. Махчлан орчуулбал 'rationalise' ('оновчтой болгох') болно. Англи, Австралид эдийн засагчдын үзэл суртлыг шууд илэрхийлэхэд 'rationalise' ('оновчтой болгох') нь түгээмэл хэрэглэгддэг байсан. Харин Америк хүмүүст 'оновчтой болгох' гэдэг нь их хачин сонсогддог байсан юм шиг байгаа юм. Америкт дээрх санааг илэрхийлэхэд 'streamlining' ('шувтан хэлбэртэй болгох') гэдэг үг хэрэглэгддэг байсан. Шувтан хэлбэр гэдэг нь 'илүүдсэн юмыг хасах' гэдэг утгатай бөгөөд энэ “гоё” илэрхийлэл нь тэр үеийн нэр томьёо, үг хэллэгийн толь бичигт Америк маягийн 'streamlining' гэдэгтэй дүйж байсан. Харин би Австрали заншил ёсоор 'rationalise' ('оновчтой болгох')-ыг хэрэглэсээр л байв.

***Kūdōka*-гийн тухай**



Тухайн үед зардлаа хэмнэх зорилгоор японы компаниуд бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ гадаад руу нүүлгэн шилжүүлэх хандлагатай болсон. Энэ үзэгдлийг японоор 産業空洞化 sangyō kūdōka ('аж үйлдвэрийн хоосрол') гэдэг үгээр хэлдэг. Манай нэг орчуулагч *kūdōka*-гийн хамгийн зөв зүйтэй дүйх үг бол 'deindustrialisation' ('үйлдвэргүй болох') юм хэмээх санал гаргасан. Одоо ч гэсэн аль алийг нь хэрэглэсээр л байна. Гэхдээ *kūdōka* уг нь Америкийн 'hollowing out' ('хоосрол') гэдэг үгийг япон хэл рүү орчуулсан хэлбэр юм. Харин тэр үеийн

дэлгэрсэн илэрхийлэл болох 'аж үйлдвэрийн хоосрол' нь илүү тохиромжтой байсан байж магадгүй.

Нэг үе би өөр орчуулагчидтай хамт орчуулгын судалгааны бүлэгт оролцож, орчуулагч хүний мэдэх ёстой арга барилд суралцдаг байлаа. Эндээс би өөрт тус болох олон шинэ юм сурч авсан юм. Одоог хүртэл Chris Holmes-ын инээдэмтэй анхааруулгыг мартаагүй явна. Япон хэлэнд *も* mo (монгол хэлний 'ч'-тэй адил) гэдэг үг маш их хэрэглэгддэг. Харин *то*-г гарах болгонд 'also, even' гэж орчуулбал байнга хачин англи өгүүлбэр болдог. Chris Holmes япон хэлний өгүүлбэрийг орчуулахдаа *то*-г тоохгүй байх тусам, *то* чамд илүү их хайртай болно шүү гэж хэлж билээ. Энэхүү арга барил нь орчуулагчийг үгчлэн орчуулахаас холдуулах зорилготой байсан нь ойлгомжтой.

Цочирдол

Тэгээд нэг өдөр элчин сайдын яамны хөдөлмөрийн хэргийн зөвлөх намайг хажуу тийш нь дагуулж яваад, миний орчуулсан юмыг гоё англи хэл болон япон маягийн хачин англи хэлний холимог гэж хэлэхэд, энэ нь намайг маш их цочирдуулсан билээ. Зөвлөх орчуулсан өгүүллийг минь надтай хамт гүйлгэн уншингаа олон үг хэллэг зааж өгч анхааруулж билээ. Тус японы сэтгүүлчийн бичсэн өгүүллийн сэдэв бол Австралийн удирдлага болон ажилчдын хоорондох харилцааны систем ба нөхцөл байдлын тухай байсан юм. Зөвлөх нэг хэллэгийг зааж, энийг 'path of industrial harmony' гэж орчуулах ёстой гэсэн.

Үүнийг махчлан орчуулбал, industrial relations 'аж үйлдвэрийн харилцаа' гэсэн үг. Харин Англиар 'industrial relations' нь ажил олгогч ажилчдын (бодитоор хэлбэл компани болон үйлдвэрчний эвлэлийн) хоорондын харилцааг заадаг. 'Path of industrial harmony' ('ажил олгогч ба ажилчдын хоорондын эв найрамдлын зам') бол тэр үеийн үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөний, аль болох ажил хаялтаас зайлсхийж ажил олгогчтой эв найрамдалтайгаар хэлэлцэх гэсэн бодлогыг хэлнэ. Тухайн үед Австралид байнга болдог байсан хөдөлмөрийн маргаан их алдартай байсан болохоор япон компаниуд Австрали руу хөрөнгө оруулах эсэхдээ эргэлздэг байсан нь шийдвэр гаргахад нь ч их муу нөлөөлж байсан юм.

劳使関係

✗ 'management-labour relations'

✓ 'industrial relations'

Тэр сэтгүүлч 'path of industrial harmony'-г яаж илэрхийлснийг, би яаж англиар бичсэнээ мартсан байна. Харин японоор 'industrial relations'-ыг 劳使関係 rōshi-kankei, яг 'ажилчин ажил олгогч хоёрын харилцаа' гэж хэлдэг учраас, би шууд 'management-labour relations' ('удирдлага хөдөлмөрчид хоёрын харилцаа') гэж махчлан орчуулсан байсан байх. Миний хувьд Австралийн уншигчдад япон хэлний хэлбэр, утгыг дамжуулах зорилготой байсан. Нөгөө талд манай зөвлөхийн үзэл бодлоор бол энэ орчуулга нь маш оновчгүй юм байсан бололтой. Яагаад

гэвэл, тэр зөвлөх япон сэтгүүлчийг Австрали руу явуулах ажилд оролцсон байж магадгүй бөгөөд Австралийн холбогдох хүмүүст ажлаа сайн хийж байгаа мэт сэтгэгдлийг заавал төрүүлмээр байсан байх л даа. Тэр зөвлөх 'Policy of peaceful labour-management relations' ('удирдлага хөдөлмөрчид хоёрын харилцааны энх тайванч бодлого') гэдэг япон маягийн хачин англи хэлийг Австралийн холбогдох хүмүүст лавтай үзүүлмээргүй байсан бололтой.

Тэгээд би нэг чухал юм ойлгосон билээ. Миний орчуулах арга Америкийн элчин сайдын яамныхнаас бараг ялгаагүй байсан гэж. Орчуулсан өгүүлбэрийг болхи бус болгохоор засаж, уншуургатай юм болгохын төлөө хүч чармайлт гаргасан ч, эхийн утгыг онож илэрхийлж, уншигчдадаа дамжуулахыг гол зүйл гэж бодож байсан юм л даа. Австралийн уншигчдад гоё хувцасласан мэт орчуулга бус, японы уншигчдад ямар сэтгэгдэл төрөхийг дамжуулах нь гол зорилго гэж бодож байсан хэрэг. Миний тэр санаа буруу байжээ.

Шантарч байсан надад өөрийгөө хүндэтгэх, өөртөө итгэх итгэл маань хэдэн жилийн дараа л өмнө нь төгссөн Австралийн их сургуульдаа эргэн очих үед анхны япон хэлний багштайгаа уулзсан тэр үед бүрмөсөн ул мөргүй алга болсон юм.

Тэр багш хэлэхдээ "Бид нар орчуулгын хичээл дээр чиний элчин сайдын яаманд байхдаа орчуулсан орчуулгыг дандаа хэрэглэдэг байсан" гэсэн билээ.

"Тийм үү?"

"Харин тийм. Чиний орчуулга эхтэйгээ ойролцоо байсан учраас япон хэл рүү орчуулахад нэлээд амархан байдаг байсан шүү" гэж билээ.

Австралийн оюутан англиас япон хэл рүү шууд орчуулж чадах англи хэлний текст нь багшийн хувьд маш сайн материал байсан ч, орчуулагчийн хувьд махчлан орчуулах хэмээх ноцтой дутагдлаасаа ангижраагүй гэсэн үг байсан.

Өөр ажил хийсэн минь

Би элчин сайдын яамны ажлаасаа гадна зарим өөр ажлын туршлагатай болсон. Токиогийн тусгай зөвшөөрөл (патент)-ийн өмгөөлөгчийн газарт түр ажил хийж үзэхдээ өөрөө патент орчуулаагүй боловч, хүний орчуулгыг засахдаа патентын орчуулгын нарийн шинж, чанга шаардлагыг ухаарсан юм. Патентын өгүүлбэр нь өөрсдийн зохион бүтээсэн зүйлийн онцлогийг нарийн тайлбарлахаас гадна хуулийн баримт бичиг болохоор эхээсээ яльгүй л зөрвөл өндөр хохирол гарахуйц болгодог.

Мөн нэг хэсэг хугацаанд би телевизийн студид мэдээллийг японоос англи руу орчуулж унших ажил ч хийж үзсэн. Мэдээлэл нь уншихад амархан, сонсоход аятайхан байх шаардлагатай. Хамт ажилладаг нэгэн япон хүний япон хэлийг түвэггүй, аятайхан англи хэл рүү хялбархан орчуулдаг чадварыг нь би машид биширсэн. Харин би шал ондоо. Би хичнээн хичээсэн ч загварчилдаг зуршлаасаа бүрэн ангижирч чадахгүй хэвээрээ л байсан юм.

"Жинхэнэ ажил"-аа олсон минь

Би бусдын нүднээс далд тийм ч их үнэлэгдэхгүй орчуулгын ажил хийж байхдаа, нийгэм дээр идэвх зүтгэл гаргаж улс болон байгууллагадаа их хувь нэмрээ оруулж байгаа хүмүүсийг хараад үргэлж атаархдаг байлаа. Тэгээд, хэдэн жилийн дараа би зүрхээ чангалж "жинхэнэ ажил" олж элчин сайдын яамаа орхисон юм. Олсон ажлын байр маань бол Токио дахь зах зээлийн судалгааны компанийн судалгааны ажил хариуцсан менежер. Хэлний тодорхой хэв маягийг дагаж бичсэн судалгааны тайлангаас гадна би үйлчлүүлэгчийнхээ төлөө Японы улс төр, эдийн засаг, нийгмийн талаар илтгэл бичдэг байв. Би энэ ажлынхаа төлөө нийтлэл орчуулж байсан боловч, эхийг нь нарийн орчуулах шаардлагаас чөлөөлөгдөж, үйлчлүүлэгчийг сонирхоно гэж бодсон янз бүрийн мэдээллийг тодруулахад зорьж ажилладаг байсан юм. Одоо бодоход энэ нь орчуулгын ур чадварыг минь сайжруулсан болов уу гэж бодож байна. Гэхдээ одоо ч гэсэн сайн мэдэхгүй л байна.

Хятад руу явсан нь



Дөрвөн жилийн дараа би Японы үзэсгэлэнт эргээс Хятадын өргөн уудам нутаг руу явахаар шийдлээ. Нэг жил хятад хэл сурсны дараа би нэг компанийн 'даргын туслахаар' ажиллах ажлын байр олов. Хятадад байхдаа нийтдээ дөрвөн компанид ажиллажээ. Бээжин, Хайнань, Макао, Шанхай, Япон, Монгол гэх мэт хэдэн газарт ажилладаг байсан. Миний дээд тушаалтан бол зарим нь хятад хүн, зарим нь япон хүн, нэг нь ирланд иргэншилтэй пакистан хүн байсан. Хэдийгээр Хятадад мэргэжлийн орчуулга руу хэзээ ч эргэж ороогүй боловч, би ажиллахдаа ихэвчлэн хятад-англи, япон-англи, англи-хятад, япон-хятад, заримдаа хятад-япон хэлээр орчуулах үүрэгтэй байсан юм.

Ажил дээрээ заримдаа гэрээ орчуулах шаардлагатай байлаа. Гэрээ орчуулахдаа мэргэжлийн сэтгэгдэл төрүүлэхүйц хуулийн үг хэллэгээр утгыг нь зөв илэрхийлэх хэрэгтэй байдаг. Азаар, миний орчуулга ихэнхдээ дотоод лавлагаанд зориулж байсан тул би хууль ёсны баримт бичгийн хамгийн хатуу чанга шаардлагаас чөлөөлөгдөж байсан гэхэд болно.

Зочид буудлын олон нийттэй харилцах ажил дээрээ би зар сурталчилгааны материал, үйлчлүүлэгчдээ зориулсан тайлбар, рестораны цэсийг хүртэл орчуулдаг байсан. Орчуулга төрөл бүрт тодорхой зорилго байдаг байсан юм. Зар сурталчилгааны материал зочид, үйлчлүүлэгчдийг татаж зочид буудлын үйлчилгээ, төхөөрөмж, цогцолборыг хэрэглүүлэх зорилготой байсан юм. Цэс уншуулж зочид буудлын ресторанд хоол идэх дур хүслийг нь татах хэрэгтэй байлаа. Өрөөний сэйф гэх мэтийн тоног төхөөрөмжийг яаж хэрэглэх вэ гэдэг тайлбарыг ойлгоход амархнаар илэрхийлэх хэрэгтэй. Энэ зорилгод үгчлэн

орчуулах нь тохиромжтой биш.

Үүнээс гадна өөр газарт, албан тушаалаа орхисон гадаад улс төрчдөд япон-англи хэлний орчуулгыг заримдаа надаар хийлгэдэг байсан. Нэг удаа гадаадын нэг улс төрч 'entrenched attitudes' гэдэг үг хэллэгийг хэрэглэсэн юм даг. Монгол хэл рүү үгчлэн орчуулбал 'бугшсан хандлага' гэдэг утгатай. Миний ой будилаагүй бол, тэр хүн улс төрийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд тухайн орны бага ястан хийгээд гадаад хүнийг ялгаварлан гадуурхах үзэл гэдэг утгаар хэрэглэсэн билээ. Англиар энэ төрлийн хандлагыг 'prejudice' ('эчнээ бодол, үнэмшил, үзлээр ялгаварлах') гэдэг. Харин тэр улс төрч 'prejudice' гэдэг үгээс илт зориудаар зайлсхийж байсан. Харамсалтай нь тэр үед би 'entrenched attitudes' ('бугшсан хандлага') хэмээх цээрлэн илэрхийлэх үгийг шууд санаж чадаагүй, яг 先入観 sennyūkan ('буруу төсөөлөл, атгаг санаа, итгэн үнэмшил') гэж орчуулсан билээ. Тэр хүний санааг бодвол, 先入観 sennyūkan гэдэг үг бол тохиромжгүй үг байсан байх. Google Translate харвал 'entrenched attitudes' ('бугшсан хандлага')-ыг японоор 定着した態度 teichaku shita taido ('байршсан хандлага') гэж байна. Харин энэ хэллэг ч тэр хүний санааг бүрэн зөв зүйтэй илэрхийлсэн үг гэж би одоо ч гэсэн бодохгүй байна.

Японы улс төрч ихэнх нь үлбэгэр, амт шимтгүй, хэвд оруулсан үгээр ярьдаг онцлогтой, үүнтэй харьцуулбал англи хэлтэн улс төрч ерөнхийдөө хурц, тодорхой ярих хэвшилтэй. Нэг удаа, миний орчуулсан үг тус гадаад улс төрчийн хэлсэн утгыг нь зөв дамжуулж байгаа эсэхийг батлахаар орчуулсан агуулгыг буцааж англи хэл рүү орчуулсан юм. Тэр хүн "би энэ хэлбэрээр илэрхийлээгүй шүү" гэсэн боловч утгыг нь ойролцоо гэж хүлээн зөвшөөрсөн юм. Улс төрчийн хэллэгийн нарийн ялгааг онож илэрхийлэх нь хэцүү болохоор энэ бол орчуулагчийн чадварыг сорьдог ажил. Тийм болохоор би олон улсын удирдагчдад орчуулга хийх хүмүүсийн орон тоонд ажилламааргүй санагддаг юм.

Өөр зүйлийн орчуулга

Хожим нь би миний ажиллаж байсан худалдааны компаний даргад салбарын мэдээ (шаардлагатай бол улс төр, эдийн засгийн мэдээ гэх мэт) цуглуулж өгөхөөс гадна англи, япон хэлнээс хятад хэл рүү орчуулах ажилд томилогдсон. Энэ нь маш их хэцүү үүрэг байлаа. Би эцэст нь Google Translate маш ихээр ашиглаж, түүний муу орчуулгыг нь засахдаа их цаг зарцуулдаг байсан юм. Би өөрийнхөө орчуулгаар огт бахархахгүй. Манай компанид зуны амралтаар нь хөлсөлсөн их сургуулийн оюутнуудын хийсэн гялзалзсан орчуулгатай харьцуулбал миний орчуулга маш муу байсан санагддаг юм.

Харин би туршлага багатай залуу хятад оюутнуудаас хэд хэдэн давуу талтай байсан. Үүнд:

1. Би хамгийн чадварлаг оюутнуудаас ч илүү англи хэлээр төгс ойлгодог байсан. Нэгэн оюутан 'wet weather' (бороотой цаг агаар)-ыг 'чийгтэй цаг агаар' гэж орчуулсныг санаж байна. Энэ нэлээд энгийн жишээ боловч би зарим томоохон мэдээллийн агентлагаас гарсан орчуулгад ч алдаа гардаг гэдгийг олж мэдсэн.

2. Цаг хугацаа өнгөрөхөд би мэдээн доторх мэдээллийн ихэнх нь суурь мэдээлэл эсвэл нөхөөс байдаг гэдгийг мэдсэн. Жишээ нь, хятад хэл рүү орчуулахдаа би 'Австралийн зүүн хойд нутагт оршдог Квинсланд муж' гэх мэт олон нийтэд зориулан хүмүүсийн төлөө тайлбарласан мэдээллийг уул уурхайн салбарынхан нийтээрээ мэддэг зүйл учраас, энэ мэт мэдлэгийн зүйлийг орхидог байсан юм. Иймэрхүү байдлаар миний орчуулгын найруулга тааруухан байсан ч үнэн зөв, цэгцтэй болдог байв.

Гадаад хэл рүү орчуулга хийхдээ, өмнө хуримтлуулсан мэдлэгээ дайчлан ажиллах нь орчуулах чадварт тийм ч их нэмэр болдоггүй гэж би мэдсэн. Гадаад хэлнээс төрөлх хэл рүүгээ орчуулбал үгсийн сан, илэрхийлэх чадвараа дээшлүүлэх илүү их боломжийг олгодог.

Бүтэлгүйтэл

Он удаан жил бүтэлгүйтэх явдал гарсаар л байлаа. Аман орчуулга хийхдээ тэвдэж сандрахдаа алдаа гаргадаг байснаас гадна, хэлмэрч хийхдээ төдийлөн сайн биш байсан билээ. Бичгийн орчуулга хийхэд ч дутагдалтай зүйл байсаар байсан санагддаг.

Нэг удаа таньдаг япон эмэгтэй нөхөр нь болох хятад уран бүтээлчийн бүтээлийн цомгийн оршлыг орчуулахыг надаас хүсэж хятад хэл дэх эх зохиол, япон хэлний орчуулгыг хоёуланг нь надад өгсөн. Хятад хэлний эх зохиолын утга нь овоо тодорхой байсан боловч би яаж тохиромжтой сайн найруулгатайгаар орчуулахаа мэдэхгүй байлаа. Миний хувьд уран бүтээлчийн эхнэрийн орчуулсан япон орчуулга нь хоёр хэлний хоорондын ялгааг хүчээр тохируулсан, болхи бүтцээр дүүрэн, тойруу замаар найруулсан, хангалтгүй өгүүлбэр байсан. Би орчуулж дуусгаад түүнд өгсний дараа тэрээр сураггүй боллоо. Хэсэг хугацааны дараа нэг япон найз маань надад тэр эмэгтэй миний орчуулгад тун сэтгэл дундуур байсан тухай ярьж билээ. Миний бодлоор, орчуулга минь илүү хялбар, урлах мэдрэмж дутуу байсан байж магадгүй. Харамсалтай нь тэр эмэгтэй надад ямар ч үнэлэлт дүгнэлт тайлбар өгөөгүй болохоор, би жинхэнэ шалтгааныг хэзээ ч мэдээгүй бөгөөд тэр байдлаас орчуулах түвшингээ ахиулах боломжийг авч чадаагүй юм.



Газар хөдлөлтийн дараах бохир усны шугам сүлжээ

Саяхан би япон үйлчлүүлэгчийн хүсэлтээр газар хөдлөлтийн дараа бохир усны шугам сүлжээг саадгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх талаар хоёр орчуулгын ажил хийсэн юм. Эхнийх нь миний үйлчлүүлэгчийн олон нийтэд зориулж хэлэх үг байсан. Би эхийн үгс, бүтэцтэй нь ойролцоо маягаар орчуулсан нь үйлчлүүлэгчид овоо таалагдсан.

Дараагийнх нь эхнийхтэйгээ нь ойролцоо боловч, зарлал учраас зорилго нь маш өөр байсан. Олон нийтийн зарлалын зай хязгаартай, хялбар ойлгогдох үг хэрэгтэй болохоор, би сонгосон үгийг нь хялбарчилж үгийн тоог нь ч багасгаж

сайжруулсан. Харин энэ нь үйлчлүүлэгчийн сэтгэлийг зовоож эхийн орчуулгын хэлбэрт нь буцаан оруулах гэж шөнөжингөө нухсан гэнэ. Энэ удаад би уг нь эх зохиолыг сохроор дагадаг муу зуршлаасаа зайлсхийх ур дүй эзэмшсэн ч, инээдэмтэй нь үйлчлүүлэгчийнхээ сэтгэлийг хангаагүй хэрэг. Үйлчлүүлэгч харваас миний зайлсхийгээд байгаа тэр орчуулах аргыг хүсээд байсан юм.

Миний сурсан зүйл

Олон жилийн туршлагатай болохоор намайг орчуулгын талаар төгс гэж бодож байж магадгүй, харамсалтай нь тийм биш юм. Гэхдээ олон жилийн турш ингэж байнгын орчуулгын ажил хийх явцдаа миний олж мэдсэн, ойлгосон зүйлсийн заримыг нь доор дурдъя. Үүний ихэнх нь цэвэр эрүүл ухаан боловч 'орчуулга судлал'-ын салбарт бага зэрэг хамааралтай байж болох юм.

1. Орчуулга бол зорилгод чиглэсэн үйл ажиллагаа, зөвхөн зорилгын талаас ойлгох боломжтой.

Туйлын оновчтой зөв орчуулга гэж байдаггүй. Зөвхөн зорилгодоо нийцсэн орчуулга гэж бий. Орчуулгыг ихэвчлэн 'хууль ёсны орчуулга', 'утга зохиолын орчуулга' гэж хуваадаг. Энэ нь зөвхөн зорилгоор нь хувааж байгаа хэрэг юм.

- Хэрэв АНУ-ын элчин сайдын яам эх зохиолыг үгчлэн орчуулсан, эхтэй тодорхой холбоотой орчуулгыг хүсэж байвал, энэ нь зайлшгүй шаардлага;
- Хүмүүсийг ятгах, сэтгэгдэл төрүүлэх шаардлагатай бол, хүмүүсийг ятгах үгсийг жигд хэрэглэх ёстой;
- Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд сонирхогчийн сэтгэлийг нь татам болгох зорилготой орчуулгыг сэтгэл татам байдлаар танилцуулахаар бэлтгэх ёстой;
- Хэрэв орчуулга нь улс төрийн шаардлагыг хангах хэрэгтэй бол таарсан үгсийг хэрэглэх ёстой. (Жишээ нь, Хятад улсын хилийн чанадад зориулсан мэдээллийн нэг асуудал бол гадаадад байгаа уншигчдад сэтгэгдэл төрүүлэхийн зэрэгцээ, улс төрийн шаардлагыг хатуу баримтлах гэдэг хоёр зорилго нь харилцан зөрчилддөг);
- Хууль эрх зүйн орчуулга нь, агуулга нь хуулийн цоорхойгүй, эрх зүйн баримт бичгийн хэв маягтай, хууль дээр няцаагдашгүй байх ёстой;
- Улс төрчдөд зориулсан орчуулга нь тэдний улс төрийн асуудалд яаж нөлөөлөхийг мэдрэх мэдрэмжтэй байх хэрэгтэй;
- Дипломатын орчуулга нь дипломат хэлбэрийн онцлог хэлбэр, хэлийг дагаж мөрдөх ёстой;
- Гол мэдээллийг шаарддаг орчуулга нь үнэн зөв, хэрэгцээг хангадаг байх ёстой. Хичнээн ч сайхан өнгөлсөн орчуулга байсан ч тоо баримт алдаатай байвал хэрэгцээ хангахгүй муу орчуулга болно;
- Уран зохиолын орчуулга нь уншигчдад уран сайхан мэдрэмж төрүүлэх зорилготой. Гүн ухаан сэтгэлзүйн сонгодог зохиолыг сонгодог зохиол шиг уншигддаг, адал явдалт зохиолыг адал явдалт зохиол шиг уншигддаг, хошин зохиолыг хошин шог зохиол шиг уншигддаг байхаар орчуулах хэрэгтэй;

Александр Поуп (Wikipedia)



- Уран зохиолын орчуулгын шаардлага мөнхөд тогтоосон зүйл биш. XVIII зууны английн яруу найрагч болох Александр Поуп (Alexander Pope) Хомер (Гомер)-ын туулийг тэр үеийн шүлэглэсэн хэлбэрээр орчуулж, үг нэмж, хасч, сольсон боловч хүмүүст сайшаагдсан байдаг. Харин өнөө цагийн хүмүүс эртний үеийн хүмүүсийн хэрэглэдэг байсан бодит үг хэллэг, найруулгыг хүсэх болсон байна.
- Хувиараа өөрийнхөө хэрэгцээг хангах орчуулга нь хэвлэлээс гаргаж олон нийтэд түгээх орчуулгаас өөр "уншигчидтай" учраас, тавих шаардлага ч мөн тийм ажээ.
- Түүхэн баримтын орчуулга, ихэвчлэн тайлбартай, эрдэм шинжилгээний орчуулга нь утга зохиолын найруулгатай байх шаардлагагүй. Утга зохиолын орчуулга нь эрдэм шинжилгээний найруулгатай байх ч албагүй. Гэхдээ энэ хоёрын аль аль нь зохицолдолгоотой байх нь тохиромжтой.
- "Бяцхан хунтайж" шиг үлгэрийн эх зохиолыг бүгдийг нь хэвээр нь орчуулсан, бас хүүхдүүдэд зориулсан үлгэр шиг орчуулсан хоёр маягийн орчуулга байдаг. Хүүхдүүдэд зориулж орчуулахад мэдээж үг найруулгыг өөрчлөх шаардлага арвин гардаг.
- Киноны үгийг хоёр хэлбэрээр орчуулдаг. Нэг нь үгийг нь хөрвүүлээд дуу оруулагчаар хэлүүлэх, нөгөө нь хадмал орчуулга хийгээд дэлгэцний доод талд хадаж гаргах. Энэ хоёр хэлбэр хоорондоо шал өөр. Дуу оруулагчийн хэлэх үг эх үгтэй голдуу адилхан хугацаанд хэлж амжих шаардлагатай. Орчуулагч үгийнхээ утгыг харьцангуй чөлөөтэй орчуулах боломжтой байдаг. Харин хадмал орчуулга нь дэлгэцэд гардаг үсгийн тоо, гарах хурд гэх мэт хатуу шаардлагатай. Хатуу хязгаарлалтын дотор эх үгийн утгыг товч тодорхой, илэн далангүй, шууд ойлгож чадах үгээр дамжуулах хэрэгтэй.
- Харамсалтай нь бодит байдалд орчуулга хийх зорилго нь уншигчдад тохиромжтой орчуулга бус, хагас дутуу гадаад хэл мэддэг үйлчлүүлэгчийн хэрэгцээг хангах хэрэгтэй байх тохиолдол байдаг. Өмнө өгүүлсэн япон үйлчлүүлэгч шиг. Ялангуяа ийм асуудал Японд түгээмэл байдаг.
- За, нөхцөл байдлыг минийхээр ойлгосон байх аа ...

2. Хэдийгээр орчуулгын программ зохион бүтээсэн ч орчуулга бол хүний төлөө хийсэн хүний үйл ажиллагаа юм.

Хамгийн гол нь орчуулга бол орчуулагчийн орчуулахдаа хийсэн сонголтын үр дүн. Тэр сонголтууд нь орчуулгын ерөнхий хэв маяг, өнгө аяс, нарийвчлалтай байдлыг тодорхойлдог.

Орчуулагчийн олон нөхцөл байдал нь орчуулгын чанарт нөлөөлнө.

- 1 Орчуулагч хэр зэрэг эх зохиолоо ойлгож байна вэ? Орчуулагчийн үл ойлгосон байдлаас болж орчуулгын чанар муу болох нь түгээмэл байдаг.
- 2 Орчуулагчийн орчуулга, тухайн чиглэлийн туршлага. Орчуулагчид тухайн сэдвийг ойлгох, үгийн олон утга, найруулгын хэв маягийг олж авахдаа маш их цаг зарцуулах шаардлага тулгарна.
- 3 Орчуулагч арвин баялаг үг, үгийн хэрэглээтэй байвал зохино. Зарим хүмүүс сайн найруулга, баялаг үгийн сан, үг хэллэгийг мэдрэх мэдрэмж, зохиогчийн ертөнцийг үзэх үзэл зэрэг янз бүрийн хэлбэрийн уран зохиолыг судалж сайн орчуулагч болдог. Зарим хүмүүс арай үүнд хүрдэггүй.
- 4 Орчуулагчийн өвөрмөц шинж. Орчуулагч нар эх зохиолыг орчуулах өөрийн гэсэн олон аргатай. Сонины нийтлэлийг орчуулахдаа өөрийнхөө аргыг хэрэглэдэг байсан манай элчин сайдын яамны орчуулагч гэх мэт, бүх орчуулагчдад өөрийн арга барил байдаг. Энэ нь орчуулгын хэв маягт ихээхэн нөлөөлөх боломжтой.
- 5 Орчуулагчийн суурь хэвшил. Орчуулагч нарын "автоматаар" орчуулах зуршил нь тэдний сургуульд анх гадаад хэл сурч эхэлсэн үеэс л тогтдог гэж би бодож байна. Харин ийм зуршлаасаа ангижрахад хэцүү.

3. Ихэнх орчуулга чухамдаа үгчилсэн орчуулга байдаг.

Махчлан орчуулахаас зайлсхийж, аль болох эх зохиолынх нь утгыг тэр хэвээр нь уншигчдад өгөх ёстой гэж байнга уриалдаг боловч бодит байдалд эх зохиолын үгсийн сонголт, үгсийн дараалал нь бүхий л орчуулгын эхлэл юм.

Зөвхөн дадлагагүй орчуулагч эх зохиолыг анх удаа хараад үг тус бүрийг зөнгөөрөө орчуулдаг юм биш. Туршлагатай орчуулагч ч бас ингэдэг. Учир нь эх зохиолын түүхий эд бол үг юм. Бодит байдалд эх зохиолын үгсийн сонголт, үгсийн дараалал нь бүх орчуулгын эхлэл юм. Ур чадвараа дээшлүүлэхийн тулд орчуулагч эхийн нарийн хэлбэрт хэт их санаа зовохоос зайлсхийх хэрэгтэй. Энэ зуршлаа нэг шөнийн дотор засаж чадахгүй. Жишээ нь, япон хэлний ㊦ то-г автоматаар үгчлэн орчуулахаас зайлсхийхтэй адил. Нарийн бүтцийг тогтсон хэлбэрээр орчуулахаас зайлсхийх гэдэг энгийн зүйлээс эхэлж болно. Мэдээжийн хэрэг зарим хүмүүс бичих чадвартай, тэдэнд сэтгэл татам уянгалаг сайн зохиолыг бичихэд бусдаас бэрхшээл бага байдаг. Гэхдээ ямар ч орчуулга хийхэд бүтэн зохиол бичихтэй адил, хүчин чармайлт хэрэгтэй.

Цогц хүрээний судалгаа нь орчуулгын өвөрмөц онцлогийг тодорхойлж, орчуулга нь эх зохиолоосоо хэрхэн ялгарч байгааг тодорхойлж, орчуулагчийн ур чадвар, дадал хэвшил, найруулгын өвөрмөц шинжийг тодорхой болгох боломжтой байдаг гэж би бодож байна.

(Аман орчуулга нь дээрх аргаас онцгой байдаг. Хэлэлцээр болон тухайн газар дээр шууд орчуулга хийхдээ орчуулагч үг тус бүрийн утгыг бус, ерөнхий мэдээллийг нь дамжуулдаг, үг, бүтцийг орчуулах аргаас зайлсхийх шинжтэй учраас аман орчуулга хийх туршлага нь бичгийн орчуулагчдад ч тустай байна.)



4. Стандарт болсон олон улсын нэр томьёоны үүрэг бусад анзаардагддаггүй.

Орчин үеийн "орчуулга" гэгч юм ихэнх нь стандартчилсан нэр томьёог мэдэх гэсэн үг. Дэлхийн гол гол хэлний орчуулагчид ямагт зөвхөн бэлэн үгийг л орлуулах хэрэгтэй. Жишээ нь, 'economic' гэдэг үг европын хэлээр *économique* (Франц хэл), *ökonomisch, wirtschaftlich* (Герман хэл), *económico* (Испани хэл), *экономический* (Орос хэлээр) гэх мэт тогтсон дүйх үгтэй. Азийн хэлэнд ч 經濟(的) *keizai(-teki)* (япон хэл), 經濟 / 经济 *jīngjì* (хятад хэл), *간결한 gangyeolhan* (Солонгос хэл) гэх мэт үг байна. Монгол хэлэнд түүхээс шалтгаалан "эдийн засгийн" (Монгол), "аж ахуйн" (өвөрмонгол) хэмээх хоёр үг байна.



Харин 150-хан жилийн өмнө орчуулга хийдэг хүмүүст ийм тогтсон нийтлэг үг байдаггүй байсан байна. Европын хэлнээс бусад хэлэнд "эдийн засаг" гэдэг үгийн тогтсон дүйх үг байдаггүй байсан. Орчин үеийн болгон шинэчлэх (现代化) буюу өрнөджилтийн (西方化) явцын дунд XIX зууны орчуулагчид дүйх үгийг цоо шинээр зохиож, одоогийн үгийн сангийн суурийг тавьсан юм. Тиймээс, өнөөгийн орчуулагчийн хувьд, жишээ нь "Свахили хэлээр 'эдийн засгийн' гэдэг санааг яаж илэрхийлэх вэ?", "Свахили хэлээр 'эдийн засгийн' гэдэгтэй дүйх үг юу вэ?" гэдэг хоёр шал өөр асуулт болно. Одоо стандартчилсан шинжлэх ухаан, технологиос гадна спортын салбарт ч олон улсын нэр томьёог маш нийтлэг хэрэглэх болжээ. Тиймээс "орчуулга" гэдэг нь ухаан сийлэх бус, цээжилсэн дүйх үгээ гарган оноох эсвэл толь бичиг харахтай адил амархан ажил болсон. Компьютерын орчуулга ч бас энэ орлуулсан, дүйлгэсэн нэр томьёод маш их түшиглэдэг.

Төгсгөл

Сүүлийн хэдэн арван жилд орчуулгазүйн салбарт олон шинэ хандлага дэлгэрч ирлээ. Үүний дотор цогц хүрээний судалгаа ч их байна. Эдгээр нь шинэлэг ололтууд болсон юм. Америкийн хэлшинжлэлч Н.Чомскийн онол бол бодит зүйл бус оюун ухааны хийсвэр объектыг судлах зорилготой. Олон судлаач Н.Чомскийн "төгс төгөлдөр яригч, сонсогч"-той адилхан, "төгс орчуулагч" байдаг гэж бодож байгаа юм шиг байна. Харин миний хувьд "төгс орчуулагч" буюу өв тэгш орчуулагч гэдэг юм байдаггүй, эхийг орчуулах төгс арга ч бас байдаггүй. Ихэнх орчуулга зорилгоосоо хамаардгийг бодолцох хэрэгтэй гэж үзэж байна.



ОРЧУУЛГЫН САН ХӨМРӨГ



ЛАМБАГУАЙН НУЛИМС

Д.Нацагдорж, 1930 он.

Орчлонт ертөнцийг хоосон гэж хүрдийг бясалгаж, винайн ёсыг сахисан гэвш Лодон улаан шарыг тунуулсаар, гандангийн наад хүр рүү бууж ирмэгц, уран тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан хүүхэн Бай-хуа гэдэг Цэрэнлхам цагаан харыг гялбалзуулсаар, баруун дамнуурчны шавартай гудамжнаас гарч ирэх нь эсрэг тохиолдов.

Иүй Бай-хуагийн хар тамхи тасарсан учир, нэг алтан бөлзгийг бариулж, хэдэн янчаан олж хэрэглэхийг зорьж явсан нь санамсаргүй гэвш Лодон тохиолдохыг үзвэл, тэр үнэхээрийн нэг томхон хувраг сэтгэл зөөлөн, чанар хөнгөн болохыг хэдийнээ ажиглан таниад, цахилгаан мэт хурдан нэг аргыг олж, ламын дэргэд зогсож, зовлонтой бөгөөд бахардсан царай гарган: “Ламбагуай өршөө, өршөө, манай хөгшин эх өвдөөд, үхэхийг хүлээж байна. Хичээж манайд морилж, ном айлдаж хайрлана уу?” гэсэнд лам: “Зүүн хүрээнд хуралд очиж явна. Энэ удаа амжихгүй. Өөр нэг ламыг зал” гэсэн боловч, Иүй Бай-Хуа сандарсан байдлыг гаргаж, дахин давтан зовлонт үгсийг тоочин, элдэвчлэн гуйхад, аргагүй болж бас ч бахардсан байдлыг үзвэл, барьц ихээхэн өх биз гэж санаж, ном уншихаар хүүхнийг дагалдан, түүний гэрийн зүг одов.

Зуны цагт баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, үнэр ханхлах нь үнэхээр түмэн багц хүжийг шатаавч үл дарагдмаар. Гэвш Лодон ам хамрыг орхимжоороо бөглөн, хүүхний хойноос намс намс алхална.

Удалгүй нэг хувхай цагаан хаалгаар орвол гангийн арьс ширийн шорвог агаар амтагдаж, зулсан үс, ноос салхинд хийсэн дээл хувцсанд наалдана.

Хоёр нурсан шавар байшингийн нарийхан завсраар өнгөрч, баруун талд зүүн тийшээ харсан нэг нүх шиг байшинд ороход хүүхэн ламыг нэг сандал дээр суулгаад: “цай авч ирье” гээд гарч явахын завсар лам ажиглавал, байшингийн өмнө этгээдэд нэг том ор байна. Хөнжил дэвсгэрийг цэмцийтэл хураан засаж, эрээн даавуугаар хучжээ. Хойт этгээдэд нэг бага дөрвөлжин ширээг цагаан даавуугаар бүтээж, дээр нь нэг том цаг ба зураг хөргийг тавьжээ.

Байшингийн дээвэр нь маш балтгар. Гэвш Лодон өндийвөл толгой нь бараг тулна. Нэг бага цонхыг хоёр давхар муутуугаар битүүлэн нааж, улаан цаасаар угалзлан чимхжээ. Байшингийн дотор өдөр байтлаа, бүрий барай байдлыг төрүүлнэ.

Цонхны буланд нэг бяцхан нүхийг гаргасан нь бодвол орж гарах хүмүүсийг ажигладаг бололтой. Удалгүй хүүхэн орж ирээд нэг аяга цай өгсний дараа ачит лам минь авралдаа тольдож, миний эхийг эдгээн соёрх гэж гуйна. Лам хүүхний зүг ажиглавал, гадна нарны гэрэлд түүний царай хувхай цагаанаар өнгөгүй

үзэгдэж байсан нь харин энэ байшингийн дотор орж ирээд, хоёр хацар нь улаанаар гэрэлтэж, өглөөгүүр залбирдаг цагаан дарь эхийн хөргийн адил үзэсгэлэнтэй гэрэлтэхэд ламын сэтгэлийн дотор ертөнцийн манан бяцхан пур пураар үүсэх бөгөөд их л эелдэг зантайгаар:”За бүсгүй ээ, ижий чинь хаана вэ?” гэж асуувал, хүүхэн энэ завсар эхээ нэгэнт хуурмагаар өвчлүүлэн хэвтүүлсэн тул “энд байгаа” гэж ламыг дагуулан нөгөө тасалгаанд оруулав. Нэг настай хөгшин хөнжлөөр хучаастай хэвтэж байна. Хоймор нь бяцхан гүнгэрваатай бурхан их л шороо тоосонд дарагдсан үзэгдэнэ. Өмнө нь хятад янзаар хоёр улаан лаа хатган тавьжээ. Түүнээс лам ном уншиж, залбирал даатгал хийснийг өгүүлэх юун. Ном уншиж сая барвал, нэгэнт шөнө орой болжээ. Эх нэлээд сэргэсэн байдалтай ламын аврал гэж залбирна. Хүүхэн нэгэн адил ламд сүсэг төрсөн байдал гаргана. Хажуугаар нь үг хэлэх ба инээн аашлах нь их л бахтай. Хоёр хар нүдээ жирвэгэнүүлэн эргэлдүүлэх бүрд Лодонгийн сэтгэлд бяцхан ширүүн гал ноцон алдана. Хүүхэн нэгэнт энэ байдлыг мэдээд “ламбугай орой болсон тул, манай гэрт хоол зооглоод морилно уу?” гэсэнд лам нэгдүгээрт бяцхан ядарсан ба хоёрдугаарт ном уншсаны хойно хоол идээд явдаг нь лам нарын тогтоосон заншил тул даруй зөвшөөрч нөгөө байшинд хүүхнийг дагалдан оров.

Хүүхэн тогоочоо дуудан, хоол бэлтгүүлж ламыг зочилсноос гадна, энэ үед хүүхний өдөх нь улам улам илүү болж шадарлах нь нэн нэн ойр тулав.

Ийн тийн ярилцсаар, ламын ертөнцийг сайшаах сэтгэл нь улам нэмэгдэж, нэг үдшийн зуур Дуйнхарын аймаг дахь дөрвөн ханатай гэр ба хэдэн гүнгэрваатай бурхнаа мартжээ.

Түүнээс хүүхэн: “өнөө нэгэнт орой болжээ. Бид энд таныг хүргэн өгөх уналгагүйгээс гадна, бас бороо орж байх тул, энэ шөнө энд морилон хоноод, маргааш харивал сайн биш үү” гэсэнд лам хойш нэгэнт зовсон боловч үнэхээр орой болж, бороо орж байгаа ба мөн ч энд баахан зугаатай болох тул, энэ шөнө дороо хонохыг нэгэнт шийдвэрлэв.

Хүүхэн ч баясаж, дэр дэвсгэрийг засав. Тус тусын ор дэвсгэр дээр унтсан хойно, мэдээжийн хэрэг хүүхэн хааяа хааяа зөөлөн ханиаж, ламын нойр үл хүрнэ. Лам хэдийгээр хүүхэнд халдахыг хүсэвч, угаас эхнэр хүүхэнтэй төдий л ихэд холилдсонгүй тул, баахан халширна.

Лам тэсэж ядахдаа шээнэ гэж шалтгаалан босож эргэж ирэхдээ хүүхний өвөрт орьё гэж сэтгэж, гадаа гарч явав. Удалгүй эргэж ирээд, гадна чагнавал, чив чимээгүй, хаалгыг татвал:

“Ламбагуай бяцхан байзнаарай” гэж хүүхэн дуу алдахад лам юу болохыг хүлцэж ядан, долоовор хуруугаа норгож, байшингийн цаасан цонхыг цоолоод, мөн л бяцхан нүхээр ажиглавал, хүүхэн хөнжил дээрээ дотуур хувцсаа тайлж байх нь дэнгийн гэрэлд үнэхээр үзэсгэлэнтэй үзэгдэж, сэтгэлийг хөдөлгөхөд, ламын хоосон чанарын бодлого хэдийнээ нөгөө ертөнцөд шилжиж винайн ёс нэгэнт баруун зууд одоод, тачаангуй гал дүрэлзэн бадрахад орж хүүхний хамт нойрсов.

Түүнээс ертөнцийн хэрэг ламын сэтгэлд тааламжтайг тоочвол барахгүй. Даруй өглөө харьсан боловч, үдэш санагдан эргэж ирсээр, нэгэнт хэд хэдэн сар болж, баруун дамнуурчны ба гандангийн дэнж хоёрын хооронд нэг нарийхан шинэ зам нээгдэв.

Түүнээс Иүй Бай-хуа, Лодонд үнэхээр дурласан бус тул энэ завсар баян гэвшийн буянгаар дэмий л тарвалзсан боловч, бас ханахгүй гэвш Лодон ертөнцийн цаламд нэгэнт урхилагдаж, хүүхэнд автагдаад юу гэвч гажуугүй болсон, яван явсаар лам гандан дахь хашаа байшин ба гавж болохын тул бэлтгэсэн юмаа бүгдийг нийлүүлж, Иүй Бай-хуад гуа сайхан элбэг дэлбэг хашаа байшин төхөөрч хорооны газар хамтран суух болов. Нэг өдөр гэвш Лодон гэртээ ирээд, Байшингийн хаалга татвал, дотроос нь түгжжээ. Цонхны булангийн завсраар нууж үзвэл, Иүй Бай-хуа нэг залуу хар хүүтэй тэврэлдэн сууна. Иүй Бай-хуагийн хуучны зузаан янаг байна гэсэн нь энэ мөн байгаа гэж лам нэгэнт таниад уур нь бадарч занчилдъя гэж байшингийн хаалгыг хэмх цохин орж, хэрүүл шуугиан гаргав. Гэтэл хүүхэн өчүүхэн ч эмээх зовох байдалгүй харин ламд дургүй учрыг хэлж хараан загнаж, хөөн гаргасанд лам заалдъя гэвч хуврагийн ёсоо эвдсэн тул аргагүй гунихран, байшингийн босгыг тэвэрч,

“Хүү минь би чамд хайртай

Одоо би хаана очих вэ? Өөр хүнтэй ханилах хамаагүй,

Гагцхүү намайг бүү орхи” гэж хоёр нүднээсээ ертөнцийн хар нулимсыг борооны дусал адил асгаруулна.

*Translated by Charles Bawden,
2003.*

THE TEARS OF THE REVEREND LAMA

A Modern Short Story

As the Bachelor of Divinity Lodon, who venerated his prayer-wheel and obeyed the Laws of the Discipline, because he saw the turning world as vain, was coming down the gully on this side of the Gandang lamasery, his robes mingling their red and yellow, the girl Tserenkhlan, also known as Yu Baihua, who had mastered the skill of fostering the sharp sword of passion, emerged from a muddy lane in the Chinese Western Pedlars quarter, flashing her eyes, black against white, and they met.

Yu Baihua had run out of opium and was on her way to pawn a gold ring and get a bit of spending money, when she chanced to see that she would run into the Bachelor of Divinity Lodon. She had marked him out some time ago as being a high cleric of mild manners and superficial nature, and quick as a flash she conceived a plan, and went up to the lama, and, putting on a show of distress mingled with confusion, she said: 'Pardon me, Your Reverence, pardon me, but my old mother is ill and likely to die. Would you be good enough to come to our place and recite some prayers?' The lama said: 'I am on my way to service in the Eastern Lamasery. I cannot manage it just now. Ask another lama to come.' But Yu Baihua pretended to be in despair, repeated her sad story, and put her case in every way she could.' He could not help seeing how upset she was, and thinking he might get a good fee he followed the girl towards her house in order to say some prayers.

There was ever so much mud in the five lanes of the Western Pedlars in the summer season, and not even ten thousand packets of incense could have overcome the stench. The Bachelor of Divinity Lodon covered his nose with his scarf and stalked along behind the girl.

Before long they went through a weather-beaten, white gate. The acrid stink of skins in the tanning-vats assailed them, and bits of fur and hair flying in the wind stuck to their clothes.

Passing through a narrow way between two tumbledown mud huts, they went into an east-facing cave-like building on the western side. The girl had the lama seat himself on a chair and went out, saying: 'I'll get some tea.' While she was out of the way, the lama looked around him. In the front part of the house there was a big bed. The bedclothes were stowed away tidily and covered with a spotted bedspread. In the rear part there was a small four-sided table covered with a white cloth, and on it a big clock and a few pictures.

The roof of the house was very low. When the Bachelor of Divinity Lodon stood upright his head almost touched it. A little window was pasted over with two layers of Chinese paper and decorated with patterns in red paper. It was still daytime, but it felt like twilight in the house. Someone had made a little hole in the corner of the window, no doubt so that they could see who was going in and out.

The girl soon came in again and gave him a cup of tea, and begged him to look mercifully on them and to heal her mother. The lama looked at the girl. Outside, in the sunlight, her face had looked weather-worn and colourless, but now that she had come inside her cheeks were gleaming red, and she shone as splendidly as the image of the Goddess Dar Ekh whom he worshipped every morning. At this the mist of worldly desire began to swirl up in his mind, and he said in gentle tones: 'Well, my dear, where is your mother?' Meanwhile the girl had got her mother to lie down and pretend to be ill, and she said: 'Here she is', and led the lama into the other room. An old woman was lying there, covered with a blanket. In the back part of the room could be seen a Buddha-statue in a frame, covered with the dust of ages. Two red candles were set on spikes before it, in Chinese fashion. We do not need to go into how the lama then recited the scriptures and recited his prayers. By the time he had finished his recitation, night had already fallen. The mother looked much restored, and confessed that it was due to the lama's help. The girl also pretended to profess her devotion to the lama. She chatted and laughed with him ever so pleasantly. Each time she flirted with her two black eyes, a fierce little flame sparked and flared in Lodon's heart. No sooner had the girl observed this than she said: 'Your Reverence, it has got late. Won't you stop and have a meal with us?' For one thing, the lama was a bit tired, and for another it was the usual thing for a lama to eat after reciting the scriptures, so he accepted at once and followed the girl into another building.

The girl called the cook and had the meal prepared, and while waiting on the lama she began to make up to him and get as cosy with him as she could.

They chatted about this and that, and the lama saw the world in a much more positive light, and within the space of an evening he forgot all about his four-section tent in the Duinkhar Quarter with its several framed Buddhas.

Then the girl said: 'It has got quite late. We have no conveyance to get you home, and besides that it is raining. Why don't you spend the night here and go home tomorrow?' The lama was a bit embarrassed, but as a matter of fact it was late, and it was raining, and it was quite jolly where he was, so he decided to spend the night there.

The girl was delighted, and made up the bed. After they had gone to their separate beds, it was only natural that the girl should give a slight cough now and again, and that the lama was not able to get to sleep. The lama wanted to try his luck with the girl, but as he had not had much experience of traffic with women, he rather fumbled it.

The lama could not bear it any longer, and he planned to go out on the pretext of making water and get into the girl's bed on the way back, and out he went. He soon came back and listened from outside. All was silence, and he opened the door. The girl called out: 'Half a minute, Your Reverence.' Unable to contain himself, he wetted his

forefinger and made a little hole in the window of the building. Looking in through this little hole he could see the girl taking off her underclothes on the blanket. She looked really pretty in the light of the lamp, and it made him excited. The lama's ideas about The Void had long since migrated to another world, and the Laws of the Discipline had by now fled to Lhasa. Up blazed the fire of lust, and he went in and slept with the girl.

From then on, nothing delighted the lama's heart more than the things of this world. He went straight home in the mornings, but would come back longing for evening, and several months went by, and a new little pathway opened between the Western Pedlars and the Gandang Terrace.

Now Yu Baihua was not really in love with Lodon, and as time went on she just exploited the generosity of the rich Bachelor of Divinity, while the unsated Lodon became ensnared in the noose of the world and infatuated by the girl, and to cut a long story short, gradually he capitalized his compound and house in Gandang and all things he had put by for taking the degree of Doctor, and fitted out a luxurious compound and house for Yu Baihua, and they began to live together in the secular district.

One day the Bachelor of Divinity Lodon came to the house, but when he tried to open the gate he found it locked. When he looked furtively in through a gap in the window, there was Yu Baihua in the embrace of a young layman. The lama realized that this was an old lover whom Yu Baihua had spoken of, and he flew into a temper and smashed the house-door open, and went in to beat him up, and kicked up a row. But the girl was not taken aback in the least, and she cursed him and scolded him, saying that she hated him, and she threw him out. The lama would have brought a case against her, but he had broken his religious vows, and there was nothing for it but to cling to the threshold of the house and lament:

‘My dear, I love you.

Where shall I go now?

You can go with someone else,

But don't reject me.’

And he shed bitter worldly tears, which dropped from his eyes like rain.

Translated by De. Natsagdorj, 1976.

TEARS OF A VENERABLE LAMA

When Father lama Lodon a master of the vinaya, who was wearing a yellow gown and a red robe, and was meditating on the fact that the world was empty, went down the eastern terrace of Gandan, he came across miss Tserenlhama, an experienced girl who was wearing shining white and black and who had just come out of the western street of Chinese Porters.

Miss Tserenlhama was about to sell a gold ring for some tugrigs for she was in need of money, and on meeting Father Lama Lodon by chance, an idea came into her mind like lightning. She already knew from experience that lamas were kind-hearted and easily led, and besides, she was told that Father Lodon was a wealthy monk. So she went straight towards him with anxiety in her face and said:

-Venerable Lama! Have mercy on us. My old mother has fallen ill and expecting to die. Be so kind as to visit her place and bestow your protection upon her.

-I am going to an important rite in the East Monastery. I am sorry, this time I'm unable to come. Go to another lama who lives nearby, he said, but he observed miss Tserenlhama standing there, panic-stricken.

Greatly worried she begged him again and again to pray over her mother. In the end he yielded to her and started walking majestically to her home, following her. He thought that he would receive substantial remuneration, for the girl seemed to be greatly alarmed.

Soon they entered a weather-bitten white gate. Passing through a narrow corridor between mud houses they went into a dark burrow-like house which was on the right facing east, and she, offering a chair to the lama, went out the house saying that she would bring "a cup of tea". In the meantime the lama looked round the room. There was a big bed along the front wall of the house. The bed was neatly made and covered with patterned chints. There was a small square table covered with white cloth at the opposite wall of the house. On the table there was a big clock and several pictures. The ceiling of the house seemed so low that if the Father Lodon stood up, he thought he would knock his head. A small window was sealed with two layers of soft Chinese paper decorated with spiral patterns cut of red paper. Although it was daytime, in the house it was very dim. A tiny hole made at a corner of the window and through it she would probably watch the visitors who came in and out.

Presently the girl came back and after giving him a cup of tea, she pleaded.

"Benevolent Lama, be so kind as to use your holy power and bless to cure mother"
The lama gave a careful look in the girl's direction.

When she was outside she had seemed very pale and colorless in the light of the sun. But when she came inside, her two cheeks seemed to burn pinkly, and she glowed just like the image of the White Tara to which lama prayed every morning. And a haze of sinful worldly thoughts began to rise in the lama's mind.

When the Father asked mildly: "Well, my girl, where is your mother?" The girl had already put her mother into bed pretending to be ill and she could say "she is here". So she led the lama into the next room. An old woman was in bed covered with a blanket. On an altar in the front part of the room there was a small flamed icons of Buddhas covered in dust. In front of it there were two red candles arranged in the Chinese manner.

Hardly had the lama finished chanting and paying homage to protective spirits, when it already became dark. The mother, somewhat revived, was praying, saying her recovery was due to the Venerable Lama's help. The girl who also gave the appearance of believing in the lama's power. Apart from that, the girl's ways of speaking and laughing were charming. Every time she flashed her shining black eyes, a tiny spark almost caught fire in Father Lodon's mind. The girl already understood this state of affairs.

Reverent lama, it is already night. Please have supper with us before you go, she said.

Firstly the lama was a little tired and secondly it is an established tradition that lamas are offered a meal after chanting prayers, so the lama immediately agreed and followed the girl into the next room. The girl summoned her servant to prepare the meal. She served the lama, and at the same time she became more and more provocative and constantly flinging ambiguous worlds in his direction.

They talked about this and that, and the lama increasingly praised the monastic way of life, but in just one evening he had completely forgotten his four-walled ger in Duinkhar district with its framed steamed statues of Buddhas. The girl said: "We have no transport to take you back, and besides it is raining. Would you do us the honor of spending the night here and go back tomorrow?" The lama, though he hesitated for a moment, could see that it was really late and that it was truly raining, and that it would be more amusing here, and therefore he decided that he would stay the night. The girl was delighted and she made up a bed for him.

After they had got into respective beds the girl naturally began to cough softly. The lama could not sleep. However, although the lama wanted to touch the girl, since reaching manhood he had hardly ever mixed with woman and girls, and therefore he was discouraged. Unable to endure this, he got up and went out under pretence of going for a walk in the fresh air with the intention of making love to the girl when he returned. Soon coming back to the house he strained his ears but there was silence. When he pulled at the door the girl uttered a sound and cried out "Reverent lama wait a bit". The lama lost his patience, wetted his index finger and made a small hole in the Chinese paper window. When he looked through the tiny hole, the girl was undressing and taking off her underclothes; it was an enchanting sight. The lama was very excited; his

lama's dogma of emptiness was consigned to the other world and the doctrines of the Vinaya had flown back to the Western Zuu. He was consumed with the fire of lust and hurriedly entering the room he went to sleep with the girl.

It is impossible to describe the welcome of worldly things, which took place in the Father lama's after that time. Although he used to go home as soon as morning broke, by evening he used to return, and so by the time several months had passed, a new path had already been worn between Gandan Monastery hill and the Western Street of Chinese porters. Meanwhile Tserenlhama greatly enjoyed herself on the proceeds of the wealthy lama.

The reverent lama gathered together his house in Gandan and all the things he had prepared for the degree of Gabji, -degree of doctor of Buddhist philosophy, and he used them to build a spacious house with a big yard for Tserenlhama. Not long after this Father Lodon one day came to the girl's place, and when he tried the door, it was holted. When he squinted through the slit at the corner of the window, he saw Tserenlhama sitting enjoying the embrace of a young layman. As soon as a lama found out that Tserenlhama's old devotion had turned to his, he flew into a rage and breaking down the door of the building he entered and threatening to hit the young man, created a great row.

However the girl, without the slightest fear, told the Lama why she did not love him. Cursing and threatening him, she drove him out. The lama wanted to sue her, but as had broken his holy priesthood vows this was impossible and he had no way out. Then lying in distress at the eshold of the house, he pleaded



My own girl, I love you

Now, where shall I go?



It doesn't matter if you have another man

Only don't abandon me.

When he said this, bitter worldly tears ran like rain drops down from his two eyes.



МЭДЭЭ



ОРЧУУЛГАЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИХ СЕМИНАР БОЛОВ

Нэгдсэн Үндэстний байгууллагаас 2019 оныг уугуул үндэстний хэл соёлыг хамгаалах жил болгон зарласантай холбоотойгоор энэ оны “Дэлхийн Орчуулгын өдөр”-ийг “Орчуулга ба Уугуул үндэстний хэл соёл” сэдвийн дор тэмдэглэлээ. МУИС-ийн ШУС-ийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Гадаад хэлний орчуулга хөтөлбөр, Орчуулгазүйн Профессорын багаас “Нутгийн аман аялгуу судлал ба орчуулгазүй” эрдэм шинжилгээний их семинар зохион байгуулав.

Семинар 2019 оны 9 дүгээр сарын 26-нд МУИС-ийн Хичээлийн 2-р байрны 439 тоот өрөөнд 15.00 цагаас боллоо.

Их семинарыг МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Орчуулгазүйн Профессорын багаас доктор Ш.Эгшиг, МУГБ доктор Л.Маналжав нар хөтлөн явуулав. Семинарт доорхи судлаач нар нутгийн аялгууны талаар илтгэсэн юм.

1. “Монголын нутгийн аялгуу судлалын тойм” М.Очирцэнд ШУА, Хэл Зохиолын хүрээлэн
2. “Судрын орчуулга ба нутгийн хэл аялгуу” профессор Д.Бүрнээ (МУИС)
3. “Хятадын нутгийн аялгуу ба хойд нутгийнхны хэл яриа” доктор Ш.Эгшиг (МУИС)
4. “Дээд монголчуудын эх хэлээ сэргээн хамгаалж буй тухай” Б.Барс (МУИС)
5. “Орчуулга ба Алшаа аялгуу” Б.Яруу (МУИС)
6. “Цахар аман аялгууны өнөөгийн байдал” Т.Урлаг (МУИС)
7. “Барга аман аялгууны онцлог” Д.Содон (МУИС)

Хэлэлцүүлэг

МУИС-ийн докторант Э.Бумбилэг сэдэвт ажлын танилцуулга хийж хэлэлцүүлэв.

МУИС-ийн ШУС, Хүмүүнлэгийн ухааны салбарын
Гадаад хэлний орчуулга хөтөлбөр,
Орчуулгазүйн Профессорын баг



ОРЧУУЛГЫН ОНОЛ, ТУРШЛАГА



ОРЧУУЛГАЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НАЙМДУГААР ЦАХИМ БАГА ХУРАЛ

Монгол Улсын Их Сургууль (МУИС)

Улаанбаатар
2020.04.10

Хурлын нээлт: Д.Заяабаатар , МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн захирал Хурлыг удирдан хөтлөх: Ш.Эгшиг , МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Орчуулгазүйн Профессорын баг		
1.	<i>Их гүүш Ц.Дамдинсүрэн абугайн орчуулгыг хэн “ойлгомжтой болгон сайжруулав”?</i>	С.Эрдэнэмаам профессор, МУБИС, Орос хэл, аргазүйн тэнхим
2.	<i>Эрдэм шинжилгээний орчуулга хийсэн туршлагаас</i>	Д.Бүрнээ профессор, МУИС, ШУС, ХУС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим
3.	<i>Д.Нацагдоржийн “Ламбугайн нулимс” зохиолын англи хэлээрх хоёр орчуулгын эргэцүүлэл</i>	С.Дугармаа профессор, М.Нямдолгор докторант ШУТИС, ГХС, Англи хэл судлалын тэнхим
4.	<i>Хэлний материалын сан (CL) -д суурилан өгүүлэмжид шүүмж шинжилгээ (CDA) хийх тухайд</i>	Ш.Эгшиг (Ph.D) МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим
5.	<i>Герман хэлний өвөрмөц хэлцийг гарал үүслээр нь тайлбарлах нь</i>	А.Цэрэнчулуун докторант, МУИС
6.	<i>“Орчуулгын аргазүй, дискурс анализ: Улс төрийн текстэд ашиглах нь”</i>	О.Мөнхчимэг докторант, ХУИС
7.	<i>“Солонгос түмнийг тольдохуй, Солонгос хайр сэтгэл”: Ц.Баярмаагийн орчуулгад хийсэн шүүмж</i>	Г.Эрдэнэчимэг (Ph.D) МУИС, ШУС, ХУС, Ази судлалын тэнхим
8.	<i>Монгол хэлнээс англи хэлнээ орчуулах “Орчил” хэмээх нэгэн загварыг ашиглах нь</i>	Т.Мягмарсүрэн (Ph.D) ОУУБИС, Англи хэлний тэнхим
9.	<i>Considering Cultural Issues in Metaphor Translation</i>	Ч.Золзаяа (Ph.D), Э.Дэлгэрмөрөн (MA) ШУТИС, ГХС, Англи хэл судлалын тэнхим
10.	<i>“Өвгөн шувуу” өгүүллэгийн англи орчуулгад хийсэн өгүүлбэрийн мэдээллийн бүтцийн анализ</i>	Б.Удвал докторант МУИС, Завхан сургууль
11.	<i>“Аман орчуулга хичээлийн хөтөлбөрт дараалсан орчуулгын аргачлалыг түсгах нь”</i>	Ш.Сэрчмаа (Ph.D) ОУУБИС, Англи хэлний тэнхим
12.	<i>“Мэргэжлийн Англи – Монгол хэлний толь бичиг боловсруулах асуудалд”</i>	Л.Энхмэнд магистр МУИС, ШУС, ХУС, ГХТ
13.	<i>Монгол хэлний хэмжилзүйн нэр томъёог орчуулгазүйн үүднээс судлах нь</i>	Н.Ууганцэцэг магистр ОУУБИС, Англи хэлний тэнхим

МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн Профессорын баг 2012©

Цахим шуудан: ghssorchuulgazui@yahoo.com

ОРЧУУЛГАЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ НАЙМДУГААР ЦАХИМ БАГА ХУРАЛ БОЛЛОО


2012 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Орчуулгазүйн Профессорын багаас уламжлал болгон зохион байгуулдаг Орчуулгазүйн эрдэм шинжилгээний бага хурал энэ жил 8 дахь удаагаа “Орчуулгын онол, туршлага” сэдэвтэйгээр цахим орчинд амжилттай зохион байгуулагдлаа.

2020 оны 4 сарын 10-нд болсон энэхүү цахим хуралд МУИС, МУБИС, ШУТИС, ХУИС, ОУУБИС-ийн эрдэмтэн судлаачдын 13 илтгэл хэлэлцүүлснээс гадна орчуулгазүйн судалгаа шинжилгээ хийдэг манай нэрт эрдэмтэн орчуулагч нар болох Л.Маналжав, Ц.Магсар, Л.Чулуунбаатар, М.Чимэдцэеэ, Д.Отгонтуяа, Г.Элдэв-Очир, Ц.Онон, Ц.Оюунсүрэн, Н.Мөнх, Б.Пүрэвсүрэн мөн Япон улсаас доктор Г.Сайнбаяр, Австралийн орчуулагч судлаач Грегори Прингл (Gregory Pringle) нар цахим хурлын хэлэлцүүлэгт оролцлоо.

Дэлхий нийтээр тархсан “Ковид 19” цар тахлын улмаас улс оронд мөрдөж буй журмын дагуу олон нийтийн арга хэмжээг танхимд зохион байгуулах боломжгүй үед цахим хэлбэрээр хурлаа хийж, хэлэлцүүлэг өрнүүлсэн нь цаг үеэ олсон ажил боллоо.

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

“МАРКО ПОЛОГИЙН АЯЛАЛ” номын тухай



Эртний итали хэлнээс орчуулж, тайлбар хийсэн:

МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Европ судлалын тэнхимийн багш, Г. Бат-Учрал,


Бүгд Найрамдах Итали Улсын Венецийн Ка Фоскари их сургуулийн профессор, монголч эрдэмтэн Элизабетта Рагагнин

Марко Поло судлаач Самүэла Симион

Эрхлэн гаргасан: МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн

Марко Пологийн аяллын тэмдэглэлийн үндсэн эх уламжилж ирээгүй хэдий ч латин хэл, эртний франц-итали хэл, венец аялгууны зуу гаруй хувилбарыг харьцуулан гаргасан Рамузиогийн хэвлэл хэмээх сонгодог эхэд тулгуурлан орчуулсан байна. Энэ нь Венецийн Ка Фоскари их сургуулийн Марко Поло судлаачдын сүүлийн 15 гаруй жилийн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн нэг хэсэг болох “Дижитал Рамузио” төслийн үр дүн бөгөөд Марко Пологийн аяллын тэмдэглэлийн талаар хамгийн өргөн мэдээллийг агуулсан гол эх юм.

“ТУУЖИС - 3” номын тухай



Хятад хэлнээс орчуулсан: Б.Гэрлээ

Бидний мөнхийн хөрш Хятад улсын бичиг соёл даруй гурван мянганы түүхтэй билээ. Хэл бичгийн арвин баялаг өвтэй энэ улсын нэн шинэ үеийн түүхэнд уран зохиолын хоёр том шагнал бий болсон нь алдартай зохиолч Мао Дунийн нэрэмжит, нөгөө нь орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Лу Синий нэрэмжит шагнал юм. Мао Дунийн шагналыг дөрвөн жилд нэг удаа шилдэг романд олгодог бол Лу Синий шагналыг мөн төдий хугацаанд туурвисан шилдэг тууж, богино өгүүллэгийг шилж сонгон олгодог уламжлалтай. Энэ түүвэрт Лу Синий нэрэмжит шагнал хүртсэн үе үеийн өгүүллэг, туужаас гадна гадаад, дотоодын уншигчдын таашаалд нийцсэн, Хятадын орчин үеийн уран зохиолын нүүр царай болсон нэртэй зохиолчдын бүтээлүүдээс сорчлон орууллаа.

Түүвэрт Хятадын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Лу Синь, XX зууны арвин их бүтээлтэй эрхэм нэгэн гэгдсэн Шэнь Цунвэнь, тэнгэрийн доорх сүүлчийн эрдэмт хүмүүн Ван Цэнци, Францын иргэн болоод 2 жилийн дараа 2000 онд Нобелийн шагнал хүртсэн Гао Синзянь, найруулагч Эн Лигийн кино хальсанд буулгасан Жан Айлиний “Хүсэл хясал”, Лу Синий нэрэмжит шагналт, залуу зохиолчдын төлөөлөл Сяо Зянхун, уран зөгнөлт зохиол бүтээлээрээ нэрд гарч буй Лю Цысинь, богино өгүүллэгийн залуу мастер, мөн ялгаагүй Лу Синий шагналт Жан Чү, өнөөгийн нийгэм дэх эмэгтэйчүүдийн ээдрээт тавиланг өгүүлсэн зохиол бичдгээрээ нэртэй Цяо Е, цөөн хэдэн өгүүллэг бичсэн ч тэр бүр нь өрнө, дорнын уншигч, шүүмжлэгчдийн талархлыг хүлээсэн Сюэ Мо, Азийн шилдэг зохиолчдод олгодог Man Asian Literary Prize шагналт Хятадын алдартай зохиолч Су Тун зэрэг арав гаруй зохиолчдын хориод тууж өгүүллэг багтжээ.

Энэ дундаа зохиолч Шэнь Цунвэнийн “Боомт хот” тууж гэхэд XX зуунд бичигдсэн Хятадын шилдэг зуун зохиолын 2-т жагссан бүтээл билээ. Энэ жагсаалтыг Хятадын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Лу Синий “Уухай” өгүүллэгийн түүвэр тэргүүлдэг. 1931 онд уншигчдад хүрсэн энэ зохиолд XX зууны эхэн үеийн Хятадын эгэл жирийн хүмүүсийн аж байдал, хайр сэтгэлийн тухай өгүүлдэг энэ туужаар 1985 онд бүрэн хэмжээний кино хийсэн байдаг.

“ДЭЛХИЙН ТҮҮХИЙГ ӨӨРЧИЛСӨН ТУЛАЛДААНУУД” номын тухай



Англи хэлнээс орчуулсан: Д.Хүрэлхүү

Эрт балар цагаас цөмийн эрин үе хүртэлх түүхэнд цуутай 90 гаруй тулааны тухай өгүүлэх онц сонирхолтой, зурагт гарын авлага юм. Энэ номд газрын зураг, уран зураг, эд өлгийн дурсгал, гэрэл зургаар дамжуулан эрин үеийн гол тулалдаануудыг дүрслэн харуулж, тактикийн чухал шийдвэрүүд түүхийн хүрдийг хэрхэн өөрчилснийг үзүүлжээ.

Дэлхийн түүхийг хэдэн тулалдаан өөрчилсөн бэ? Энэ бол тун сонирхолтой асуулт. Жишээ нь, бид өнө эрт цагт болсон тулааны талбар дахь цэргүүдийн байлдааны жагсаалын тухай уншихдаа өнөө үед хамаатай зэвсэгт мөргөлдөөн гэхээсээ илүү

зүгээр л сониуч зангийнхаа үүднээс хандах нь олонтаа билээ.

Гэвч үнэндээ түүхэн тулалдаануудын үр дүнд улс орон, эзэнт гүрэн, соёл иргэншил бий болж, тэдгээрээс бидний өвөг дээдсийн амь амьдрал шалтгаалж, өнөөгийн та бидний үе хүрч иржээ. Европ тивд дайтагч улсуудын үнсэн нурам дундаас шинэ үндэстнүүд төрж байсан бол Дорнын элчилгүй цөл, цавчим уулсын дунд эртний сөргөлдөгч гүрнүүд хилээ тогтоож, соёлоо цогцлоосон нь тэр газарт оршин суугчдын амьдралд одоо ч нөлөөлсөөр байна. Евразийн их дайдад Чингис хааны үндэслэн байгуулсан Монголын Эзэнт гүрэн дэлхийн түүхийн урсгалыг эгнэгт өөрчилж орхисон билээ. Өмнөд Америкийн үндсэн хэл испани болсон нь Кортэс Ацтэкийн нийслэл Тэночтитланыг эзлэснээс улбаатай бол өнөөгийн АНУ-ын улс төр, соёлын өв нь голчлон Америкийн Тусгаар тогтнолын дайн болон Иргэний дайны үр дагавар билээ. Арай ойрын жишээ татвал Хүйтэн дайны үед хөшигний ард болж байсан хэлэлцээрүүд орчин үеийн геополитик ба цэргийн урлагт онцгой нөлөө үзүүлжээ.

Гэхдээ энэ номд зөвхөн тулалдаанаар дамжуулан түүхийн чухал үйл явдлуудыг өгүүлэхийг гол болгосонгүй. Тулалдаан бүр тухайн үеийнхээ улс төр, соёл болоод ард түмний уур хилэн, зовлон шаналал, байлдагч талуудын зэвсэг, хэрэглэл, улс төр, цэргийн зүтгэлтнүүдийн шийдвэрүүдийн тусгал байдаг билээ. Хэдий эл ном дэлхийн түүхэнд болж өнгөрсөн бүх дайн тулааны бүрэн түүвэр, эс бөгөөс цэргийн урлагийн гарын авлага биш байж болох ч тулалдааныг өргөн өнцгөөс харуулахын сацуу хоромхон зуурт түүхийн хүрд хэрхэн эргэж болдгийг зурвасхан ч үзүүлэх зорилго тавьсан болно.

Уншигч та бидний хувьд түүхэн үйл явдлууд гэдэг улиран одсон он жилүүдийн тэртээх цуурай, уншиж таашаах нэгэн зүйл мөн боловч тэдгээрийн ард ямар их золиос гарсныг мартах учиргүй. Дайны түүх гэдэг ганц цэрэг эрсийн хатан зоригоор бус асар олон хүний амиар бичигддэг бөгөөд хүн төрөлхтөн эдгээрээс ч аймшигтай эмгэнэлтэй явдал гарахаас урьдчилан сэрэмжлэхийн тулд өнгөрсөн түүхийг эргэн харж байна.

МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн “ОРЧУУЛГАЗҮЙ” сэтгүүл

Сэтгүүлийн нэр: Орчуулгазүй (Translation Studies)

Сэтгүүлийг эрхлэх байгууллага: МУИС, ШУС, Орчуулгазүйн профессорын баг

Сэтгүүлийг анх эрхлэн гаргасан он: 2013

Олон улсын стандарт дугаар: ISSN: 2313-6170

Сэтгүүлийн товч танилцуулга: “Орчуулгазүй” сэтгүүл нь хэлшинжлэлийн салбар ухаан болох орчуулга судлалын сэтгүүл юм. Жилд нэг удаа монгол, англи хэлээр, товч агуулга нь англи болон бусад хэлээр гардаг. Сэтгүүлийн бодлого бол Монгол Улс дахь орчуулгазүйн чиг хандлагыг тодорхойлж, тулгамдаж буй асуудлыг шийдэх эрдмийн индэр болох явдал юм. Сэтгүүлийн ариутган шүүх зөвлөлд манай улсын орчуулгазүйн нэрт эрдэмтдээс гадна, ОХУ, Франц, Япон, БНХАУ-ын орчуулга судлаач, монголч эрдэмтэд ажилладаг.

Сэтгүүлийн зорилго: Сэтгүүлийн бодлогын хүрээнд орчуулгазүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг дээшлүүлэх, судалгааны ажлын үр дүнг нийтийн хүртээл болгон судалгааны эргэлтэд оруулах зорилготой.

Сэтгүүлд тусгах судалгааны чиглэл: Хэлшинжлэл, орчуулгазүй

- Бүтээлийн төрөл:
1. Эрдэм шинжилгээний өгүүлэл
 2. Эрдэм шинжилгээний орчуулга
 3. Орчуулгын шүүмж
 4. Мэдээ, нийтлэл

Хэвлүүлэх өгүүлэл, мэдээллийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр доорхи техник шаардлагын дагуу бэлдсэнээр хүлээн авна. Холбоо барих болон өгүүллийг хүлээн авах цахим хаяг: ghssorchuulgazui@yahoo.com

Эрдэм шинжилгээний өгүүллийн бүтэц, хэлбэрт тавих техник шаардлага

1. **Бүтэц:** Өгүүллийн нэр, зохиогчийн мэдээлэл, товч агуулга /англи хэлээр/, түлхүүр үг, үндсэн өгүүлэл /удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт/, номзүй
2. **Өгүүллийн нэр:** Монгол, англи хэлээр, том үсгээр бичнэ.
3. **Сэтгүүлийн албан ёсны хэл:** Монгол, англи (өгүүлэл), англи, орос болон бусад (өгүүллийн товч агуулга)
4. **Зохиогчийн мэдээлэл:** Сэдвийн доор зохиогчийн нэрийг овгийн эхний үсгийн хамт бичиж¹ гэж дугаарлаад эхний нүүрний доод хэсэгт харьяалагдах байгууллагын нэр, зохиогчийн эрдмийн зэрэг, цолыг бичих ба бусад албан тушаал, цол, гавьяа шагналыг бичихгүй. Олон зохиогчтой тохиолдолд нэр бүрийг тоон тэмдэгтээр ялган тэмдэглэнэ. Зохиогч бүр өөрийн нэрийг мөн англи үсгээр бичиж ирүүлнэ. /*Доктор Ph.D, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим /
5. **Өгүүллийн товч агуулга:** Өгүүллийн агуулгыг товчлон 100-150 үгэнд багтаан англи болон бусад гадаад хэлээр бичнэ. Өгүүлэл гадаад хэлээр бичигдсэн бол товч агуулгыг монгол хэлээр бичнэ.

6. **Түлхүүр үг:** 5-8 түлхүүр үг хэрэглэнэ. Түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоон дээр байна.
7. **Эшлэл:** Эшлэл авсан хэсгийн ард дугуй хаалтанд уг бүтээлийн зохиогчийн нэр, хэвлэгдсэн он, эшлэл авсан хэсгийн хуудасны дугаарыг бичнэ. Жишээ нь: (Ц.Шагдарсүрэн, 1991:37-43)
7. **Номзүй:** Номзүйд орсон бүтээлийг монгол хэлээр, гадаад хэлээр, цахим эх сурвалж гэсэн дарааллаар жагсааж дугаарлана.
- А. Өгүүллийн төгсгөлд зөвхөн эшлэл авсан ном, зохиолын нэрсийг зохиогчийн нэрийн цагаан толгойн дэс дарааллаар бичнэ. Жишээлбэл, Шагдарсүрэн Ц.(1991), Монголчуудын утга соёлын товчоон, УБ. Шинжлэх ухааны хэвлэлийн “Эрдэм” пүүс.
- Б. Эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлээс эшлэл авсан бол зохиогчийн овог, нэр, өгүүллийн бүтэн нэр, өгүүлэл хэвлэгдсэн эмхэтгэл, сэтгүүл, ном, сонины нэр, хэвлэгдсэн он, дугаарыг бичнэ. Жишээлбэл: Магсар Ц., *Яруу найргийн орчуулгын уран чанарын тухайд*, “Орчуулгазүй” МУИС, ШУС-ийн ЭШБ, 2015 № 4 (422).
- В. Цахим сүлжээнээс болон компакт дискээс авч хэрэглэсэн ном, сонин, сэтгүүл зэрэг эх сурвалжийг дараалуулахдаа ердийн эх сурвалжтай адил зарчим баримтлах буюу овог, нэр, гарчгийн эхний үг зэргийн цагаан толгойн дарааллыг харгалзана. Ямар ч тохиолдолд дан ганц сүлжээний хаяг хэрэглэж болохгүй.
8. **Цаасны хэмжээ:** А4 (210mm x 297mm) хэмжээтэй 8-15 нүүр
9. **Үсгийн фонт:** Үндсэн өгүүлэл Times New Roman regular, өгүүллийн хураангуй Times New Roman *italic*
10. **Үсгийн өндөр:** Гарчиг 14pt; зохиогчийн нэр, хураангуй 10pt, *italic*; ерөнхий агуулга, хүснэгтийн тайлбар, агуулга нь 11pt өндөртэй үсгээр бичигдсэн байна. График, диаграмм, зургийн тайлбарыг 9pt өндөртэй үсгээр бичнэ.
11. **Ашигтай талбайн хэмжээ (margins):** Top 2 см, Bottom 2 см, Right 2 см, Left 2 см; мөрүүд нь баруун, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ. Header цэс ашиглахгүй, хуудасны дугаар тавихгүй, мөр хоорондын зай 1 байна.
12. **Tab (догол мөр):** Өгүүллийн хураангуй болон түлхүүр үг нийтдээ нэг tab/догол мөр зайд бичигдэнэ.

Жич: Докторант эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлэх тохиолдолд эрдэм шинжилгээний удирдагчийн зөвшөөрөлтэй байна.

“ОРЧУУЛГАЗҮЙ” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ
МУИС, ШУС, ХУС, Орчуулгазүйн Профессорын баг 2012©